**МОНГОЛ УЛСЫН**
**ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ**

**БААТАРЫН МӨНХБАТ**

# ХИЛИЙН ЗУРВАС ДАХЬ ЧӨЛӨӨТ БҮСИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТОГТОЛЦОО

**Улаанбаатар хот**
**2023 он**

**МОНГОЛ УЛСЫН**
**ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ**

# ХИЛИЙН ЗУРВАС ДАХЬ ЧӨЛӨӨТ БҮСИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТОГТОЛЦОО

**(Судалгааны тайлан)**

**Улаанбаатар хот**
**2023 он**

ТОВЬЁОГ


| | | |
|---|---|---|
| Өмнөх үг | | 5 |
| Товчилсон үгийн жагсаалт | | 6 |
| Зураг, хүснэгтийн жагсаалт | | 7 |
| Нэр томьёоны тайлбар | | 8-9 |
| Удиртгал | | 10-16 |
| НЭГ. ГАДААДЫН УЛС ОРНУУДЫН ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ БҮСИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ | | |
| 1.1. | БНХАУ-ын чөлөөт худалдааны бүсийн үүсэл хөгжил, онол, практикийн асуудал | 17-37 |
| 1.2. | ОХУ-ын эдийн засгийн тусгай бүсийн үүсэл хөгжил, онол, практикийн асуудал | 38-50 |
| 1.3. | Дэлхийн зарим улс орнуудын эдийн засгийн чөлөөт бүсүүдийн харьцуулсан судалгаа, практик жишээ | 51-61 |
| ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА | | |
| 2.1. | Замын-Үүдийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн өнөөгийн байдал | 62-78 |
| 2.2. | ”Алтанбулаг” эдийн засгийн чөлөөт бүсийн өнөөгийн байдал | 79-86 |
| 2.3. | Цагааннуур эдийн засгийн чөлөөт бүсийн өнөөгийн байдал | 87-89 |
| ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХАМГААЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ | | |
| 3.1. | Монгол Улсын эдийн засгийн чөлөөт бүсийн хамгаалалт, аюулгүй байдлын асуудал | 90-96 |
| 3.2. | Монгол Улсын чөлөөт бүсийн хөгжилд тулгамдсан зарим асуудал | 97-103 |
| ТӨГСГӨЛ ХЭСЭГ | | |
| 4.1. | Нэгдсэн дүгнэлт | 104-107 |
| 4.2. | Санал зөвлөмж | 108 |
| ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ | | 109 |
| ХАВСРАЛТ | | 110-134 |

## “ХИЛИЙН ЗУРВАС ДАХЬ ЧӨЛӨӨТ БҮСИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТОГТОЛЦОО”

## СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН


**Судалгааны багийн ахлагч:**

Ч.Сайнтөр — Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын төвийн захирал, хил судлалын ухааны доктор (Ph.D), бригадын генерал

**Судалгааны багийн гишүүн:**

Ц.Ганболд — Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, цэргийн ухааны доктор (Ph.D), профессор, хурандаа

**Судлаач:**

Б.Мөнхбат — Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын төвийн өдрийн докторант, дэд хурандаа

# ӨМНӨХ ҮГ

Дотоод хэргийн их сургуулийн Хилийн аюулгүй байдал судлалын профессорын судалгааны баг байгуулагдсан цагаасаа эхлэн эрдэм шинжилгээ, сургэлт, судалгааны ажлыг амжилттай гүйцэтгэж ирсэн билээ.

Энэ удаагийн судалгааны ажил нь хилийн зурвас дахь чөлөөт бүсийн аюулгүй байдлын тогтолцоог боловсронгуй болгох асуудлын хүрээнд олон улсын болон хил залгаа улс орнуудын чөлөөт бүсүүдийн түүхэн замнал, үүсэл хөгжлийг судлах, чөлөөт бүс хөгжсөнөөр улс орон, ард иргэдэд ямар сөрөг нөлөөлөл, үр дагаварууд бий болох талаар шинжлэх ухааны үүднээс суурь судалгааны түвшинд судаллаа.

Монгол Улсад Эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдах улс төрийн шийдвэр гарснаас хойш 30 гаран жилийн хугацаа өнгөрч байгаа ч чөлөөт бүсийн хамгаалалт, аюулгүй байдлын талаар онол, арга зүйн түвшинд судалсан дорвитой бүтээл байхгүй байна.

Тус судалгааны ажлын сэдвийг Хил судлалын профессорын судалгааны багийн 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр тухайн сэдвийг зайлшгүй судлах шаардлага бий болж байна гэж дүгнэн, Дотоод хэргийн их сургуулийн Тэргүүн дэд бөгөөд Сургалт, эрдэм шинжилгээний газрын захирлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн “Судалгааны ажлын сэдэв, эрдэм шинжилгээний ажлын удирдагч томилох тухай“ А/133 дугаар тушаалаар баталгаажуулж, тус сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2023 оны үндсэн арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2022 оны 05 дугаар сард чөлөөт бүсийн одоогийн хүчин төгөлдөр хууль, эрх зүйн орчныг сайжруулах, цаашдын хөгжлийн чиглэлийг тодорхойлоход оролцогч талуудын саналыг тусгах зорилгоор “Чөлөөт бүсийн хөгжлийн бодлого” хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гаргасан саналыг Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй шинэ сэргэлтийн бодлогод тусгаснаар цаашид хилийн зурвас, бүс дэх худалдааны чөлөөт бүсүүдийн үйл ажиллагаа эрчимжих хандлагатай байна.

Энэхүү судалгааны үр дүн нь хил дамнасан болон хилийн зурваст үйл ажиллагаа явуулдаг эдийн засгийн чөлөөт бүсүүдийн хамгаалалт, аюулгүй байдлын асуудлыг эрх зүйн хүрээнд боловсронгуй болгоход дэлхийн улс орнуудын арга туршлагаас нэвтрүүлэх, эрх зүйн зарим актуудад чөлөөт бүсийн аюулгүй байдлын талаар тусгуулахад өөрсдийн санал дүгнэлийг дэвшүүлэх явдал юм.

Та бүхэн энэхүү судалгааны тайлантай танилцан, тайлангийн боловсруулалт, сайжуулалтын талаар онол арга зүйн талаас нь санал, зөвлөмж, зааварчилгаа өгвөл бидний цаашдын судалгааны ажилд ихээхэн тус дөхөм болох болно.

ХҮНДЭТГЭСЭН:
ДХИС-ИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ СУДЛАЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ,
ДОКТОР (Ph.D), БРИГАДЫН ГЕНЕРАЛ Ч.САЙНТӨР

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| ТБ | Тусгай бүс |
| ЧБ | Чөлөөт бүс |
| ДХИС | Дотоод хэргийн их сургууль |
| ХЗЧБ | Хуурай замын чөлөөт бүс |
| ҮБ | Үйлдвэрлэлийн бүс |
| ТТДБ | Техник технологи дамжуулах бүс |
| БЛБ | Боомт, логистикийн бүс |
| ЭЗТБ | Эдийн засгийн тусгай бүс |
| ЭЗХЯ | Эдийн засгийн хөгжлийн яам |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| ТЭЗҮ | Техник эдийн засгийн үнэлгээ |
| НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| ОУ | Олон улс |
| ЭЗ | Эдийн засаг |
| ДХБ | Дэлхийн худалдааны байгууллага |
| ХЧБ | Худалдааны чөлөөт бүс |
| ЧХБ | Чөлөөт худалдааны бүс |
| ЗГ | Засгийн газар |
| ШУ | Шинжлэх ухаан |
| ХАА | Хөдөө аж ахуй |
| ОЭЗ | Организацие экономическое зоне |
| ТУХН | Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл |
| БНХ | Беларусийн Гаалийн холбоонд |
| ЕАЭЗХ | Евро  Азийн эдийн засгийн холбоо |
| НӨАТ | Нэмүү өртөгийн албан татавар |
| ЦДАШ | Цахилгаан дамжуулах автомат шугам |
| ААН | Аж ахуйн нэгж |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ХХК | Хязгаарлагдмал хувьцаат компани |
| АНЭУ | Арабын Нэгдсэн Эмират улс |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| УИХ | Улсын их хурал |
| ШУӨЗО | Шинжаан-Уйгарын Өөртөө Засах орон |
| ЭЗНЗ | Эдийн засаг, нийгмийн зөвлөл |

## ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1. Туршилтын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа чөлөөт бүсүүд

Хүснэгт 2. ОХУ-ын Гаалийн ерөнхий газраас 2022 онд гаргасан судалгаа

Хүснэгт 3. 2022 онд бодитоор бий болгосон болон төлөвлөгдсөн ажлын байрны тоо

Хүснэгт 4. Чөлөөт худалдааны хэлэлцээрийг соёрхон баталж, гэрээ байгуулсан улс орнуудын жагсаалт

Хүснэгт 5. Хөрөнгө оруулагчдад татвар, гаалийн хөнгөлөлт үзүүлсэн жагсаалт

Хүснэгт 6. Газрын өмчлөлийн хэлбэр

Хүснэгт 7. Удирлагын бүтэц

Хүснэгт 8. Харьцуулалт хийсэн улс орнуудын эзэлж буй байр

Хүснэгт 9. Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн хөгжлийн голлох үзүүлэлтүүд

Хүснэгт 10. Хөрөнгө оруулагчдад татвар, гаалийн хөнгөлөлт үзүүлсэн жагсаалт

Зураг 1. Хятадын чөлөөт бүсүүдийн төрөл

Зураг 2. 2013 оны эхээр ОХУ-д ЭЗ-ийн үйл ажиллагааны үр нөлөөний үнэлгээ

Зураг 3. ОХУ-ын аж үйлдвэр, худалдааны яамнаас татвараас чөлөөлөх бүс нутгуудын тойм зураг

Зураг 4. ОХУ-тай хиллэдэг хилийн боомтуудыг харуулсан бүдүүвч зураг.

# НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Энэхүү судалгааны ажилд ашигласан дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

**Үүнд:**

**“Улсын хил хамгаалах байгууллага”** гэж Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хилийн цэргийн анги, салбарыг;

**“Улсын хилийн зурвас”** гэж Улсын хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулах, хилийн инженер, техникийн байгууламж барих зориулалтаар улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг;

**“Улсын хил дамнасан байгууламж”** гэж улсын хилийн шугамыг дайран гарсан төмөр зам, авто зам, газрын тос болон хий дамжуулах хоолой, холбоо, цахилгааны шугам, гүүр, усны далан, хашлага болон бусад байгууламжийг;

**“Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж”** гэж хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий саад, мөр хянах зурвас, зам, гүүр, хянах цамхаг, холбоо, дохиолол хяналтын техник хэрэгсэл, замын хаалт болон бусад байгууламжийг;

**“Хил орчмын оршин суугч”** гэж хил орчмын нутаг дэвсгэрт байнга оршин суух бүртгэлтэй Монгол Улсын иргэнийг;

**“Хил орчмын нутаг дэвсгэр”** гэж хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрийг;

**“Хилийн хяналтын байгууллага”** гэж улсын хил нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт явуулах, бүртгэх эрх бүхий улсын хил хамгаалах, гааль, гадаадын иргэн, харьяатын байгууллагыг;

**“Чөлөөт бүс”** гэж гаалийн татвар болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршиж байгаад тооцогдох, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг;

**“Чөлөөт худалдааны бүс”** гэж улсын хилийн дотор гаалийн гадна байгуулагддаг татварын хөнгөлөлт болон гаалийн тусгай хяналтын бодлогод нийцүүлж, худалдааны чөлөөтэй байдлыг эрхэмлэн, татварыг хөнгөвчлөх зорилготой олон талт ашиг бүхий ЭЗ-ийн шинжтэй тусгай хэсгийг; (Тухайн нэршил нь БНХАУ-д ашиглагдана)

**“Эдийн засгийн тусгай бүс”** гэж эдийн засгийн чухал салбаруудад дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх, эдийн засгийн хөгжлийг төвлөрүүлэхэд зориулагдсан онцгой эрх зүйн орчин, улсын эдийн засгийн хөнгөлөлттэй нутаг дэвсгэрийн онцгой дэглэм бүхий тусгай хэсгийг; (Тухайн нэршил нь ОХУ-д ашиглагдана)

**“Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”** гэж хил залгаа улстай тус тусын хилийн зурвас дахь газарт Засгийн газар хоорондын хэлэлцээрт үндэслэн байгуулсан чөлөөт бүсийг;

**“Чөлөөт бүс дэх үйл ажиллагааны тусгай дэглэм”** гэж хөрөнгө оруулалтыг татах, шинэ технологийг нэвтрүүлэх, экспортыг дэмжих, аялал жуулчлал, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэнийг гаалийн татвар болон бусад татвараас хөнгөлөх, чөлөөлөх, шалган нэвтрүүлэх, бүртгэх, гаалийн хяналт тавих, чөлөөт бүсэд зорчих, хөдөлмөр эрхлэх хөнгөвчилсөн нөхцөлийн талаар энэ хуульд заасан тусгай зохицуулалтыг;

**“Гаалийн нутаг дэвсгэр”** гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулсан гаалийн баталгаат бүсийн болон чөлөөт бүсийн нутаг дэвсгэр нь тарифын болон тарифын бус хязгаарлалтын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдоно;

**“Гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт”** гэж Гаалийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан бичиг баримтыг шаардахгүйгээр гаалийн мэдүүлгийн зарим хэсгийг нөхөн бичүүлэх замаар гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийж, барааг гаалийн хилээр нэвтрүүлэхийг;

**“Худалдааг хөнгөвчлөх”** гэж олон улсын худалдааны үйл явц буюу худалдагчаас худалдан авагчид бараа, түүхий эд, бүтээгдэхүүнийг нийлүүлэх, зураасан кодыг бүртгэх, төлбөр төлөхтэй холбоотой мэдээллийн урсгал, өгөгдөл, баримт бичгийг цөөлөх, хялбаршуулах, харилцан уялдуулах зэрэг үйл ажиллагааг;

**“Чөлөөт бүсэд зорчих”** гэж Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн албан болон хувийн хэргээр чөлөөт бүсэд нэвтрэхийг;

**“Чөлөөт бүсэд үйлдвэрлэсэн бараа”** гэж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан нэмэгдсэн өртгийн 40-өөс дээш хувь нь чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт бий болсон барааг;

**“Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал”** гэж Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдоно” гэж[1], Монгол Улсын хилийн тухай хуульд “хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг” мөн бөгөөд “хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдахыг;

**“Чөлөөт бүсэд зорчих”** гэж Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн албан болон хувийн хэргээр чөлөөт бүсэд нэвтрэхийг;

**“Чөлөөт бүсэд үйлдвэрлэсэн бараа”** гэж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан нэмэгдсэн өртгийн 40-өөс дээш хувь нь чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт бий болсон барааг

[1] Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. Уб., 2002 он.

# УДИРТГАЛ

**1.Судалгааны үндсэн шаардлага:**

Дэлхийн улс орнуудын эдийн засаг дахь өрсөлдөөн эрчимтэй нэмэгдэж, бараа бүтээгдэхүүний үнээс илүүтэй чанар, шинэлэг байдал, шинжлэх ухааны ололт амжилтыг шингээсэн байх нь хэрэглэгчдийг татах чухал хүчин зүйлс болж байгаа бөгөөд энэхүү эдийн засгийн өрсөлдөөн дундаас их хэмжээний ашиг олох гэсэн санаархал улам бүр нэмэгдсээр байна. Монгол Улс ч гэсэн энэхүү өрсөлдөөнөөс ангид байх боломжгүй учир өөрийн давуу тал, нөөц баялагтаа тулгуурлан хөгжих гарцыг хайж, олон тулгуурт эдийн засгийг бий болгох боломжийг эрэлхийлсээр байгаа билээ. Үүний нэг нь эдийн засгийн чөлөөт бүсийг өргөжүүлэх замаар орон нутгийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжих явдал юм.

Сүүлийн үед дэлхий дахинд чөлөөт бүс нь техник технологийн, боомт логистикийн, аялал жуулчлалын, үйлдвэрлэлийн төв болон өргөжих нь улс орнуудын эдийн засгийн сэргэлт, тогтвортой байдалд эерэг нөлөөлөл үзүүлж байгаа хэдий ч хилийн зурвас газарт болон улсын хил дамнан оршдог зарим чөлөөт бүсүүдийн хувьд улсын хилийн аюулгүй байдлын асуудал зайлшгүй хөндөгдөх болж байна.

Олон улсад хил дамнасан болон хилийн зурвас газарт байрлах эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг хэвийн явуулах, тэдгээрийн байршилд өрнөж буй үйл ажиллагаа, иргэдийн хөдөлгөөнийг хянах, чөлөөт бүсэд хоёр улсын засгийн газрын гэрээ, хэлэлцээрийг мөрдүүлэх, нийтийн хэв журмыг сахиулах, хилийн аюулгүй байдлыг хангахад Цагдаа, Дотоодын цэрэг, Хил хамгаалах байгууллагын үүрэг оролцоо, харилцан ажиллагааг сайжруулах нь зүйтэй гэж үздэг.

Энэ нь чөлөөт бүсэд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль дүрэм, гэрээ хэлэлцээрийн хэрэгжилт, чөлөөт бүсээр үйлчлүүлэгчдийн болон тэнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн ажилчид, хоёр улсын хил орчмын нутаг дэвсгэрт оршин суугчдын аюулгүй байдал, цаашлаад улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээний нэг юм.

Хил дамнасан чөлөөт бүс нь улс орны эдийн засгийн үр өгөөж, ажлын байрны тоог нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангах, зах зээлийн өрсөлдөөнийг бий болгох, хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйлдвэрлэл явуулах, аялал жуулчлал хөгжүүлэх зэрэг хил залгаа оршин тогтнох улс орнуудын хувьд олон талт эрх ашгийг хангахад өндөр ач холбогдол бүхий субьект болохыг судлаачдын дүгнэлтээр тогтоосон ч түүнийг дагасан сөрөг үр дагаврууд байсаар байгаагийн нэг нь эдийн засгийн чөлөөт бүс байрлаж буй нутаг дэвсгэр, хил хязгаарын аюулгүй байдлын асуудал юм.

Чөлөөт бүс хөгжиж буй Хятад, Казакстан, Турк зэрэг улс орнууд энэхүү асуудалд чухал ач холбогдол өгч, чөлөөт бүсийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд эдийн засгийн чөлөөт бүс дэх аюулгүй байдлын асуудал харьцангуй тогтворжсон гэж үзэж болно.

Гадаадын улс орнуудын туршлагаас үзэхэд хил орчмын нутагт эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх бодлогын баримт бичигтээ бүтээн байгуулалтын болон үйл ажиллагаа явуулах үеийн аюулгүй байдлын асуудлыг тусган хэрэгжүүлдэг ба хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулж, улсын хилийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тухайн баримт бичигтэй уялдуулан зохицуулдаг байна.

Манай улсын хувьд хилийн зурвас газарт болон хил дамнасан эдийн засгийн чөлөөт бүс байгуулах асуудал 1995 оноос эхэлсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 87 дугаар тогтоолоор “Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал”-ыг баталж, Монгол Улсын их хурлын 2002 оны 38 дугаар тогтоолоор “Алтанбулаг”, 2004 оны 17 дугаар тогтоолоор “Замын-Үүд”, 2005 оны 66 дугаар тогтоолоор “Цагааннуур” эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах шийдвэр гарчээ.

Өнгөрсөн хугацаанд эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийн асуудал царцанги байдалтай байсан хэдий ч Монгол Улсын Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогын баримт бичигт эдийн засгийн үр өгөөж бүхий зарим хилийн боомтуудыг дахин төлөвлөх, чөлөөт бүсийн хөгжлийг сайжруулах олон талт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тусгаж, цаашид энэ чиглэлийн бүтээн байгуулалтын ажлуудыг үе шаттайгаар гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Дээрх ажлууд хийгдэж, чөлөөт бүсийн үйл ажиллагааг эдийн засгийн эргэлтэд оруулах нь улс орны хөгжил, ард иргэдийн амьжиргаанд сайнаар нөлөөлөх хэдий ч чөлөөт бүсийн аюулгүй байдлын асуудал хөгжлийн бодлоготой зэрэгцээ байдлаар явуулах нь зүйтэй юм.

Хилийн аюулгүй байдлын үндсэн үүрэг бол газар нутгийн бүрэн бүтэн байдал, улс орны тусгаар тогтнолыг хангах, улсын хил, хязгаар нутагт сайн хөршийн харилцаа, энх тайвнаар зэрэгцэн оршиход чиглэсэн, хилийн зөрчилгүй байлгах олон улсын зарчим, бусад улс хоорондын эрх зүйн хэм хэмжээг зохион байгуулах, улсын хилийн шугамын явалтыг хууль бусаар өөрчлүүлэхгүй байх, хилийн дэглэм, журмыг хувь хүмүүс, хуулийн этгээдүүдээр сахиулах явдал юм. Үүнд:

Хилийн зурвас дахь эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжил нь хилийн аюулгүй байдалд дараах байдлаар нөлөөлнө гэж үзэж байна. Үүнд:

-Хилийн зурвас, бүсэд нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдэж, хил орчмын дэглэмийн биелэлтийг хангуулахад хүндрэл бий болох;

-Манай улсын иргэд хил залгаа улсын талын иргэдтэй чөлөөт бүсийг түшиглэн үгсэн тохирч, хил дамнасан хууль бус үйл ажиллагаа явуулах тохироо хийх;

-Чөлөөт бүс рүү нэвтрэх хөдөлгөөний нягтрал, дараалал нэмэгдсэнээр иргэд, төрийн алба хаагчдын дунд үл ойлголцол бий болж, хилийн зурваст нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх;

-Чөлөөт бүсээр үйлчлүүлэгчид гаалийн татваргүй бүсэд архидан согтуурч, согтуугаар улсын хил зөрчих, зөрчихийг завдах;

-Хилийн ойролцоох суурингуудад хүн амын нягтрал ихэссэнээр хүн хулгайлах хэлбэрийн гэмт хэргийн гаралт нэмэгдэх;

-Чөлөөт бүсээр үйлчлүүлэх зорилгоор хилийн зурвас нэвтрэгсэд байгалийн үзэсгэлэнт болон түүхийн дурсгалт газруудыг үзэх, аялах зорилгоор хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил гаргах;

-Хилийн орчинд хар тамхи мансууруулах бодисыг худалдан борлуулах, хэрэглэх, улсын хил давуулан хууль бусаар наймаалах, нисгэгчгүй нисэх хэрэгсэл ашиглан хар тамхи зөөвөрлөх;

-Чөлөөт бүсэд дэд бүтэц, барилга байгууламжийг барих, сайжруулахад чиглэсэн хамтарсан төслийн хүрээнд суваг шуудуу татах нэрийдлээр улсын хилийг газрын хэвлийгээр зөрчих зэрэг хэлбэрийн зөрчил гаргах эрсдэлтэй байна.

Эдийн засгийн чөлөөт бүс бүхий хилийн цэргийн ангиуд дээрх нөлөөллийг урьдчилан тооцож, өөрсдийн хүч хэрэгслийн боломжид тулгуурлан хил хамгаалалтыг зохион байгуулахаас гадна хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд чөлөөт бүсийн хамгаалалтын асуудлыг шинэ шатанд судалж, чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн ажилчдын болон чөлөөт бүсээр үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах асуудлыг зохион байгуулах шаардлага бий болж байна.

Монгол Улсын чөлөөт бүсийн тухай хууль 2015 онд батлагдаж, уг хуулийн шинэчилсэн найруулгын наймдугаар бүлгийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт ***“хилийн зурвас дахь чөлөөт бүсийн харуул, хамгаалалтын үүргийг хил хамгаалах байгууллага, бусад чөлөөт бүсийн харуул, хамгаалалтын үүргийг холбогдох байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр тус тус гүйцэтгэнэ”*** гэж[2], Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 497 дугаар тогтоолд ***“Алтанбулаг”, “Замын-Үүд”-ийн чөлөөт бүсүүдийн харуул, хамгаалалтын үүргийг 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Хил хамгаалах байгууллагаар гүйцэтгүүлэх”*** гэж[3] тус тус заасан байна.

Тус тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ***“Цагдаагийн байгууллагын хамгаалалтад байх онц чухал обьектын жагсаалт”***-ын ***“Цагдаагийн гэрээт хамгаалалтад байх обьектын жагсаалт”-***аас “Алтанбулаг” эдийн засгийн чөлөөт бүс, “Цагааннуур” эдийн засгийн чөлөөт бүс гэсэн хэсгийг хасах талаар тогтоолд дурдсан тул хилийн зурвас дахь чөлөөт бүсийн хамгаалалтын асуудлыг 2016 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн Цагдаагийн байгууллагын “Объект хамгаалах тасаг”-аас Хил хамгаалах байгууллагад шилжүүлсэн юм.

---

[2] Монгол Улсын хилийн тухай хууль. Уб., 2016 он.

[3] Монгол Улсын Засгийн газрын тогтоол. Уб., 2014 он.

Иймд Хил хамгаалах байгууллага болон чөлөөт бүс бүхий хилийн цэргийн анги, салбаруудын чиг үүргийг зөвхөн улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх боомтын үйл ажиллагаа руу төвлөрүүлэх биш хилийн зурвас, бүс дэх иргэдийн хөдөлгөөн, хүн амын нягтрал ихтэй хэсгүүд, чөлөөт бүсийн аюулгүй байдал, хамгаалалт руу хандуулан, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх замаар чөлөөт бүсийн захиргаа болон бусад харилцан ажиллагаатай байгууллагуудын уялдаа холбоог сайжруулахад чиглэсэн арга хэмжээг цогц байдлаар нарийвчлан төлөвлөж, хамтран хэрэгжүүлэхээс гадна хилийн орчинд үүссэн гадаад, дотоод аюул заналыг даван гарахад төрийн цэргийн байгууллагуудын нэгдмэл үйл ажиллагаа нэн чухал юм.

Хилийн аюулгүй байдлын обьект, субьект, тэдний орон зайн цар хүрээг тодорхойлсон тодорхойлолтод төрийн захиргааны төв байгууллагууд, орон нутгийн засаг захиргааны нэгжүүд, ард иргэд нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хилийн аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт оролцох эрх, үүргийг хүлээсэн байдаг.

Үүнээс үзэхэд чөлөөт бүсийн хөгжил түүнийг дагаж эрчимжих худалдааны болон үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа цаашид улам бүр өргөжиж, хил орчмын нутаг дэвсгэрт байрлах аймаг, сум, сууринууд руу чиглэсэн хөдөлгөөний урсгал, хүн амын нягтрал нэмэгдэн, тухайн чиглэлийн улсын хил хамгаалалт, хилийн дэглэм сахиулах арга хэмжээ, хилийн аюулгүй байдлыг хангах асуудал цаг үеэ даган хувьсан өөрчлөгдсөөр байх болно.

Иймд эдийн засгийн хувьсал, нийгмийн харилцаа, хүн амын өсөлт, аялал жуулчлал, тээвэр логистик, цахим хөгжил, уул уурхай, үйлдвэрлэл худалдаа хөгжсөнөөр эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагаа эрчимжиж, энэ нь хилийн аюулгүй байдал, цаашлаад улс орны үндэсний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх талаар нарийвчлан судалж, судалгааны эргэлтэд оруулах хэрэгцээ шаардлага бий болж байна.

**2.Судалгааны зорилго, зорилт:**

Хил залгаа улс орнуудын чөлөөт худалдааны болон эдийн засгийн тусгай бүсийн үүсэл хөгжил, онол, практикийн асуудал, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах, Монгол Улсын Алтанбулаг, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагад дүн шинжилгээ хийх, чөлөөт бүсийн аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж боловсруулахад судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны ажлын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

-Хил залгаа улс орнуудын эдийн засгийн чөлөөт бүс (Тусгай бүс)-ийн түүхэн уламжлал, онцлог, онол, практикийн асуудал, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах;

-Монгол Улсын Алтанбулаг, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүс болон хамтын ажиллагааны бүсийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх;

-Эдийн засгийн чөлөөт бүсийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг багасгах, аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж боловсруулж, дүгнэлт гаргах зэрэг болно.

**3. Судлагдсан байдлын тойм:**

Сүүлийн жилүүдэд хил судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх замаар Хил хамгаалах багууллагаас эрдэмтэн, судлаачдыг дэмжин, Хил судлалын хүрээлэн байгуулж, улсын хил хамгаалалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэхэд анхааран ажиллаж байгаа хэдий ч чөлөөт бүсийн аюулгүй байдлын асуудлаар докторын түвшинд судалсан судалгааны бүтээл хийгдээгүй байна.

**4.Судалгаанд ашигласан мэдээлэл:**

Монгол Улсын “Алтанбулаг”, “Замын-Үүд”, “Цагааннуур”-ын эдийн засгий болон худалдааны чөлөөт бүсүүдийн 2015-2023 оны тайлан, Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яамнаас чөлөөт бүсийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний бодлого, төлөвлөгөө, Хятад, Монголын Эрээн хот-Замын-Үүдийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хамтад нь хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө (2019-2035), БНХАУ, Казакстан улсын хил дээр байрлах “Хосгос” олон улсын эдийн засгийн чөлөөт бүсийн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагад хийсэн дүгнэлт, БНХАУ, ОХУ-ын эдийн засгийн болон худалдаа, аж үйлдвэрлэл, аялал жуулчлал, тээвэр ложистикийн чөлөөт бүсүүдийн талаарх ерөнхий мэдээлэл.

**5. Судалгааны ажлаар хүрэх онол, практикийн ач холбогдол:**

**А) Онолын ач холбогдол.**Судалгааны ажил нь чөлөөт бүсийн аюулгүй байдал, харуул, хамгаалалт руу чиглэсэн урьд өмнө тусгайлан судлагдаж байгаагүй, судалж буй асуудлаар онол арга зүйн хувьд тэнцвэртэй байдлыг хангасан, хил хамгаалалтын урлагт суурилсан, харуул, хамгаалалтын асуудлыг онолын үндэслэлтэйгээр зохион байгуулан явуулах, чөлөөт бүсийн аюулүй байдал, харуул, хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгох талаар тусгайлан судалсан нь судалгааны болон мэдлэгийн санд зохих хувь нэмрээ оруулж, энэ чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын эх сурвалж болохуйц түвшинд боловсруулахад  судалгааны ажлын онолын ач холбогдол оршино.

**Б) Практик ач холбогдол.** Улс орон бүр аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр багагүй анхаарч буй өнөөгийн нөхцөлд манай улс түүний дотор хуулиар хүлээсэн чиг үүрэг бүхий Хил хамгаалах байгууллагын хүч хэрэгслийн бэлэн байдлыг дээшлүүлэх, чөлөөт бүсийн аюулгүй байдал, харуул, хамгаалалтын асуудлаар нэгдсэн ойлголт, зохион байгуулалттай болгох талаар санал, зөвлөмж боловсруулахад судалгааны  ажлын практик ач холбогдол оршино.

**6.Судалгааны ажлын шинэлэг тал:**

Хилийн зурвас дахь худалдааны чөлөөт бүсүүдийн харуул, хамгаалалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, чөлөөт бүсийн цаашдын хөгжлийн чиг хандлагатай

уялдуулах зарчмаар чөлөөт бүсийн аюулгүй байдал, харуул, хамгаалалтын асуудлыг тодорхойлж, боловсронгуй болгоход чиглэсэн санал, зөвлөмж боловсруулна.

**7.Судалгааны арга зүй:**

Судалгааны ажил гүйцэтгэхдээ баримт бичгийн судалгаа хийх нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, статистик дүн шинжилгээ хийх, түүхчлэн судлах, шинжээчдийн үнэлгээний арга, төлөв нөхцөл байдлын шинжилгээг дотоод болон гадаад хүчин зүйлсийн боломж үр дүнгээр гаргах аргуудыг ашиглана.

**8.Судалгааны ажил явуулах хугацаа:**

2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл.

**9.Судалгаа хийх газар:**

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь эдийн засгийн чөлөөт бүсүүдэд тулгуурлан явуулах бөгөөд хөрш зэргэлдээх ОХУ, БНХАУ-ын туршлагаас судална.

**10.Судалгаанд шаардагдах хүч хэрэгсэл, тоног төхөөрөмж:**

Судалгааны ажлыг ердийн орчинд бичих, хэвлэх техник хэрэгслийг ашиглах замаар хийнэ.

**11.Судалгааны ач холбогдол:**

-Хил залгаа улс орнуудын эдийн засгийн чөлөөт бүс (Тусгай бүс)-ийн түүхэн уламжлал, онцлог, онол, практик, эрх зүйн зохицуулалтыг судлан, судалгааны үр дүнгээр чөлөөт бүс байгуулах, хөгжүүлэх үеийн арга туршлага, бодлого төлөвлөлтийг хэрхэн хэрэгжүүлдэг арга замыг тодорхойлно.

-Монгол Улсын Алтанбулаг, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, эрх зүйн орчныг судлан, дүн шинжилгээ хийж, цаашид боловсронгуй болгох асуудлыг тодорхойлно.

-Чөлөөт бүсийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг багасгах, аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж боловсруулан, дүгнэлт гаргаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ГАДААДЫН УЛС ОРНУУДЫН ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ БҮСИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

## §1.1.БНХАУ-ын чөлөөт худалдааны бүсийн үүсэл хөгжил, онол, практикийн асуудал

"Киотогийн конвенц"-д үндэслэн, чөлөөт худалдааны бүс нь улсын нэг хэсэг газрыг заах, энэ хэсэг газар дотор тээвэрлэн оруулах аливаа бараа таваарын импортын гаалийн татвар болон бусад бүх татварыг нөхцөлийн хувьд, гаалийн хилийн гадна гэж авч үзэх, мөн гаалийн хяналтын дүрмийн хэрэгжүүлэлтээс чөлөөлөгдөнө гэж заасан байдаг.

Чөлөөт худалдааны бүс нь энгийнээр хоёроос дээш улсууд эсвэл бүс нутгийг хэлнэ гэж чөлөөт худалдааны гэрээнд гарын үсэг зурснаар, Дэлхийн худалдааны байгууллагын хамгийн ашигтай улстай холбогдоход үндэслэн, харилцан зах зээлээ нэг алхам нээлттэй болгох, хэсэг үе шатанд барааны асар том хэсэгт тарифын болон тарифын бус саад бэрхшээлийг хүчингүй болгох, үйлчилгээний болон аж ахуйн салбарыг сайжруулах, зах зээлийн нөхцөл, нээлттэй хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүн үйлчилгээ, хөрөнгө оруулалт, техник технологи гэх мэтийн үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн чөлөөтэй урсгалыг идэвхжүүлэх, худалдаа болон хөрөнгө оруулалтын чөлөөтэй байдлыг хангах, давуу байдлыг харилцан нөхөх байдлыг хэрэгжүүлэх, нэгдсэн хөгжлийг идэвхжүүлэх, бүх гишүүдийг хамарсан нэг төрлийн онцгой чиг үүргийн бүсийг бүрэлдүүлэн бий болгох асуудал юм.

Одоогийн байдлаар дэлхий дээр нэг ч олон улсын шинж чанартай чөлөөт худалдааны бүс байхгүй байгаа ба олон улсын худалдааны давхаргаас чөлөөт худалдааны бүсийг судлах, мөн чөлөөт худалдааны бүсүүд хооронд нэвтрэлцэх гүүр болгох, аливаа чөлөөт худалдааны бүсүүд хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэлхийн чөлөөт худалдааны бүсүүдийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах зорилгыг хангах, орон тоог нөхөх, дэлхийн аливаа улсын чөлөөт худалдааны бүсийн хамтын ажиллагааны хүчийг нэмэгдүүлэх, чөлөөт худалдааны бүсийг үйлчилгээгээр хангахын тулд, аливаа чөлөөт худалдааны бүсүүдийн мэдээлэл нэвтрэлцэх байдлыг улам тохиромжтой болгох, хамтын ажиллагааны үр ашгийг сайжруулах, аливаа улсууд хоорондын чөлөөт худалдааг хурдасгах, чөлөөт худалдааны бүсийн үр нөлөөг хамгийн том хэмжээгээр онцгойлон гаргах зэрэг асуудлыг шинэ шатанд гаргахыг эрмэлзэж байна.

Өнөөдрийн байдлаар, дэлхийн аль ч улсад чөлөөт худалдааны бүсийг өөрийн улсын эдийн засгийг хөгжүүлэхэд түшиц болгох замаар үүсгэн байгуулж байгаа ба түүнийг хөгжүүлэхэд онцгой анхаарал хандуулж байна. Мөн чөлөөт худалдааны бүсийн үйлдвэрлэл болон цаашдын хөгжил нь гүнзгий учир шалтгаантай бөгөөд өвөрмөц үүрэг оролцоотой байдаг. Дэлхий даяар чөлөөт худалдааны бүсийн тоо тасралтгүй өсөж, хамрах асуудлууд ч хурдтай өргөжин, эдийн засгийн чөлөөт байдлын түвшин илэрхий сайжирч байна гэж үзэж байна.

Карибын тэнгисийн чөлөөт худалдааны бүс нь дэлхийн эдийн засгийн хөгжлийн шинэ байдалд хариу үйлдэл үзүүлж, дэлхийн чөлөөт худалдааны бүсүүдийн холбоо өргөжин хөгжих бэлтгэл болж байсан. Дэлхийн чөлөөт худалдааны бүсүүдийн холбоо нь аливаа чөлөөт худалдааны бүсүүдийн чөлөөтэй худалдаа эрхлэх түвшнийг дээшлүүлж,

дэлхийн хэмжээнд чөлөөт худалдааны бүсийг үүсгэн байгуулах ажлыг идэвхтэй урагшлуулах, аливаа улсын гадаад худалдааны хэмжээг дээшлүүлэх, идэвхжүүлэх, гадаад худалдааны хоёр талын хөрөнгө оруулалтын ихэнх хэсэгт чөлөөтэй байх болон хөнгөвчлөх байдлыг хэрэгжүүлсээр ирсэн.

Дэлхийн чөлөөт худалдааны бүсийн холбоог ОУ-ын шинжтэй ашгийн бус байгууллага болгох, чөлөөт худалдааны бүсийн бодлогыг бүрэн хэрэгжүүлэх, чөлөөт худалдааны бүсүүд хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, чөлөөт худалдааны бүсийг хамтын ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, мөн чөлөөт худалдааны бүсийг НҮБ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн байгууллагын тусгай гишүүн байгууллага болгон хөгжүүлэхэд анхаарч байна.

Дэлхийн чөлөөт худалдааны бүсийн үр нөлөөг дараах байдлаар харж байна. Үүнд:

1.Чөлөөт худалдааны бүсийг бараа бүтээгдэхүүний төвлөрсөн төв болгон ашиглах боломжтой экспортын болон дамжин өнгөрөх худалдааны зарчмаар өргөжүүлэх, түүний худалдааны байр суурь, чадамжийг сайжруулах замаар гадаад валютын орлогыг нэмэгдүүлэх.

2.Чөлөөт худалдааны бүсийн бараа бүтээгдэхүүнийг ОУ-ын хөрөнгө оруулалтын төв болгон ашигласнаар чөлөөт бүсийн доторх татварын орлого, гадаад валютыг ашиглах зэрэг урамшууллын бодлогыг хэрэглэх, гадаадын хөрөнгийг татах, тэргүүлэх зэрэглэлийн техник технологийн болон менежментийн туршлагыг нэвтрүүлэх.

3.Чөлөөт худалдааны бүсийг олон улсын ложистикийн төв болгон ашиглах боломжтой гэж үздэг бөгөөд энгийнээр хэлбэл хилийн бүс нутагт чөлөөт худалдааны бүсийг байгуулснаар зам харилцааны хөгжил дэвшил сэргэж, тээвэр ложистикийн салбарын хөгжилд үр нөлөө үзүүлэх боломжтой юм.

**Чөлөөт худалдааны бүсийн ерөнхий ангилал:**

Чөлөөт худалдааны бүсэд мөн чанарын ялгаатай хоёр ангилал байдаг ба нэгдүгээрт ЕТА, хоёрдугаарт ЕТ2 юм. Хятад хэлээр ижил төстэй юм шиг боловч ойлголтын болон зарчмын хувьд ялгаатай зүйлүүд байдаг байна.

**ЕТА:** Дэлхийн худалдааны байгууллагаас гаралтай “Чөлөөт худалдааны бүс”-ийн тухай дүрэм нь 1947 онд “Гаалийн татвар болон худалдааны ерөнхий гэрээ”-нд дурьдагдаж байсан. Тус гэрээний 24 дүгээр зүйлийн 8 дугаар хэсэгт гаалийн татвар болон чөлөөт худалдааны бүсийн зарчмыг тусгайлан тайлбарласан.

Үүнд: “Чөлөөт худалдааны бүс нь хоёр эсвэл түүнээс дээш бие даасан гаалийн татварын субъект хоорондын ойлголт байна.

Худалдааны чөлөөтэй байдалд гаалийн татвар болон бусад хязгаарлалтын шинжтэй худалдааны хууль дүрмийг хүчингүй болгох”.

Түүний гол онцлог нь хоёр эсвэл олон ЭЗ-ийн субъектив хэсгүүдийг нэгтгэн групп болгох, группийн гишүүд харилцан хоорондоо бодит шинжтэй гаалийн татвар болон бусад худалдааны хязгаарлалтуудыг хүчингүй болгох, гэхдээ тус бүрдээ бие даасан өөрийн гадаад худалдааны бодлогыгн баримтлах явдал юм.

Одоогийн байдлаар дэлхий дээр Европын холбоо, Хойд америкийн чөлөөт худалдааны бүс гэх мэт ЕТА-үүд аль хэдийн бий болсон байна. Мөн Хятадын АСЕАН-ны

чөлөөт худалдааны бүс нь энгийн ETA юм.

**ET2:** Дэлхийн гаалийн байгууллагаас гаралтай "чөлөөт бүс"-ийн тухай дүрэм, ДГБ-аас тогтоосон "Киотогийн конвенц"-д зааснаар "ET2 бол талуудын хилийн доторх тодорхой хэсэгт байрлах аливаа бараа бүтээгдэхүүний импортын татварын нөхцөлүүд нь ихэвчлэн гаалийн хилээс гадна байдаг". Түүний онцлог нь нэг гаалийн хилийн доторх нэг жижиг бүсийг гол эрх бүхий улс (бүстэй)-тай хашаагаар тусгаарлаж, хилээр орох барааны гаалийн татварыг татваргүй болон татварын баталгаат хэлбэрийг хэрэгжүүлдэг.

Маш олон улс орнууд хилийн дотроо бие даасан чөлөөт гарам, чөлөөт худалдааны бүсүүдийг үүсгэн байгуулж байна. Жишээлбэл Германы "Хамбург" чөлөөт гарам, Панамын "Кельн" чөлөөт худалдааны бүс гэх мэт байдаг.(Зураг 1)




**Хятадын чөлөөт бүсийн хэлбэрүүд:**

-Эдийн засаг, технологийн хөгжлийн бүс (Economic and Technology Development Zone);

-Худалдааны чөлөөт бүс (Free Trade Zone);

-Өндөр технологийн үйлдвэрийн хөгжлийн бүс (Hi-Tech Industrial Development Zone);

-Хилийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүс (Border Economic Cooperation Zone);

-Экспортын боловсруулах үйлдвэрийн бүс (Export Processing Zone);

-Аялал жуулчлал, амралтын бүс (Tourist and Holiday Resort);

-Тайваны хөрөнгө оруулалтын бүс (Taiwanese Investment Zone);

-Хөдөө аж ахуйн өндөр технологийн үйлдвэрийн үлгэр жишээ бүс (Agricultural Hi-Tech Industrial Demonstration Zone).

**1.Эдийн засаг, технологийн хөгжлийн бүс:**

- ➢ Далайн эрэг хавийн болон нээлттэй хотуудад төвлөрөх;
- ➢ Өндөр технологид суурилсан үйлдвэрийг үүсгэн хөгжүүлэх;
- ➢ Аж үйлдвэрийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх;
- ➢ Экспортод чиглэсэн эдийн засгийг бий болгох үндсэн 4 зорилготой байгуулагддаг бөгөөд энэ чиглэлийн нийт 56 бүс байдаг байна.






**2. Худалдааны чөлөөт бүс:**

- Гадаад худалдааны үйл ажиллагаа
- Гаалийн баталгаат агуулах
- Экспортын чиглэлийн аж ахуй, сав, баглаа, боодлын үйлдвэр, зарим бүсэд угсралтын үйлдвэр хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд энэ чиглэлийн 10 бүс байна.







**3.Өндөр технологийн үйлдвэрийн хөгжлийн бүс:**

- Оюуны багтаамжтай өндөр технологи, шинжлэх ухаан, технологийн ололт, амжилтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- Инновацийн бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд гаргах;
- Шинэ технологид суурилсан аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг 54 бүс байна.

**4.Хилийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүс:**

- Хил орчмын нээлттэй хотуудад хилийн худалдааг хөгжүүлэх;
- Экспортын бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих;
- Хөрш орнуудтай сайн хөршийн харилцааг хөгжүүлэх;
- Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 14 бүс байна.

**5.Аялал жуулчлал, амралтын бүс:**

- Дотоодын зах зээлээ гадаадад нээлттэй болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Аялал жуулчлалын нөөц, баялгийг эргэлтэнд оруулж, аялал жуулчлалын салбарын хөгжлийг түргэтгэх;
- Аялал жуулчлалын төрөл бүрийн төслүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 11 бүс байна.

**6.Тайваны хөрөнгө оруулалтын бүс:**

- Тайваны эх газар руу чиглэсэн хөрөнгө оруулалтыг татах;
- Тэргүүлэх технологи, менежментийг нутагшуулах;
- Хөгжлийн бүсээс БНХАУ-ын эдийн засагт орох ашиг, орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.

**7.ХАА-н өндөр технологийн үйлдвэрийн үлгэр жишиг бүс:**

- Тэргүүний технологид суурилсан үлгэр жишээ хөдөө аж ахуйг хөгжүүлэх;
- Өндөр технологийн газар тариаланг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.





**БНХАУ-ын чөлөөт худалдааны бүсийн хөгжлийн түүхэн явц:**

Хорь гаруй жилийн өмнө Хятадын анхны гаалийн баталгаат татварын бүс болох Шанхай Вайгаочиао группийг үүсгэн байгуулсан байна.

Тухайн үед, түүнийг англиар “Чөлөөт худалдааны бүс” гэж нэрлэдэг байсан бөгөөд гаалийн баталгаат татварын бүс гэж нэрлэдэггүй байв. Өнөөдрийг хүртэл хугацаанд Вайгаочиао гаалийн баталгаат татварын бүсийн дотор, Хятадын гаалийн тусгай хяналтын 110 бүс байгуулж байсан нь Хятадын гадаад худалдааны хөгжлийг сэргээн босгоход асар том үр нөлөө үзүүлсэн гэж үздэг байна.

Гэхдээ тэрхүү шинэчлэлт нь нээлттэй болсноор Хятадын хуурай газрын гаалийн тусгай хяналтын бүсэд “Хилийн доторх гааль” бодлогыг хэрэгжүүлсээр ирсэн.

ОУ-д нэвтрэх чөлөөт худалдааны бүсийн дүрэмд “Хилийн доторх гааль” бодлогыг хэрэгжүүлсэн нэг дэх шугам нь улсын хилийн шугам, хоёр дахь шугам нь чөлөөт бус худалдааны бүсийг холбох шугам болон хөгжиж, эдгээрийг бүсийн дотор гаалийн байнгын хяналтаас чөлөөлсөн байдаг.

Үүнтэй уялдуулан холбогдох салбаруудын шинэчлэлийг хийх шаардлага улам бүр нэмэгдсээр байсан байна.

Ойрын жилүүдэд өрнөсөн олон улсын санхүүгийн хямралын нөлөөгөөр дэлхийн эдийн засаг хараахан бүрэн сэргэж чадаагүй байгаа ба Хятад улсад ч гадаад эрэлт буурах, худалдааг гаалийн тарифаар дамжуулан хамгаалах байдал нэмэгдэх гэх мэт нэг систем бүхий сорилтууд тулгамдсаар байна.

Энэхүү нөхцөл байдалд Хятадын хилийн доторх туршилтын чөлөөт худалдааны бүсүүдэд “хилийн дотор гаалийн гадна” бодлогыг хэрэгжүүлж, Хятад болон эргэн тойрны эдийн засгийн субъектуудын харилцааг идэвхжүүлснээр дэлхийн худалдааны эргэлтэд эерэг үр нөлөөг үзүүлэх боломж нээгдэнэ гэж үздэг байна.

**БНХАУ-ын чөлөөт худалдааны бүсийн өнөөгийн байдал:**

2013 оны 8-р сарын 22-ны өдөр Хятадын ЗГ-аас Хятадын чөлөөт худалдааны бүсийг байгуулахаар албан ёсоор шийдвэрлэжээ.

Энэ талаар олон нийтэд мэдээлэл цацагдсаны дараа талууд ерөнхийдөө итгэлтэй болж, чөлөөт бүс нь Хятадын ЭЗ-ийг дээшлүүлэх томоохон хувилбар болсон ба ДХБ-д орсноор Хятадын ЭЗ-ийн үйл ажиллагаа нэг алхмаар урагшилж, чөлөөт худалдааны туршилтын бүсийн бүтээн байгуулалтыг идэвхтэй явуулсны үр дүнд дотоодын зах зээлд эдийн засгийн томоохон дэвшил гарчээ.

Одоогийн байдлаар Хятад улсад аль хэдийн байгуулахыг батлагдсан чөлөөт худалдааны бүсүүдэд (Шанхай), (Гуаньдунь), (Тианжин), (Фүжиан), (Туньлиао), (Жэжиань), (Хэнан), (Хубэй), (Чуньчинь), (Сичуань), (Шанси), (Хайнан), (Шандунь), (Жиаьсү), (Гуаньси), (Хэбэй), (Юннан), (Хэлуньжиань) зэрэг 18 чөлөөт худалдааны туршилтын бүс үйл ажиллагаагаа явуулж байна.

Хятадын чөлөөт худалдааны бүс нь улсын хилийн дотор гаалийн гадна байгуулагддаг ба татварын хөнгөлөлт болон гаалийн тусгай хяналтын бодлогыг гол чухал арга хэрэгслээ болгож, худалдааны чөлөөтэй байдлыг эрхэмлэн, татварыг хөнгөвчлөх зорилготой олон талт ашиг бүхий ЭЗ-ийн шинжтэй тусгай бүс бөгөөд зарчмын хувьд бараа бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, экспорт зэргийг зөвшөөрдөг субьект гэдгийг онцолъё.

Иймхүү чөлөөт бүсийг хөгжүүлэхэд Хятадын ЗГ бүх боломжоо дайчлан ажилласан бөгөөд энэ нь улсынхаа ЭЗ-ийг босгох хамгийн чухал алхам гэж үзэж байсан байна. Түүний гол ач холбогдлыг 1980-аад онд Шинжааны эдийн засгийн тусгай бүс байгуулах, 1990-ээд онд Пудуныг хөгжүүлэх хоёр томоохон үйл явдалтай харьцуулан үзэж, түүний гол цөм нь олон улсад нийцсэн ОУ хоорондын гэрээ конвенцыг байгуулах явдал юм.

Дотоод, гадаадын хөрөнгө оруулалт бүгд ОУ-д өрсөлдөх хүч бүхий ОУ-ын худалдааны орчин байдаг.

2013 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Хятадын ЗГ-аас (Шанхай) чөлөөт худалдааны туршилтын бүсийг;

2015 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр (Шанхай)-н чөлөөт худалдааны туршилтын бүсийг;

2015 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр (Гуаньдунь), (Тианжин), (Фүжиан) зэрэг 3 чөлөөт худалдааны туршилтын бүсийг;

2017 оны 03 дугаар сарын 31-ний өдөр (Туньлиао), (Жэжиань), (Хэнан), (Хубэй), (Чуньчинь), (Сичуань), (Шанси) зэрэг 7 чөлөөт худалдааны туршилтын бүсийг;

2017 оны 10 дугаар сарын 16-ны өдөр (Хайнан)-н чөлөөт худалдааны туршилтын бүсийг;

2017 оны 08 дугаар сарын 02-ны өдөр (Шандунь), (Жиаьсү), (Гуаньси), (Хэбэй), (Юннан), (Хэйлуньжиань)-н чөлөөт худалдааны туршилтын бүсийг бүтээн байгуулах зөвшөөрлийг тус тус баталсан байна.

Одоогийн байдлаар БНХАУ-д дараах чөлөөт бүсүүд туршилтын байдлаар үйл

ажиллагаа явуулж байгаа болон судлагдаж байна. (Хүснэгт 1)

**(Хүснэгт 1) Туршилтын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа чөлөөт бүсүүд**

| № | Тайлбар нэр |
|---|---|
| ***Эцэслэн батлагдсан гэрээ бүхий чөлөөт худалдааны бүс*** | |
| 1 | Хятад-Мавритани |
| 2 | Хятад-Мальдив |
| 3 | Хятад-Гүрж |
| 4 | Хятад-Австрали |
| 5 | Хятад-Солонгос |
| 6 | Хятад-Швейцарь |
| 7 | Хятад-Исланд |
| 8 | Хятад-Коста Рика |
| 9 | Хятад-Перу |
| 10 | Хятад-Шинэ Зеланд |
| 11 | Хятад-Сингапур |
| 12 | Хятад-Сингапурын шинэчлэх |
| 13 | Хятад-Чили |
| 14 | Хятад-Чилийн шинэчлэх |
| 15 | Хятад-Пакистан |
| 16 | Хятад-Пакистан 2-р үе шат |
| 17 | Хятад-АСЕАН |
| 18 | Хятад-АСЕАН (“10 + 1”) шинэчлэх |
| 19 | Дотоодын эх газар болон Хонконг, Макаогийн эдийн засаг, худалдааны харилцааг илүү нарийн нягт тохируулалт |
| ***Хөнгөлөлттэй худалдааны тохируулалт бүхий бүс*** | |
| 20 | Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр |
| ***Одоо хэлэлцээр хийгдэж буй чөлөөт худалдааны бүс*** | |
| 21 | Эдийн засгийн иж бүрэн түншлэлийн хэлэлцээр (ПСЕР) |
| 22 | Хятад-Персийн булангийн хамтын ажиллагааны зөвлөл (ССС) |
| 23 | Хятад, Япон, Өмнөд Солонгос |
| 24 | Хятад-Шри Ланка |
| 25 | Хятад-Израиль |
| 26 | Хятад-Норвеги |
| 27 | Хятад-Шинэ Зеландын чөлөөт худалдааны хэлэлцээрийг шинэчлэх хэлэлцээр |
| 28 | Хятад-Молдав |
| 29 | Хятад-Панам |
| 30 | Хятад Солонгос чөлөөт худалдааны хэлэлцээрийн 2-р үе шатны хэлэлцээр |
| 31 | Хятад-Палестин |
| 32 | Хятад-Перу чөлөөт худалдааны хэлэлцээрийг шинэчлэх хэлэлцээр |
| 33 | Хятад-Камбож |
| ***Одоо судлагдаж буй чөлөөт худалдааны бүс*** | |
| 34 | Хятад-Колумби |
| 35 | Хятад-Фижи |
| 36 | Хятад-Балба |
| 37 | Хятад-Папуа Шинэ Гвиней |
| 38 | Хятад-Канад |
| 39 | Хятад-Бангладеш |
| 40 | **Хятад-Монгол** |

| | |
|---|---|
| 41 | Хятад, Швейцарийн чөлөөт худалдааны хэлэлцээрийг шинэчлэх талаар хамтарсан судалгаа |

**БНХАУ-ын туршилтын чөлөөт худалдааны бүсүүдийн тухай:**

**Хөгжлийн зорилго:** БНХАУ-ын Намын төв хороо, ЗГ-ын чөлөөт худалдааны туршилтын бүсийг “Зорилгодоо хүрэх, үр дүнтэй туршилт явуулах, бие даасан өөрчлөлтийг идэвхтэй үргэлжлүүлэх”, “Зогсолтгүйгээр хайн судлах, туршилтын бүсийг улам гүнзгийрүүлэх” зэрэг шаардлагын дагуу хяналтын менежментийг гол цөм хөрөнгө оруулалтын менежмент болгох, худалдааг хөнгөвчлөх байдлыг чухалчлан, худалдааны хяналтыг сайжруулах, хөрөнгө санхүүгийн үйлчилгээний салбарын нээлттэй байдлыг зорилтот санхүүгийн инновац болгох, ЗГ-ын чиг үүргийн өөрчлөлтийг гол цөм асуудлыг сайжруулахыг эрмэлзэж, ОУ-ын хөрөнгө оруулалт, худалдааны зарчимтай холбогдсон дүрэм бүхий инновацын шинэ тогтолцоог бүрэлдүүлэн, санхүүгийн худалдаа, тэргүүлэх үйлдвэрлэл, ШУ технологийн инновац гэх мэт гол чухал чиг үүргүүдэд чиглүүлэхийг зорьж байна.

**“Гуаньдунь” чөлөөт худалдааны туршилтын бүс:**

Стратегийн байршил:

Хонгконг, Макаогийн үйлдвэрлэл үйлчилгээний газар, дэлхий ертөнцтэй нээлттэй харилцах бодлогод үндэслэн, чөлөөт худалдааны туршилтын бүсийн бүтээн байгуулалтыг Гуаньдунь, Хонгконг, Макао хоорондын хамтын ажиллагааны жишиг бүс болгох, 21-р зууны Шанхайн торгоны замын гол чухал зангилаа төв болон өргөжсөнөөр цоо шинэ өөрчлөлтийг нээнэ гэж үзсэн юм.

Хөгжлийн зорилго:

-Ойрын арван таван жилийн шинэчлэлтийг явцад ОУ-ын зах зээлд хууль дээдэлсэн бизнес худалдааны орчныг үүсгэн бий болгох;

-Нээлттэй хэлбэрийн эдийн засгийн шинэ тогтолцоог бүрэлдүүлэн бий болгох;

-Гуаньдунь, Хонгконг, Макао хоорондын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх;

-ОУ-ын эдийн засгийн өрсөлдөх давуу талыг шинээр бүрдүүлэн бий болгох;

-ОУ-ын өндөр стандартын хуулийн хязгаарлалт бүхий орчны цар хүрээ, хөрөнгө оруулалт худалдааг хөнгөвчлөх;

-Хяналт удирдлагын аюулгүй байдлын чөлөөт худалдааны бүсийг бүтээн байгуулах зэрэг юм.

Хэрэгжүүлэх цар хүрээ:

Чөлөөт худалдааны туршилтын бүсийн хэрэгжүүлэх цар хүрээ нь 116.2 км хавтгай дөрвөлжин газар нутаг байх ба гурван дүүрэг бүхий бүс нутаг хамаарна. Үүнд:

Гуаньжөү Нанша шинэ дүүргийн бүс 60 км хавтгай дөрвөлжин (Гуаньжөү Нанша баталгаат татварын далайн боомтын бүс 7.06 км хавтгай дөрвөлжин), Шинжааны Чианхай Шэкоү дүүргийн бүс 28.2 км хавтгай дөрвөлжин (Шинжааны Чианхайван баталгаат татварын далайн боомтын бүс 3.71 км хавтгай дөрвөлжин), Жүхай Хэньчин шинэ дүүрэг дэх дүүргийн бүс 28 км хавтгай дөрвөлжин газар нутгууд хамарна.

Чиг үүргийн төлөвлөлт:

-Бүс нутгийн байршуулалтын төлөвлөлтийн дагуу, Гуаньжөү Нанша шинэ дүүрэг дэх дүүргийн бүсэд голлон усан тээвэр ложистикийн, онцгой санхүүгийн, ОУ-ын худалдааны, өндөр чанартай үйлдвэрлэл гэх мэт салбаруудыг хөгжүүлэх;

-Үйлдвэрлэлийн шинжтэй үйлчилгээний салбаруудыг голлон орчин үеийн аж үйлдвэрийн шинэ өндөр болон дэлхийн тэргүүлэх түвшний нэгдсэн үйлчилгээний зангилаа төвүүдийг бүтээн байгуулах;

-Шэнжэн Чианхай Шэкоү дүүргийн бүсэд гол чухал санхүүгийн, орчин үеийн ложистикийн, мэдээллийн үйлчилгээний, ШУ технологийн, үйлчилгээний гэх мэт стратегийн шинж чанартай үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх;

-Хятадын санхүүгийн салбарыг гадаадад нээлттэй туршилтын жишиг цонх, дэлхийн үйлчилгээ худалдааны гол чухал үндсэн суурь болон ОУ-ын шинжтэй зангилаа төв, далайн гармуудыг бүтээн байгуулах;

-Жүхай Хэньчин шинэ дүүргийн бүсэд голлон аялал жуулчлал, амралт эрүүл мэнд, худалдаа үйлчилгээний санхүүгийн үйлчилгээ, соёл ШУ боловсрол болон өндөр хүчин чадал бүхий шинэ технологийн аж үйлдвэрүүдийг хөгжүүлэх;

-Соёл, боловсролын нээлттэй тэргүүлэх бүс болон ОУ-ын худалдаа үйлчилгээ, амралт, аялал жуулчлалын үндсэн суурь газруудыг бүтээн байгуулах;

-Макаогийн эдийн засгийг дэмжих зорилгоор, олон талын шинэ тээгч субектыг хөгжүүлэх зэрэг юм.

**“Тяньжин” чөлөөт худалдааны туршилтын бүс:**

Стратегийн байршил:

-Системийн инновацыг гол үүрэг болгох;

-Хуулбарлан өргөжүүлэх боломжийг үндсэн шаардлага болгож, Бээжин Тяньжин, Хэбэйн хамтын ажиллагааны хөгжлийг өндөр түвшинд нээлттэй байлгах өндөр түвшиний чөлөөт худалдааны бүсийг бий болгох.

Ерөнхий зорилго:

-Ойрын арван таван жилийн шинэчлэлтээр дамжин, чөлөөт худалдааны туршилтын бүсийн худалдааны чөлөөт байдал, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх;

-Аж үйлдвэрт тулгуурласан санхүүгийн үйлчилгээг сайжруулах, хуулийн хязгаарлалт бүхий орчны цар хүрээ, үр дүнд тохирсон удирдлагад чиглүүлэн жолоодох;

-ОУ-ын чанартай нэг урсгал бүхий чөлөөт худалдааны бүсийг бүтээн байгуулах;

-Бээжин, Тяньжин, Хэбэй хамтын ажиллагааны хөгжил болон улсын эдийн засгийн шилжилтийн хөгжлийн явцад манлайлан татах үр нөлөө бүхий жишгийг онцгойлон гаргах.

Хэрэгжүүлэх цар хүрээ:

Чөлөөт худалдааны туршилтын бүсийн хэрэгжүүлэх цар хүрээ нь 119.9 км хавтгай дөрвөлжин газар нутагтай байх ба дараах 3 дүүргийн бүс нутгийг хамруулна. Үүнд:

Тяньжин далайн боомтын дүүргийн бүс 30 км хавтгай дөрвөлжин (Дуньжиань баталгаат татварын далайн гармын бүс 10 км хавтгай дөрвөлжин), Тяньжин нисэх буудлын дүүргийн бүс 43.1 км хавтгай дөрвөлжин (Тяньжин далайн гармын баталгаат татварын бүсийн агаарын гарцын хэсэг 1 км хавтгай дөрвөлжин болон Бинхай шинэ дүүргийн нэгдсэн баталгаат татварын бүс 1.96 км хавтгай дөрвөлжин), Бинхай шинэ дүүргийн төв худалдаа үйлчилгээний дүүргийн бүс 46.8 км хавтгай дөрвөлжин (Тяньжин далайн боомтын

баталгаат татварын бүсийн далайн гармын хэсэг болон баталгаат татварын ложистикийн бүс 4 км хавтгай дөрвөлжин) тус тус байна.

Чиг үүргийн төлөвлөлт:

-Бүс нутгийн байршуулалтын төлөвлөлтийн дагуу, Тяньжин далайн гармын дүүргийн бүсэд голлон усан тээвэр ложистикийн, ОУ-ын худалдаа, санхүүжилтийн лизинг гэх мэт орчин үеийн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх;

-Тяньжин нисэх буудлын дүүргийн бүсэд голлон агаарын орон зайн, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, шинэ нэг үеийн мэдээллийн технологи гэх мэт өндөр чанартай үйлдвэрлэлийн салбар хөгжүүлэлт, судалгаа, зураг төслийн, агаарын тээвэр ложистик гэх мэт үйлдвэрлэлийн шинж чанартай үйлчилгээний салбарыг бий болгох;

-Бихай шинэ бүсийн төв худалдааны дүүргийн бүсэд голлон санхүүгийн инновацын гол орчин үеийн үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх.

**“Фүжиан” чөлөөт худалдааны туршилтын бүс:**

Стратегийн байршил:

-Эргэн тойрны хоёр эргийн зогсох цэг, улсын хэмжээнд үйлчлэх, дэлхий ертөнцтэй харилцах стратегийн шаардлага зэргийг үндэслэн, шинэчлэлтээр тэргүүлэх давуу талыг онцгойлон бүрэн гаргах;

-ОУ-ын зах зээлийн, хууль дээдлэх бизнес худалдааны орчныг бий болгох;

-Чөлөөт худалдааны туршилтын бүсийн бүтээн байгуулалтыг өөрчлөлт шинэчлэлтийн туршилтын талбайг бий болгох;

-Тайваний давуу талыг бүрэн дүүрэн гаргаж, тэргүүлэх байдлыг ахиулах болон Тайваний бүсийн хөрөнгө оруулалт худалдааны чөлөөтэй болгох;

-Чөлөөт худалдааны туршилтын бүсийн бүтээн байгуулалтыг гүнзгийрүүлэн хоёр эргийн эдийн засгийн хамтын ажиллагааны жишиг бүсийг бий болгох;

-Гадаадад нээлттэй өмнөд эргийн давуу талыг бүрэн дүүрэн онцгойлон гаргах, 21-р зууны Шанхайн торгоны замын гол цөм бүсийг бүтээн байгуулах, 21-р зууны Шанхайн торгоны замын хил хязгаарын улсууд болон бүсийн нээлттэй хамтын ажиллагааны шинэ түвшнийг тогтоох.

Хөгжлийн зорилго:

-Нээлттэй байдлыг өргөжүүлэх болон шинэчлэлийг гүнзгийрүүлэн нэгтгэх, чиг үүргийг төлөвшүүлэх болон системийн инновацыг нэгтгэх байдлыг тууштай дэмжих;

-ЗГ-ын чиг үүргийн шилжилтийг хурдтай хийх, ОУ-ын хөрөнгө оруулалт худалдааны зарчимд нийлүүлсэн шинэ тогтолцоог бүтээн бий болгох;

-Хоёр эргийн хамтын ажиллагааны механизмыг шинэчлэх;

-Бараа, үйлчилгээ, сангууд, хүмүүс гэх мэт төрөл бүрийн гол хүчин зүйлсийн чөлөөтэй урсгалыг ахиулах, Фүжиан Тайванийн эдийн засгийн харилцааг хүчтэй нэмэгдүүлэх;

-Улам илүү өндөр түвшинд гадаадад нээлттэй шинэ хэв маягийг хурдтай бүрэлдүүлэн бий болгох, 21-р зууны Шанхайн торгоны замын хил хязгаарын улсууд болон бүсийн харилцаа хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх болон өргөтгөн өргөжүүлэх, хөгжүүлэх;

-Ойрын 15 жилийн шинэчлэлийн хайн судлах ажлаар дамжуулан, хөрөнгө оруулалт

худалдааг хөнгөвчлөх, санхүүгийн инновацын чиг үүргийг онцгойлон гаргах, үйлчилгээний тогтолцоог бүрэн төгс болгох, үр дүн бүхий тохиромжтой хяналт удирдлага, хуулийн хязгаарлалттай орчны цар хүрээ бүхий чөлөөт худалдааны бүсийн бүтээн байгуулалтыг хийх.

Хэрэгжүүлэх цар хүрээ:

Чөлөөт худалдааны туршилтын бүсийг хэрэгжүүлэх цар хүрээ нь 118.04 км хавтгай дөрвөлжин байх ба гурван дүүргийн бүс нутгийг хамруулна. Үүнд:

Пиньтан дүүргийн бүс 43 км хавтгай дөрвөлжин, Сиамэн дүүргийн бүс 43.78 км хавтгай дөрвөлжин (Сианьүй баталгаат татварын бүс 0.6 км хавтгай дөрвөлжин, Сианьүй баталгаат татварын ложистикийн бүс 0.7 км хавтгай дөрвөлжин, Сиамэний Хайцань баталгаат татварын далайн гармын бүсийн 9.51 км хавтгай дөрвөлжин), Фүжөү дүүргийн бүсийн 31.26 км хавтгай дөрвөлжин (Фүжөү баталгаат татварын бүс 0.6 км хавтгай дөрвөлжин, Фүжөү экспортын боловсруулах бүсийн 1.14 км хавтгай дөрвөлжин, Фүжөү баталгаат татварын далайн гармын бүс 9.26 км хавтгай дөрвөлжин) тус тус байна.

Чиг үүргийн төлөвлөлт:

-Бүс нутгийн байршлын төлөвлөлтийн дагуу, Пиньтан дүүргийн бүсэд голлон хоёр эргийн нэгдсэн хүрээлэн болон ОУ-ын аялал жуулчлалын арлыг бүтээн байгуулах, хөрөнгө оруулалт худалдааны болон сангуудын ажилчдын харилцааны талаар улам илүү чөлөөттэй хөнгөвчилсөн арга хэмжээг хэрэгжүүлэх;

-Сиамэний дүүргийн бүсэд голлон хоёр эргийн цоо шинэ аж үйлдвэр болон орчин үеийн үйлчилгээний салбарын хамтын ажиллагааны жишиг бүс, Дуньнаны ОУ-ын усан тээврийн төв, хоёр эргийн бүс нутгийн шинжтэй санхүүгийн үйлчилгээний төв болон худалдааны төвийг бүтээн байгуулах;

-Фүжөү дүүргийн бүсэд голлон тэргүүлэх үйлдвэрлэлийн салбарын үндсэн суурь газар, 21-р зууны Шанхайн торгоны замын хил хязгаарын улсууд болон бүсийн харилцаа хамтын ажиллагааны чухал жишиг, хоёр эргийн үйлчилгээ худалдааны болон санхүүгийн инновацын хамтын ажиллагааны жишиг бүсийг бүтээн байгуулах.

**“Лиаонинь” чөлөөт худалдааны туршилтын бүс:**

Стратегийн байршил:

-Системийн шинэчлэлийг гол цөм болгож, хуулбарлах өргөжүүлэх боломжийг үндсэн шаардлага болгож, зах зээлд чиглэсэн тогтолцооны механизмын шинэчлэл, бүтцийн тохируулалтыг идэвхтэй урагшлуулах байдлыг хурдасгах;

-Чөлөөт худалдааны туршилтын бүсийн бүтээн байгуулалтыг зүүн хойд хуучин аж үйлдвэрийн суурь газрыг хөгжүүлэх ерөнхий өрсөлдөх хүч болон гадаадад нээлттэй байх түвшний шинэ хөдөлгүүр зэргийг сайжруулах бий болгох.

Хөгжлийн зорилго:

Ойрын 15 жилийн шинэчлэлийг судлан, ОУ-ын хөрөнгө оруулалт, худалдааны нэвтрэлцэх зарчимтай холбогдсон системийн шинэчилсэн тогтолцоог бүрэлдүүлэн бий болгох;

-Хууль дээдлэх, ОУ-ын хөнгөвчилсөн бизнес худалдааны орчныг бий болгох, хүний чадвар, хөрөнгө гэх мэт гол хүчин зүйлсийг хослуулан хөгжүүлэх;

-Өндөр чадвартай аж үйлдвэрийн төвлөрөл, худалдааг хөнгөвчилсөн байдал, санхүүгийн үйлчилгээг төгс сайжруулахад тохиромжтой хяналт удирдлага, хууль дээдлэх орчны цар хүрээ бүхий өндөр түвшний стандартыг чөлөөт худалдааны бүсийг бүтээн байгуулахад ашиглах;

-Зүүн хойд бүсийн шилжилтийн эдийн засгийн хөгжлийн хэлбэрийг татан чиглүүлэх, эдийн засгийн хөгжлийн чанар болон түвшнийг сайжруулах.

Хэрэгжүүлэх цар хүрээ:

Чөлөөт худалдааны бүсийг хэрэгжүүлэх цар хүрээ нь 119.89 км хавтгай дөрвөлжин газар нутаг байх ба 3 дүүргийн бүс нутгийг хамруулна. Үүнд:

Далианы дүүргийн бүс 59.96 км хавтгай дөрвөлжин (Далиан баталгаат татварын бүс 1.25 км хавтгай дөрвөлжин, Далиан экспортын боловсруулах бүсийн 2.95 км хавтгай дөрвөлжин, Далиан Даяаован баталгаат татварын далайн боомтын гармын бүс 6.88 ЛЙ^), Шэнянь дүүргийн бүс 29.97 км хавтгай дөрвөлжин, Инькоү дүүргийн бүс 29.96 км хавтгай дөрвөлжин тус тус байна.

Чиг үүргийн төлөвлөлт:

Бүс нутгийн байршуулалтын төлөвлөлтийн дагуу Далиан дүүргийн бүсэд голлон далайн гармын усан тээврийн ложистик, санхүүгийн худалдаа, тэргүүлэх тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, өндөр шинэ технологи, эдийн засгийн тойрог, усан тээврийн үйлчилгээ гэх мэт салбаруудыг хөгжүүлэх;

-Зүүн хойд Азийн ОУ-ын усан тээврийн төв, ОУ-ын ложистикийн төв зэргийг бүтээн байгуулах үйл явцыг урагшлуулах;

-Зүүн хойд Азийн нээлттэй хамтын ажиллагааны стратегийн өндөрлөг газрыг бүрэлдүүлэн бий болгох;

-Шэнянь дүүргийн бүсэд голлон тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, авто машин болон сэлбэг, агаарын орон зайн тоног төхөөрөмж гэх мэт тэргүүлэх үйлдвэрлэлийн салбарууд болон санхүү, ШУ технологи, логистик гэх мэт орчин үеийн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх;

-Улсдаа шинэ хэлбэрийн аж үйлдвэржилтийн жишиг хот болгоход зүүн хойд бүсийн ШУ технологийн шинэчлэлийн төвийн хөгжлийн түвшнийг сайжруулах;

-ОУ-ын өрсөлдөх хүч бүхий тэргүүлэх тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн салбарын суурь газрыг бүтээн байгуулах;

-Ийнькоү дүүргийн бүсэд голлон худалдааны ложистик, хил дамнасан цахим худалдаа, санхүүгийн гэх мэт орчин үеийн үйлчилгээний салбарууд болон шинэ нэг үеийн мэдээллийн технологи, өндөр чанартай тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл гэх мэт стратегийн шинжтэй цоо шинэ аж үйлдвэрийг хөгжүүлэх;

-Бүс нутгийн шинжтэй ОУ-ын ложистикийн төв болон өндөр чанартай тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, өндөр шинэ технологийн аж үйлдвэрийн суурт газрыг бүтээн байгуулах. ОУ-ын далай, төмөр зам хосолсон тээврийн том нэвтрүүлэх суваг бүхий гол чухал зангилаа төвийг бүрэлдүүлэн бий болгох.

**“Жэжиань” чөлөөт худалдааны туршилтын бүс:**

Стратегийн байршил:

Системийн шинэчлэлийг гол цөм болгож, хуулбарлах өргөжүүлэх боломжийг үндсэн шаардлага болгож, чөлөөт худалдааны туршилтын бүсийн бүтээн байгуулалтыг зүүн хэсгийн газар орны чухал далай дээрх нээлттэй хаалга бүхий жишиг бүс, ОУ-ын бөөний барааны худалдааны чөлөөт байдлаар тэргүүлэх бүс болон ОУ-д нөлөөлөх хүч бүхий нөөцийн бүрэлдэхүүн суурь газар байна.

Хөгжлийн зорилго:

-Гурван жил орчим хугацаанд судалснаар ерөнхийдөө хөрөнгө оруулалт худалдааг хөнгөвчлөх, өндөр чанартай аж үйлдвэрийн төвлөрөл, хууль дүрэм бүхий орчны цар хүрээ, санхүүгийн үйлчилгээг төгс сайжруулах, үр дүн бүхий тохиромжтой удирдлагын үр нөлөөг онцгойлон гаргах зэргийг хэрэгжүүлэх;

-Газрын тосны бүтээгдэхүүнийг гол цөм болгож, бөөний бараа бүтээгдэхүүнийг дэлхийд түгээх хүчин чадлыг тодорхой сайжруулах;

-ОУ-ын стандарттай холбох чөлөөт худалдааны далайн гармын тэргүүлэх бүсийн эхний алхмыг бүтээн байгуулах зэрэг багтана.

Хэрэгжүүлэх цар хүрээ:

Чөлөөт худалдааны туршилтын бүсийн хэрэгжүүлэх цар хүрээ нь 119.95 км хавтгай дөрвөлжин нутаг байна. Эх газар нутгаас болон холбогдох далайн тулгуур бүрэлдэхүүнтэй гурван дүүргийн бүсийг хамруулна. Үүнд:

Жөүшаны арлын дүүргийн бүс 78.98 км хавтгай дөрвөлжин (Жөүшан далайн гармын нэгдсэн баталгаат татварын бүсийн 2-р бүс 3.02 км хавтгай дөрвөлжин), Жөүшаны арлын хойд хэсгийн дүүргийн бүс 15.62 км хавтгай дөрвөлжин (Жөүшан далайн гармын нэгдсэн баталгаат татварын бүсийн 1-р бүс 2.83 км хавтгай дөрвөлжин), Жөүшаны арлын өмнөд хэсгийн дүүргийн бүс 25.35 км хавтгай дөрвөлжин тус тус байна.

Чиг үүргийн төлөвлөлт:

-Бүс нутгийн байршуулалтын төлөвлөлтийн дагуу, Жөүшаны арлын дүүргийн бүсийн Үйшан аралд голлон ОУ-ын нэг урсгал бүхий эко нефть химийн суурь газрыг бүтээн байгуулах;

-Шүланьхү, Хуаньзэшан, Шуаньзишан, Чүшан, Сиаочүшан, Мажишан зэрэг арлуудыг голлон газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, дамжуулалт, худалдааны аж үйлдвэрийн чиглэлээр хөгжүүлэх;

-Далайн тулгуур газруудад голлон баталгаат түлш, газрын тосны нийлүүлэлтийн үйлчилгээг хөгжүүлэх;

-Жөүшаны арлын хойд хэсгийн дүүргийн бүсэд голлон газрын тосны бүтээгдэхүүний худалдаа, баталгаат түлш, газрын тосны нийлүүлэлт, газрын тосны химийн аж үйлдвэрийн бүрэлдэхүүний тоног төхөөрөмж, тээвэр ложистик, агуулах, үйлдвэрлэл гэх мэт аж үйлдвэрийг хөгжүүлэх;

-Жөүшаны арлын өмнөд хэсгийн дүүргийн бүсэд голлон бөөний бүтээгдэхүүний харилцаа, агаарын орон зайн үйлдвэрлэл, сэлбэг эд ангийн ложистик, судалгаа хөгжүүлэлт, зураг төсөл болон холбогдох бүрэлдэхүүн аж үйлдвэрийг хөгжүүлэх;

-Жөүшан агаарын орон зайн аж үйлдвэрийн паркийг бүтээн байгуулах. Усан бүтээгдэхүүний худалдаа, далайн аялал жуулчлал, далайн усыг ашиглах, орчин үеийн худалдаа, санхүүгийн үйлчилгээ, усан тээвэр, мэдээллийн зөвлөгөө, өндөр шинэ технологи

гэх мэт аж үйлдвэрийг хөгжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлнэ.

**“Хэнан” чөлөөт худалдааны туршилтын бүс:**

Стратегийн байршил:

-Системийн шинэчлэлийг өргөжүүлэх боломжийг үндсэн шаардлага болгож, өмнөдөөс умард руу нэвтрэх, зүүнээс баруунд холбох орчин үеийн гурав хэмжээст зам харилцааны систем болон орчин үеийн ложистикийн тогтолцоог хурдтай бүтээн байгуулах;

-Чөлөөт худалдааны туршилтын бүсийн бүтээн байгуулалтыг “Бүс ба зам” бүтээн байгуулалтын орчин үеийн нэгдсэн зам харилцааны зангилаа төвүүд, нээлттэй туршилтын талбай болон дотоодын эх газрын нээлттэй хэлбэрийн эдийн засгийн жишиг бүсийг бүх талаар шинэчлэхэд үйлчилж байхаар бий болгох.

Хөгжлийн зорилго:

Ойрын 15 жилийн шинэчлэлийг судалж, ОУ-ын хөрөнгө оруулалт, худалдааны нэвтрэлцэх зарчим бүхий системийн шинэчлэлийн тогтолцоог бүрэлдүүлэн бий болгох, хууль дээдлэх, ОУ-ын, бизнес худалдааны орчинг бий болгох;

-Чөлөөт худалдааны туршилтын бүсийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, худалдааг хөнгөвчлөх, өндөр чанартай аж үйлдвэрт төвлөрөх, зам харилцаа ложистикийг нэвтрүүлэх, үр дүн бүхий тохиромжтой удирдлагыг чиглүүлэх үр нөлөөг онцгойлон гаргах, өндөр стандартын чөлөөт худалдааны бүсийг бий болгох;

-Дотоодын эх газрын эдийн засгийн хөгжлийн шилжилт рүү чиглүүлэх, бүх талаар гадаадад нээлттэй байх шинэ хэв маягийг бүрэлдүүлэн бий болгох ажлыг урагшлуулах.

Хэрэгжүүлэх цар хүрээ:

Чөлөөт худалдааны туршилтын бүсийн хэрэгжүүлэх цар хүрээ 119.77 км хавтгай дөрвөлжин газар нутагтай байх ба гурван дүүргийн бүсийг хамарна. Үүнд:

Жэньжөү дүүргийн бүс 73.17 км хавтгай дөрвөлжин (Хэнан Жэнжөү экспортын боловсруулалтын бүсийн А бүс 0.89 км хавтгай дөрвөлжин, Хэнан баталгаат татварын ложистикийн төв 0.41 км хавтгай дөрвөлжин), Кайфэнь дүүргийн бүс 19.94 км хавтгай дөрвөлжин, Луоянь талбай 26.66 км хавтгай дөрвөлжин тус тус байна.

Чиг үүргийн төлөвлөлт:

-Бүс нутгийн байршуулалтын төлөвлөлтийн дагуу, Жэньжөү талбайд голлон ухаалаг терминал, өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж болон авто машины үйлдвэрлэл, био эм эмнэлэг гэх мэт тэргүүлэх үйлдвэрлэлийн салбарыг болон орчин үеийн ложистик, ОУ-ын худалдаа, хил дамнасан цахим худалдаа, орчин үеийн санхүүгийн үйлчилгээ, үйлчилгээний гадаад эх үүсвэр, бүтээлийн зураг төсөл, худалдаа үйлчилгээний үзэсгэлэн, анимэ видео тоглоом гэх мэт орчин үеийн үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх;

-Зам харилцаа ложистикийн нэгдсэн хөгжил болон хөрөнгө оруулалт худалдааны хөнгөлөлтийн талаар тогтолцооны механизмын шинэчлэлийг урагшлуулах ажлыг идэвхижүүлэх;

-Олон хэлбэрт хосолсон тээврийн ОУ-ын шинжтэй ложистикийн төвийг бий болгох, “Бүс ба зам”-ын бүтээн байгуулалтад үйлчлэх орчин үеийн нэгдсэн зам харилцааны зангилаа төвийн үр нөлөөг онцгойлон гаргах;

-Кайфэнь талбайд голлон үйлчилгээний гадаад эх үүсвэр, эмчилгээний аялал

жуулчлал, бүтээлийн зураг төсөл, соёл хэвлэл мэдээлэл, соёл санхүүгийн, гар урлалын бүтээгдэхүүний арилжаа, орчин үеийн ложистик гэх мэт үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх;

-Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, ХАА-н туслах бүтээгдэхүүний боловсруулах ОУ-ын хамтын ажиллагаа болон худалдааны хүчин чадлыг дээшлүүлэх;

-ОУ-ын соёл бүхий худалдаа болон хүний соёл аялал жуулчлалын хамтын ажиллагааны жишгийг бүрдүүлэн бий болгох;

-Үйлчилгээний худалдааны шинэчлэлийн хөгжлийн бүс болон соёлын бүтээлийн салбарыг гадаадад нээлттэй тэргүүлэх бүсийг бий болгох, ОУ-ын аялал жуулчлалын нэгдсэн хөгжлийг идэвхжүүлэх;

-Лүоянь талбайд голлон тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, робот, шинэ материалын гэх мэт өндөр чанартай үйлдвэрлэлийн салбар болон судалгаа хөгжүүлэлт зураг төсөл, цахим худалдаа, үйлчилгээний гадаад эх үүсвэр, ОУ-ын аялал жуулчлал, соёлын бүтээл, түүх соёлын худалдаа, түүх соёлын үзэсгэлэн гэх мэт орчин үеийн үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх;

-Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн салбарын хувиралтыг шинэчлэх хүчин чадал болон ОУ-ын чадамжид хамтын ажиллагааны хүчин чадлыг сайжруулах;

-ОУ-ын ухаалаг үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны жишиг бүсийг бий болгох, Хуасиа түүхэн соёл иргэншлийн өвийн инновацын бүсийн бүтээн байгуулалтыг урагшлуулах зэрэг болно.

**“Хубэй” чөлөөт худалдааны туршилтын бүс:**

Стратегийн байршил:

Системийн шинэчлэлийг гол цөм болгон, өргөжүүлэх боломжийг үндсэн шаардлага болгож, төвлөрсөн хэсгийн бүх улсад түгээн дэлгэрсэн, дэлхий рүү алхах тулгуур цэг байна. Төвлөрсөн хэсгүүдэд шат дараатайгаар холбогдох аж үйлдвэрийн шилжилтийн жишиг бүс, стратегийн шинжтэй цоо шинэ аж үйлдвэрийн болон өндөр технологит суурилсан бүс, нээлттэй туршилтын талбайг бүх талаар шинэлэх болон дотоодын эх газрын гадаадад нээлттэй шинэ өндөрлөг газрыг бий болгоход анхаарна.

Хөгжлийн зорилго:

-Ойрын 15 жилийн шинэчлэлийг судалж, ОУ-ын хөрөнгө оруулалт, худалдааны нэвтрэлцэх зарчим бүхий системийн шинэчлэлийн тогтолцоог бүрэлдүүлэн бий болгох, хууль дээдлэх, ОУ-ын, бизнес худалдааны орчинг бий болгох;

-Өндөр чанартай аж үйлдвэрийн төвлөрөл, аж ахуй эрхлэх үйл ажиллагааны шинэчлэл, санхүүгийн үйлчилгээг сайжруулах, үр дүнтэй тохиромжтой хяналт удирдлага, чиглүүлэн жолоодох үр нөлөөг онцгойлон гаргах;

-Төвийн хэсэгт өсөлтийн стратегийг хэрэгжүүлэх болон Янцэ мөрний эдийн засгийн бүсийн хөгжлийг урагшлуулах жишиг үр нөлөөг онцгойлон гаргах;

Хэрэгжүүлэх цар хүрээ:

-Чөлөөт худалдааны туршилтын бүсийн хэрэгжүүлэх цар хүрээ 119.96 км хавтгай дөрвөлжин газар нутагтай байх ба гурван дүүргийн бүсийг хамарна. Үүнд:

Уханы талбай 70 км хавтгай дөрвөлжин (Ухан Дуньхү нэгдсэн баталгаат татварын бүс 5.41 км хавтгай дөрвөлжин), Сианьянь талбай 21.99 км хавтгай дөрвөлжин (Сианьянь

баталгаат татварын ложистикийн төв “В хэлбэр” 0.281 км хавтгай дөрвөлжин), Ичань талбай 27.97 км хавтгай дөрвөлжин тус тус байна.

Чиг үүргийн төлөвлөлт:

Бүс нутгийн байршуулалтын төлөвлөлтийн дагуу, Уханы талбайд голлон шинэ үеийн мэдээллийн технологи, ахуйн эрүүл мэнд, ухаалаг үйлдвэрлэл гэх мэт стратегийн шинжтэй цоо шинэ аж үйлдвэр болон ОУ-ын худалдаа, санхүүгийн үйлчилгээ, орчин үеийн ложистик, хяналт шалтгалтын, судалгаа хөгжүүлэлт зураг төслийн, мэдээллийн үйлчилгээний, мэргэжлийн үйлчилгээний гэх мэт орчин үеийн үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх;

-Сианьянь талбайд голлон өндөр чанартай тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, шинэ энергийн эх үүсвэрт авто машин, дата, тооцоолол, худалдааны ложистик, хяналт шалгалтын гэх мэт салбаруудыг хөгжүүлэх;

-Ичаний талбайд голлон тэргүүлэх үйлдвэрлэл, био эм бэлдмэл, цахим мэдээлэл, шинэ материалын гэх мэт өндөр шинэ аж үйлдвэр болон судалгаа хөгжүүлэлт зураг төсөл, ерөнхий эдийн засгийн, цахим худалдаа үйлчилгээний гэх мэт орчин үеийн үйлчилгээний салбаруудыг хөгжүүлнэ.

**“Чуньчинь” чөлөөт худалдааны туршилтын бүс:**

Стратегийн байршил:

Системийн шинэчлэлийг гол цөм болгон өргөжүүлэх боломжийг үндсэн шаардлага болгож, намын төв хороо, ЗГ-ын зүгээс Чуньчиний стратегийг дэмжих төвийг онцгойлон гаргах болон төвүүдийн гол чухал үр нөлөөг холбох тухай баруун хэсгийн бүсийн үүд хаалга бүхий хотын нээлттэй байх хүчний хэмжээ шаардлагыг бүх талаар хэрэгжүүлэх;

-Чөлөөт худалдааны туршилтын бүсийн бүтээн байгуулалтыг “Бүс ба зам” болон Янцэ мөрний эдийн засгийн бүсэд харилцан нэвтрэлцэх чухал ач холбогдол бүхий зангилаа төвүүдийг баруун хэсгийн нээлттэй стратегийг дэмжих төв болгоход чармайх;

Хөгжлийн зорилго:

Ойрын 15 жилийн шинэчлэлийг судалж, хөрөнгө оруулалт, худалдааг хөнгөвчлөх, өндөр чанартай аж үйлдвэрийн төвлөрөл, үр дүнтэй хяналтын удирдлага, санхүүгийн үйлчилгээний төгс хэлбэр, хууль дээдлэх орчны цар хүрээ, удирдан чиглүүлэх үр нөлөөг онцгойлон гаргасан өндөр стандартын чөлөөт худалдааны бүсийг бүтээн байгуулахад чармайх;

-“Бүс ба зам” бүтээн байгуулалтад үйлчлэх болон Янцэ мөрний эдийн засгийн бүсийн хөгжлийн ОУ-ын ложистикийн зангилаа төв болон боомтын өндөрлөг газрыг бүтээн байгуулахад чармайх;

-Баруун бүсийн үүд хаалга бүхий хотуудын нээлттэй шинэ хэв маягийг бүрэлдүүлэн бий болгох ажлыг урагшлуулах;

-Баруун бүсийг удирдан чиглүүлэх нээлттэй стратегийг өндөр түвшинд хэрэгжүүлэх;

Хэрэгжүүлэх цар хүрээ:

Чөлөөт худалдааны туршилтын бүсийн хэрэгжүүлэх цар хүрээ нь 119.98 км хавтгай

дөрвөлжин байх ба гурван талбайг хамарна. Үүнд:

Хоёр мөрний талбай 66.29 км хавтгай дөрвөлжин (Чуньчинь хоёр замын Цүнтан баталгаат татварын далайн гармын бүс 8.37 км хавтгай дөрвөлжин), Сиюүнь талбай 22.81 км хавтгай дөрвөлжин (Чуньчинь Сиюүнь нэгдсэн баталгаат татварын бүс 8.8 км хавтгай дөрвөлжин, Чуньчинь төмөр замын баталгаат татварын ложистикийн төв "В хэлбэр" 0.15 км хавтгай дөрвөлжин), Гүоюүэн далайн гармын талбай 30.88 км хавтгай дөрвөлжин тус тус байна.

Чиг үүргийн төлөвлөлт:

Бүс нутгийн байршил, төлөвлөлтийн дагуу Хоёр мөрний талбайд өндөр хүчин чадалтай аж үйлдвэр бүхий төвлөрсөн бүсийг байгуулахад анхаарлаа хандуулах, орчин үеийн тоног төхөөрөмж, цахилгаан, сэлбэг хэрэгсэл, эд анги, био эм бэлдмэл гэх мэт цоо шинэ аж үйлдвэр болон ерөнхий хэсгийн худалдаа, үйлчилгээний худалдаа, цахим худалдаа, дэлгэцэн арилжаа, агуулах түгээлтийн терминал, мэргэжлийн үйлчилгээ, санхүүгийн лизинг, судалгаа хөгжүүлэлт зураг төсөл гэх мэт орчин үеийн үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх.

-Ложистик, технологи, хөрөнгө, хүний чадвар гэх мэт гол хүчин зүйлсийн нөөцийн төвлөрөн цацрах хүчин чадлыг нэмэн бэхжүүлэх;

-Сиюүнь талбайд боловсруулалт худалдааны шилжилтийг дээшлүүлсэн жишиг бүсийг барьж байгуулахад анхаарлаа хандуулах, голлон цахим мэдээлэл, ухаалаг тоног төхөөрөмж гэх мэт үйлдвэрлэлийн салбар болон баталгаат татварын ложистикийн дамжин өнгөрөх түгээх гэх мэт үйлдвэрлэлийн шинжтэй үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх;

-Боловсруулалт худалдааны хөгжлийн оновчтой загварчлах;

-Гүоюүэн далайн гармын талбайд олон хэлбэрийн хосолсон тээвэр ложистикийн шилжилтийн төвийг байгуулахад анхаарч, голлон ОУ-ын дамжин өнгөрөх, төвлөрүүлэн түгээх гэх мэт үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх;

-Тэргүүлэх үйлдвэрлэлийн салбарын инновацын хөгжлийг судлах.

**"Сичуань" чөлөөт худалдааны туршилтын бүс:**

Стратегийн байршил:

Системийн шинэчлэлийг гол цөм болгон, тэдгээрийг өргөжүүлэх боломжийг үндсэн шаардлага болгож, дотоодын эх газрын эдийн засгийн тулах цэг болох зүүн бүсээс баруун бүс рүү тээвэрлэлт хийх боломж нээгдэнэ.

-Чөлөөт худалдааны туршилтын бүсийн бүтээн байгуулалтыг баруун хэсгийн үүд хаалга бүхий хотын хөгжлийн нээлттэй татан чиглүүлэх бүс, эх газрын нээлттэй стратегийг дэмжих тэргүүлэх бүс, ОУ-ын нээлттэй нэвтрэх зангилаа төв бүс, эх газрын нээлттэй хэлбэрийн эдийн засгийн шинэ өндөрлөг, эх газрын болон хил хязгаар, далайн эргийн хамтын ажиллагааны нээлттэй жишиг бүсийг бий болгох.

Хөгжлийн зорилго:

-Ойрын 15 жилийн шинэчлэлийг судалснаар хууль дээдлэх, хөрөнгө оруулалт худалдааг хөнгөвчлөх, инновацын гол хүчин зүйлс төвлөрсөн үр дүнтэй удирдлага зохион байгуулалт, хамтын ажиллагааны нээлттэй бүсийг бүтээн байгуулахад хичээх;

-Эх газрын нээлттэй хэлбэрийн эдийн засгийн тулгуур цэгийг барьж байгуулах,

баруун хэсгийн нээлттэй байдлыг гүнзгийрүүлэх болон Янцэ мөрний эдийн засгийн бүсийн хөгжлийг онцгойлон гаргах;

Хэрэгжүүлэх цар хүрээ:

Чөлөөт худалдааны бүсийн хэрэгжүүлэх цар хүрээ нь 119.99 км хавтгай дөрвөлжин газартай байх ба гурван талбайг хамруулна. Үүнд:

Чэньдү Тианфү шинэ бүсийн талбай 90.32 км хавтгай дөрвөлжин (Чэньдү өндөр шинэ нэгдсэн баталгаат татварын бүсийн 4-р хэсэг “хоёр урсгал бүхий бүс” 4 км хавтгай дөрвөлжин, Чэньдү агаарын гарцын баталгаат татварын ложистикийн төв “B хэлбэр” 0.09 км хавтгай дөрвөлжин), Чэньдү Чиньбайжиань төмөр замын гармын талбай 9.68 км хавтгай дөрвөлжин (Чэньдү төмөр замын баталгаат татварын ложистикийн төв “B хэлбэр” 0.18 км хавтгай дөрвөлжин), Чуаний өмнөд хяналтын гармын талбай 19.99 км хавтгай дөрвөлжин (Лүжөү гармын баталгаат татварын ложистикийн төв “B хэлбэр” 0.21 км хавтгай дөрвөлжин) тус тус байна.

Чиг үүргийн төлөвлөлт:

-Бүс нутгийн байршил, төлөвлөлтийн дагуу шинэ бүсийн талбайд Чэньдү, Тианфү зэрэг голлон орчин үеийн үйлчилгээний салбарууд болон өндөр хүчин чадалтай үйлдвэрлэлийн салбар, технологийн болон агаарын хяналтын, эдийн засгийн, боомтын үйлчилгээний гэх мэт чиглэлүүдээр хөгжүүлэх;

-Орчин үеийн аж үйлдвэрийн төвлөрсөн бүс, инновацад суурилсан хөгжлийн тэргүүлэх бүс, нээлттэй хэлбэрийн санхүүгийн салбарын инновацын газар, худалдаа ложистикийн төв болон ОУ-ын шинжтэй агаарын тээврийн зангилаа төв зэргийг бүтээн байгуулах;

-Баруун бүсийн үүд хаалга бүхий хотуудын нээлттэй худалдааны газрыг бий болгох;

-Чэньдү Чиньбайжиань төмөр замын гарам бүхий талбайд голлон ОУ-ын худалдааны бүтээгдэхүүнийг төвлөрүүлэх, дамжин өнгөрүүлэх, тээвэрлэх, түгээх, баталгаат татварын ложистикийн агуулах, ОУ-ын ачаа тээвэр, тээврийн хэрэгслийн импорт, тусгай санхүүгийн гэх мэт боомтын үйлчилгээний салбарууд болон мэдээллийн үйлчилгээ, ШУ технологийн үйлчилгээ, үзэсгэлэнгийн үйлчилгээ гэх мэт орчин үеийн үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх;

-Эх газрын торгоны замын эдийн засгийн бүсийн баруунаас чиглэсэн ОУ-ын худалдааны сувгийг дэмжих;

-Сичуаний өмнөд хяналтын гармын талбайд голлон усан тээврийн ложистик, далайн боомтын худалдаа, боловсрол, эм эмнэлэг гэх мэт орчин үеийн үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх. Мөн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, эм бэлдмэл, хүнс ундаа гэх мэт тэргүүлэх болон онцгой давуу тал бүхий аж үйлдвэрүүдийг бий болгох;

Бүс нутгийн шинжтэй нэгдсэн зам харилцааны зангилаа төв болон Чэньдү-Чуньчинь хотуудын эдийн засгийн урсгал өмнөд рүү буюу Юннан-Гүйжөү хотууд руу чиглэсэн гарцыг байгуулах.

**“Шанси” чөлөөт худалдааны туршилтын бүс:**

Стратегийн байршил:

-Системийн шинэчлэлийг өргөжүүлэх боломжийг үндсэн шаардлага болгож,

Хятадын намын төв хороо, ЗГ-ын “Бүс ба зам”-ын бүтээн байгуулалтыг онцгойлон, баруун бүс рүү хөгжлийг чиглүүлэх, баруун бүсийн үүд хаалга бүхий хотын нээлттэй байдлыг нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлэх;

-Чөлөөт худалдааны туршилтын бүсийг шинэчлэн, нээлттэй туршилтын талбар, эдийн засгийн хамтын ажиллагааны болон харилцааны төв болгон бүтээн байгуулахад чармайх.

Хөгжлийн зорилго:

-Ойрын 15 жилийн шинэчлэлийг судалж, ОУ-ын хөрөнгө оруулалт, худалдааны нэвтрэх зарчимтай холбогдсон системийн шинэчлэлийн тогтолцоог бүрэлдүүлэн бий болгох;

-Хууль дээдлэх, ОУ-ын хөнгөвчилсөн бизнес худалдааны орчныг бий болгох, хөрөнгө оруулалт, худалдааг хөнгөвчлөх, өндөр хүчин чадалтай аж үйлдвэрийн төвлөрөл, санхүүгийн үйлчилгээг сайжруулах, соёлын харилцааг гүнзгийрүүлэх, хууль дээдлэх түвшний өндөр стандартын чөлөөт худалдааны бүсийг бүтээн байгуулахад чармайх;

“Бүс ба зам” бүтээн байгуулалтыг урагшлуулж, баруун бүсийн томоохон хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх.

Хэрэгжүүлэх цар хүрээ:

Чөлөөт худалдааны бүсийн хэрэгжүүлэх цар хүрээ нь 119.95 км хавтгай дөрвөлжин байх ба гурван хэсэг талбайг хамруулна. Үүнд:

Төв талбай 87.76 км хавтгай дөрвөлжин (Шанси Сиан экспортын боловсруулах бүсийн А хэсэг 0.75 км хавтгай дөрвөлжин, В хэсэг 0.79 км хавтгай дөрвөлжин, Сиан өндөр шинэ нэгдсэн баталгаат татварын бүс 3.64 км хавтгай дөрвөлжин болон Шанси Сичэнь баталгаат татварын ложистикийн төв “В хэлбэр” 0.36 км хавтгай дөрвөлжин), Сиан ОУ-н гармын үйлчилгээний бүсийн талбай 26.43 км хавтгай дөрвөлжин (Сиан нэгдсэн баталгаат татварын бүс 6.17 км хавтгай дөрвөлжин), Яньлинь жишиг бүсийн талбай 5.76 км хавтгай дөрвөлжин тус тус байна.

Чиг үүргийн төлөвлөлт:

Бүс нутгийн байршил, төлөвлөлтийн дагуу, чөлөөт худалдааны туршилтын бүсийн төв талбайд голлон стратегийн шинжтэй цоо шинэ аж үйлдвэр болон өндөр шинэ технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх;

-Өндөр чанартай үйлдвэрлэл, агаарын тээврийн ложистик, худалдааны санхүүжилт гэх мэт аж үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулах;

-Үйлчилгээний худалдааг идэвхжүүлэхэд чиглэсэн тогтолцооны бүтээн байгуулалтыг урагшлуулах;

-Шинжлэх ухаан технологийн, боловсрол, соёлын, аялал жуулчлалын, эрүүл мэнд эмнэлгийн гэх мэт хүний соёлын харилцааг гүнзгийрүүлэх болон өргөжүүлэх байдлыг хөгжүүлэх;

“Бүс ба зам”-ын хүрээнд өндөр хүчин чадал бүхий аж үйлдвэрүүд болон хүний соёлын харилцааны урсгалыг чиглүүлсэн бүтээн байгуулалтуудыг хийх;

“Бүс ба зам”-ын ОУ-ын дамжин өнгөрөх гармыг бүтээн байгуулах, нээлттэй

хэлбэрийн санхүүгийн салбарын инновац болон Евроазийн худалдаа ба соёлын харилцааны хамтын ажиллагааны шинэ жишгийг бий болгох;

-Яньлинь жишиг бүсийн талбайд ХАА, ШУ технологийн инновацийн жишгийг өргөжүүлэхэд голлож, ХАА-н салбарын ОУ-ын хамтын ажиллагааны харилцааг бүх талаар өргөжүүлэх байдлаар дамжин, "Бүс ба зам" орчин үеийн ХАА-н ОУ-ын хамтын ажиллагааны төвийг бий болгох.

**"АСЕАН" чөлөөт худалдааны бүс:**

Хятад-АСЕАН чөлөөт худалдааны бүс нь Хятад болон зүүн өмнөд азийн улсууд буюу АСЕАН (Бруней, Камбож, Индонез, Лаос, Малайз, Мьянмар, Филиппин, Сингапур, Тайланд, Вьетнам)-ний 10 орны хооронд чөлөөт худалдааны бүсийг бий болгосноор "10+1" гэж нэрлэгдэх болсон. Хятад-АСЕАН-ны чөлөөт худалдааны бүс нь Хятад улсын гадаад худалдааны хэлэлцээр бүхий анхны чөлөөт худалдааны бүс бөгөөд бүхэлдээ АСЕАН-ы анхны чөлөөт худалдааны бүс юм.

Тус бүс нь бүтээн байгуулагдсаны хойш 13 сая хавтгай дөрвөлжин км талбайг хамарч, жилд 1.9 тэрбум хүнд ашиг тусаа өгч байна. ДНБ-ний хэмжээ 6 их наяд ам.доллар, жилийн 4.5 их наяд давсан ам.долларын худалдаа. Энэ бол дэлхийн хамгийн хүн амтай чөлөөт худалдааны бүс бөгөөд дэлхийн хөгжиж буй орнуудын байгуулсан хамгийн том чөлөөт худалдааны бүс юм.

1997 оны 12-р сард Хятад болон АСЕАН-ы удирдагчид АСЕАН-Хятад удирдагчдын анхны албан бус уулзалт дээр харилцан итгэлцлийн найрсаг хөршийн түншлэлийг байгуулах бодлогыг тодорхойлсон байна.

Одоогийн байдлаар Хятадын 20 чөлөөт худалдааны бүсийг барьж байгуулж байгаа бөгөөд үүнд 32 улс болон бүс нутаг хамрагдаж байна.

Үүнээс 12 улстай чөлөөт худалдааны гэрээг байгуулсан ба үүнд 20 улсын бүс нутаг хамрагдаад байна. Ангилал нь Хятад болон АСЕАН, Сингапур, Пакистан, Шинэ Зеланд, Чили, Перу, Коста Рика, Исланд, Швейцарь улсуудтай чөлөөт худалдааны гэрээ байгуулсан.

Дотоодын болон Хонгког, Макаотай улам нягт эдийн засаг худалдааны харилцааг тохируулсан (CEPA), мөн эх газар болон Тайваны Хайсиа хоёр тал эдийн засгийн хамтын ажиллагааны бүтцийн хэлэлцээр (ECPA) зэрэг байна.

Яг одоогийн байдлаар 23 улсыг хамарсан чөлөөт худалдааны 9 гэрээг хэлэлцэж байна. Ангилал нь Хятад болон Өмнөд Солонгос, Персийн булан, Арабын хамтын ажиллагааны зөвлөл, Австрали, Шри Ланка, Норвегийн чөлөөт худалдааны гэрээ зэрэг болно. Мөн Хятад, Япон, Өмнөд Солонгосын чөлөөт худалдааны бүс, "Бүс нутгийн бүх талын эдийн засгийн хамтын ажиллагааны түншийн харилцаа" (PCEP)-н гэрээний хэлэлцээр болон Хятад- АСЕАН чөлөөт худалдааны гэрээ ("10+1") сайжруулах хэлэлцээр, Хятад-Пакистан чөлөөт худалдааны гэрээний хоёрдугаар үе шатны хэлэлцээр зэрэг байна.

Үүнээс гадна, Хятад улс, Энэтхэг улсын бүс нутгийн худалдааг тохируулах (PTA) хамтарсан судалгааг хийж дуусгаад байна. Мөн Колумб улс гэх мэт чөлөөт худалдааны бүсийг нээн, хөгжүүлэх хамтарсан боломжит байдлын судалгааг хийж байна.

**§1.2.ОХУ-ын эдийн засгийн тусгай бүсийн үүсэл хөгжил, онол, практикийн асуудал**




ОХУ-д чөлөөт эдийн засаг хөгжиж эхэлсэн 1990 оноос Эдийн засгийн чөлөөт бүс (Free economic zone Свободная экономическая зона)-ийг байгуулах шийдвэр гарсан боловч хууль эрх зүйн орчин нь төдийлөн хангалтгүй байсан тул "Гадаад эдийн засгийг чөлөөтэй болгох тухай" хуулийг 1991 оны 02 дугаар сард, "Гадаад хөрөнгө оруулалтын тухай" хуулийг 1991 оны 07 дугаар сард, Татварын системийн тухай хуулийг 1992 оны 01 дүгээр сард тус тус баталж, эрх зүйн орчныг нь шинээр бий болгосон гэж үздэг.

Хуулийн зорилго нь боловсруулах болон өндөр технологийн салбарын эдийн засгийг хөгжүүлэх, аялал жуулчлал, рашаан-сувиллын орчин, боомт болон тээвэрлэлтийн дэд бүтцийг хөгжүүлэх, шинэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, технологийн судалгаа үйлдвэрлэл, шинэ технологийг эдийн засагт нэвтрүүлэх зэрэг байлаа.

Эдийн засгийн чөлөөт бүс нь 2005 он хүртэл эдгээр хуулиудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд дээрх хугацаанд тус бүс рүү чиглэсэн хөрөнгө оруулагч байхгүйн улмаас хөгжлийн хувьд зогсонги байдалд орж, чөлөөт бүсийн үйл ажиллагаа үндсэндээ явагдахгүй болсон байна.

"ОХУ-д 2005 оны 07 сарын 22-ны өдөр "Эдийн засгийн тусгай бүсийн тухай" хууль батлагдан гарч, нэршлийн хувьд Эдийн засгийн тусгай бүс (Special economic zone-Особые экономические зоны) болон өөрчлөгдөж, үйл ажиллагаагаа эрчимтэй явуулж эхэлсэн ба ОХУ-ын Засгийн газраас үйлдвэрлэлийн, техник технологи дамжуулах, аялал жуулчлалын, боомт, ложистикийн гэх дөрвөн төрлөөр хөгжүүлэх үндсэн бодлого баримтлан ажиллаж эхэлсэн байна.

Хууль гарснаар:

1.Системтэйгээр хөгжиж эхэлсэн: 2005 оноос дэлхийн шилдэг томоохон компаниуд ОХУ-ын ЭЗТБ-д хөрөнгө оруулагчаар орж эхэлсэн.

2.Бүсүүдэд тохирсон татварын болон гаалийн тусгай дэглэмийн талаар хуульчилж өгснөөр 2014 он гэхэд 17 чөлөөт бүс бий болж , гадаадын 23, дотоодын 354 байнгын оршин суугчтай болсон.

3.Хувийн хөрөнгө оруулалт нэмэгдэх нөхцөл бүрдэж, хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэж, чөлөөт бүсүүдэд хувийн хөрөнгө оруулсан компаниудын нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 12 тэрбум ам.долларт хүрсэн.

ОХУ-ын Засгийн газраас 2006 онд РосОЭЗ /Оросын эдийн засгийн чөлөөт бүс ХК/ нэртэй компанийг байгуулж, чөлөөт бүсийн удирдлагын системийг бий болгосон ба "ЭЗТБ" ХК нь Эдийн засгийн тусгай бүсүүдийг удирдах дээд байгууллага болон өргөжиж, 100 хувь төрийн эзэмшлийн компани болжээ. Энэхүү компани нь үндсэн 2 зорилготой байсан. Үүнд:

1.Олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар бүхий үйлчилгээ, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, технологийг бүсэд бий болгох;

2.Оросын эдийн засгийн хөгжилд нөлөөлөхүйц өндөр зэрэглэлийн гадаадын компаниудыг тусгай бүсэд оруулах, үйлдвэрлэлийн тэргүүний технологийг Орос улсад нэвтрүүлэх, нутагшуулах зэрэг байв.

"РосОЭЗ" ХК-ий тэргүүнийг ЭЗХЯ-ны сайд томилдог бөгөөд "РосОЭЗ" ХК нь тус улсын томоохон компаниуд болох "Ростехнологи", "Рособоронэкспорт", "Роснефть" зэрэг засгийн газрын харьяа томоохон компаниудтай хамтран ажилладаг.

Дээрх компаниудаас эдийн засгийн тусгай бүсэд үйл ажиллагаа явуулахдаа тус бүсэд байнгын оршин суугчийн эрхийг заавал авдаг байна.

**Үүнд:**

- Хуулийн этгээд ЭЗТБ-д байрлах тухай хүсэлт гаргаж, орон нутгийн засаг захиргаанд бүртгүүлэх;
- Бизнес төлөвлөгөө болон бусад шаардлагатай бичиг баримт, байнгын оршин суугчийн эрх авах өргөдөл зэрэг материалуудыг бүрдүүлж, "Рос ОЭЗ" ХК-д өгөх;
- Хөрөнгө оруулалтын төслийг хяналтын зөвлөл хянаж, шаардлагатай тохиолдолд тохирсон өөрчлөлтийг бизнес төлөвлөгөөнд тусгуулах;
- Хяналтын зөвлөл нь бүс нутгийн зэрэглэлийн мэргэжилтнүүд анхан шатны магадлан шинжилгээ хийх;
- Хөрөнгө оруулалтын төслийг ОХУ-ын ЭЗХЯ-ны дэргэдэх дээд зөвлөл хүлээн авч, магадлан шинжилгээг дүгнэн, байнгын оршин суугчийн эрх олгох шийдвэрийг гаргах;
- ОХУ-ын ЭЗХЯ, "РосОЭЗ" ХК-тай ЭЗТБ-ийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах тухай гурвалсан гэрээ байгуулж, ЭЗТБ-ийн байнгын оршин суугчийн гэрчилгээг авах зэрэг багтдаг байна.

ОХУ нь 2008 онд Үйлдвэрлэлийн бүсийн хөгжлийн стратегийг баталж, түүхий нефть, байгалийн хий, дизель түлш, мазут зэрэг байгалийн баялгаа гадагш гаргаж эхэлсэн бол машин тоног төхөөрөмж, автомашин, эм зэрэг үйлдвэрлэлийн эцсийн бүтээгдэхүүнийг их хэмжээгээр импортлон авч байсан байна. (Хүснэгт 2)

(Хүснэгт 2) ОХУ-ын Гаалийн ерөнхий газраас 2022 онд гаргасан судалгаа:

| ОХУ-ын экспорт, импортын гол бүтээгдэхүүн, 2022 он | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Экспорт** | | | **Импорт** | | |
| **Нэр** | **Хэмжээ, тэрбум ам.дол** | **Хувь** | **Нэр** | **Хэмжээ, тэрбум ам.дол** | **Хувь** |
| Түүхйи нефть | 151 | 32 | Машин, Тоног төхөөрөмж | 136 | 51 |
| Байгалын хий | 66 | 14 | Автомашин /жижиг/ | 30 | 11 |
| Дизель түлш | 33 | 7 | Эм | 8 | 3 |
| Мазут | 31 | 7 | Хар метал | 5 | 2 |
| | 281 | **60%** | | 179 | **67%** |

Тухайн улсын Засгийн газраас худалдааг бус үйлдвэрлэлийг нэн тэргүүнд хөгжүүлэх шаардлагатайг харуулсан бөгөөд энэхүү шинэ чиг баримжаа нь чөлөөт бүсийн хөгжилд нөлөөлж, чөлөөт бүсийг үйлдвэрлэл, техник-технологи дамжуулах, нутагшуулах, аялал жуулчлал, нисэх буудал-боомт гэсэн төрлөөр хөгжүүлэх стратегийг баримтлахад хүргэжээ.

ОХУ-д ЭЗТБ-ийг тодорхойлохдоо эдийн засгийн чухал салбаруудад дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх, эдийн засгийн хөгжлийг төвлөрүүлэхэд зориулагдсан онцгой эрх зүйн орчин, улсын эдийн засгийн хөнгөлөлттэй нутаг дэвсгэрийн онцгой дэглэм бүхий тусгай хэсгийг хэлдэг ба тус улсад Үйлдвэрлэлийн 6, Техник технологи дамжуулах 5, Аялал жуулчлалын 4, Боомт Логистикийн 2 нийт 17 эдийн засгийн тусгай бүсүүд дараах хот, тосгонуудыг түшиглэн үйл ажиллагаагаа явуулдаг байна. Үүнд:

-Санкт-Петербург;
-Самар муж;
-Татарстан Улс;
-Свердловск муж;
-Хабаровын хязгаар;
-Буриад улс;
-Эрхүү муж;
-Алтайн хязгаар;
-Алтай Улс;
-Томск муж;
-Ульянов муж;
-Липецк муж;
-Калуж муж;
-Москва хотын Зеленоград муж;
-Москва муж-Дубна;
-Псков муж зэрэг болно.

Тухайн ЭЗТБ-үүдийг байгуулах дэд бүтцийн зардалд нь ОХУ-ын Засгийн газраас 75 тэрбум рубль зарцуулсан бөгөөд хувийн хэвшлээс 460 тэрбум рублийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.



**Үйлдвэрлэлийн бүс**: ОХУ-ын үйлдвэрлэл явуулахад тохирсон нөхцөл, эдийн засгийн хөгжил сайтай, тээвэрлэлтийн дэд бүтэц хөгжсөн, байгалийн эрдэс баялаг ихтэй болон нарийн мэргэшсэн ажиллах хүчний нөөцтэй муж нутгуудад байрладгаараа онцлогтой юм. Тухайн эдийн засгийн тусгай бүс нь Олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зорилготойгоор анх байгуулагдсан бөгөөд хуучин социалист системийн үед ажиллаж байсан томоохон үйлдвэр, бааз суурь, техник технологийн нөөцтэй байсан нь Оросын хувьд давуу тал болсон байна.

Үйлдвэрлэлийн бүсэд дэлхийн нэртэй томоохон Ford, General Motors, Yokohama, Novartis, Nokia Siemens Networks, Rockwool, Arcray, 3M зэрэг компаниуд байнгын оршин суугчийн эрх авсан байна. Үүнд:

“Липецк” ҮБ-д 2010 онд байгуулагдсан “Бекарт Липецк” үйлдвэр 2012 онд корд метал /ган трос/ үйлдвэрлэлтээр ОХУ-д тэргүүн байранд орж байсан ба бүтээгдэхүүнээ Орос, Украин болон Европын Холбооны зах зээлд нийлүүлж байна.

“Титановая долина” ҮБ-д АНУ-ын Boieng корпораци Оросын титан үйлдвэрлэлийн корпораци «ВСМПО-Ависма»-тай хамтран Ural Boeing Manufacturing (UBM) компанийг байгуулан, Боинг 787 Dreamliner иргэний нисэх онгоцны титан хэв, зарим эд ангийг үйлдвэрлэж байна.

ҮБ-ийн байнгын оршин суугч компаниуд олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай бараа, бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж байгаа бөгөөд “РосОЭЗ” ХК-ний мэдээлж байгаагаар 2022 онд үйлдвэрлэлийн бүсийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 3,0 орчим тэрбум ам.долларт хүрчээ.

ОХУ-ын ЭЗХЯ-ны тооцоогоор үйлдвэрлэлийн бүсүүдэд үзүүлж буй хөнгөлөлт, дэмжлэгийн үр дүнд бүтээгдэхүүний зардал 30.0 хувь буурснаар бизнесийн хөгжил, улмаар хэрэглэгчдэд очих барааны үнэ буурч байна гэж үзэж байна.

“Алубуга” ҮБ-д автомашин, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг төвлөрүүлэн хөгжүүлэх стратегитай төлөвлөгөөтэй байна. Тусгай бүсийн хөнгөлөлт эдэлж буй үйлдвэрүүд, бүсэд орж чадаагүй үйлдвэрлэлүүдийн зах зээлийг булаах сөрөг үр дагавар гарах зэрэг сул талууд ажиглагддаг байна.

ОХУ-д Моглино, Тольятти, Титановая долина, Калуга, Липецк, Алабуга зэрэг үйлдвэрлэлийн бүсүүд үйл ажиллагаагаа явуулдаг.

**Үүнд:**

- “Моглино” ҮБ нь 2012 оны 07 дугаар сарын 19-ний өдөр байгуулагдсан ба 215 га талбайг хамарсан үйлдвэрт төмөр зам, автомашин, цахилгаан бараа, ХАА-н тоног төхөөрөмж үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг.
- “Тольятти” ҮБ нь 2010 оны 08 дугаар сарын 12-ны өдөр байгуулагдсан ба 660 га талбаг хамарсан үйлдвэрт автомашин, барилгын материал, нефть химийн үйлдвэрлэл явуулдаг. 44 сая ам.долларын хөрөнгө оруулалттай.
- Титановая долина ҮБ нь 2010 оны 12 дугаар сарын 16-ны өдөр байгуулагдсан ба 584,4 га талбайг хамарсан үйлдвэрт онгоц, машин, эм, химийн үйлдвэрлэл явуулдаг. 13 сая ам.долларын хөрөнгө оруулалттай.
- “Калуга” ҮБ нь 2012 оны 12 дугаар сарын 28-нд байгуулагдсан ба 1042 га талбайг хамарсан үйлдвэрт автомашин, мод, модон бүтээгдэхүүн, хөдөлгүүрийн эд анги үйлдвэрлэдэг.
- “Липецк” ҮБ нь 2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулагдсан ба 1024 га талбайг хамарсан үйлдвэрт цахилгаан машин, автомашин, хими, барилгын материал үйлдвэрлэдэг. 1,845 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалттай.
- “Алабуга” ҮБ нь 2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулагдсан ба “Липецк” ҮБ-тэй нэг өдөр байгуулагдсан. Тус бүс нь 2140 га талбайг хамарсан үйлдвэрт

автомашин, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг төвлөрүүлэн хөгжүүлэх стратеги төлөвлөгөөтэй ажилладаг. 700 сая ам.долларын хөрөнгө оруулалттай.




**Техник технологи дамжуулах бүс:** Шинжлэх ухаан техникийн өндөр чадавхтай томоохон шинжлэх ухаан техникийн төвүүдийг тусгай бүс болгон өргөжүүлж, өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, мэдээллийн технологи, робот судалгаа шинжэлгээ, туршилт зохион бүтээх чиглэлийн үйл ажиллагаа явуулснаар ОХУ-д өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, судалгаа шинжилгээ, туршилт зохион бүтээх салбарын эрэлт нэмэгдсэн гэж үздэг байна.

ТТДБ-үүд хөгжлийн хурдацаараа ҮБ-г гүйцэхгүй байна. ТТДБ-ийн гишүүдэд 350 гаруй дэлхийн тэргүүлэгч компаниуд ашигладаг зохион бүтээх патентийг */Boeing, Airbus, Apple, Phillips, Samsung, IBM, Nvidia/* ашиглах боломжтой болсон нь үйлдвэрлэлийн бүсийн гишүүд эдгээр патентыг ашиглаж дэлхийн томоохон брэндүүдийг өөрийн орондоо үйлдвэрлэх боломж нь нээгдэж байна.

Техник, технологийг дамжуулах бүсүүдийг шинжлэх ухаан, техник, технологийн гадаадын компаниудтай хамтран ажиллах, шинэ технологийг бий болгох, нутагшуулах, үйлдвэрлэлийн ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор байгуулсан бөгөөд “РосОЭЗ” ХК-ны ерөнхий захирал В.В.Милявскийн хэлснээр 2022 оны байдлаар үр өгөөжөө төдийлөн сайн өгөөгүй байна.

ОХУ-д Дубна, Санкт-Петербург, Зеленоград, Иннополис, Томск зэрэг Техник, технологийг дамжуулах бүсүүд үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд:

- “Дубна” ТТДБ бүс нь 2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулагдсан ба 187,7 га талбайг хамарсан үйлдвэрт Нано, Био, цөм, мэдээллийн холбооны технологи үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг. 701 сая ам.долларын хөрөнгө оруулалттай.
- “Санкт-Петербург” ТТДБ нь 2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулагдсан ба 129,4 га талбайд мэдээлэл холбоо, эм үйлдвэрлэл, эрүүл мэндийн тоног төхөөрөмж үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг. 988 сая ам.долларын хөрөнгө оруулалттай.
- “Зеленоград” ТТДБ нь 2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулагдсан ба146га талбайд бичил, нано электроник, органик электроник, цахилгаан хэмнэх технологи, мэдээлэл холбооны технологи үйлдвэрлэдэг. 3,276 их наяд ам.долларын хөрөнгө оруулалттай.
- “Иннополис” ТТДБ нь 2012 оны 11 дүгээр саын 01-ний өдөр байгуулагдсан ба 294 га талбайд нано, био технологи хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг.
- “Томск” ТТДБ нь 2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулагдсан ба 207 га талбайд холбооны тоног төхөөрөмж, эрүүл мэндийн техник, технологи, цахилгаан бараа, мэдээллийн технологи үйлдвэрлэдэг. 497 сая ам.долларын хөрөнгө оруулалттай.

**Аялал жуулчлалын бүс:** АЖБ-ийг ОХУ-ын ЗГ-аас Алтай, Буриад, Эрхүү, Хабаровскийн хязгаарын бүс нутгуудыг хөгжүүлэх, хоцрогдлыг арилгах зорилгоор улсаас ихээхэн дэмжиж байгаа боловч амжилт олж чадахгүй байна. Энэ нь Египет, Турк, Испанийн аялал жуулчлалын салбартай харьцуулахад өрсөлдөх чадвар муу, нөгөө талаас орон зайн

хувьд алслагдмал, Алтай, Байгалийн муж нутгуудын дэд бүтэц болон тээврийн хөгжил муутай холбоотой гэж үздэг.

**Жишээ нь:** Москвагаас Турк орох нь Москвагаас Байгаль орохоос хямд үнэтэй болдог байна. Орчин үеийн аялал жуулчлалын цогцолборыг ажиллуулах чиглэлд мэргэшсэн мэргэжилтнүүд байхгүйн улмаас гадны өндөр мэргэшсэн боловсон хүчнийг хөлслөн ажиллуулдаг болох нь тогтоогджээ.

Калининград “Куршская коса” болон Краснодарийн “Новая Анапа” АЖБ-үүдэд хөрөнгө оруулагч гишүүн байхгүй гэдэг шалтгаанаар хаасан боловч үнэн хэрэгтээ Холбооны болон Мужийн хууль, эрх зүйн актуудын хүрээнд хөрөнгө оруулагч болон орон нутгийн захиргааны байгууллагууд газрын асуудлаар хамтран ажиллаж чадахгүй байснаас болсон байна.

“Бирюзовая катунь” АЖБ нь 2007 оны 02 дугаар сарын 03-нд байгуулагдсан ба 3326 га талбайд зочид буудал, аялал, спортын аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлдэг.

“Долина Алтай” АЖБ нь 2007 оны 02 дугаар сарын 03-ны өдөр байгуулагдсан ба 857 га талбайд экологи, түүх дурсгал, эрүүл мэнд, экстрем аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг.

“Ворота Байкал” АЖБ нь 2007 оны 02 дугаар сарын 03-нд байгуулагдсан ба 2347 га талбайд аялал жуулчлал, спорт, эмчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ явуулдаг.

“Байкальская гавань” АЖБ нь 2007 оны 02 дугаар сарын 03-нд байгуулагдсан ба 3613 га талбайд эрүүл мэнд, цана, амралтын үйлчилгээ явуулдаг.

**Боомт, логистикийн бүс:** БЛБ-ийн хөгжил төдийлөн үр дүнгээ өгөхгүй байгаа бөгөөд “Улъяновск” бүсэд болсон хэлэлцээрийн үр дүнд цөөхөн тооны гишүүн аж ахуйн нэгжүүдийг олсон. “Хабаровск”, “Советская Гавань” тээвэр ложистикийн бүсүүдэд хөрөнгө оруулагч гишүүн олдохгүйн улмаас үйл ажиллагаа нь царцанги байдалд орсон, “Мурманск”-ийн бүс нь хөрөнгө оруулагч огт байхгүйн улмаас хаагдсан зэрэг нөхцөл байдал үүсээд байна.

“Ульяновск” БЛБ нь 2009 оны 12 дугаар сарын 30-ны өдөр байгуулагдсан ба 324,7 га талбайд онгоцны засвар үйлчилгээ, угсралт, үйлдвэрлэл, логистик, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

“Советская гавань” БЛБ нь 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байгуулагдсан ба 290 га талбайд Боомтын логистик, усан онгоц засвар, үйлчилгээ, үйлдвэрлэл явуулдаг.

ОХУ-ын Засгийн газраас дээрх 4 төрлийн эдийн засгийн тусгай бүсийг байгуулан, үйл ажиллагаагаа явуулж байсан ч тусгай бүсүүдийн ихэнх хөрөнгө оруулагч нь Америк болон Европын холбооны зарим улсуудаас хамааралтай байснаас эдийн засгийн тусгай бүсийн мөнгөний эргэлт саармагжих цаашлаад царцанги байдалд ороход хүргэсэн байна.

Үүний гол шалтгаан нь ОХУ-ын эсрэг авсан Европын холбооны хэд хэдэн удаагийн эдийн засгийн хориг арга хэмжээтэй холбон ойлгож болох ба уг хоригуудад Орос-Украйны хооронд өрнөж буй дайны байдал шууд нөлөөлсөн гэж үзэж болно.

Өнөөдрийн байдлаар Орос улсад аж үйлдвэр, үйлдвэрлэл, аялал жуулчлалын болон амралт зугаалгын, технологи инновац болон порт/боомтын гэсэн дөрвөн төрлийн эдийн засгийн чөлөөт бүс байна.

Орос улсад 2023 оны байдлаар нийтдээ Эдийн засгийн 33 тусгай бүс, Аж үйлдвэр, үйлдвэрлэлийн эдийн засгийн 15 бүс, 7 технологийн инновацын эдийн засгийн бүс, 1 боомтын эдийн засгийн бүс, аялал жуулчлал, амралт зугаалгын эдийн засгийн 10 бүс байгаа ба 41 хөрөнгө оруулагч орон, 778 оршин суугч, 38 мянга гаруй ажлын байр бий болсон тоо мэдээлэл байна. (Зураг 2)

**(Зураг 2) 2013 оны эхээр ОХУ-д ЭЗ-ийн үйл ажиллагааны үр нөлөөний үнэлгээ.**




(Хүснэгт 3) 2022 онд бодитоор бий болгосон болон төлөвлөгдсөн ажлын байрны тоо

| Хэлбэр | Төлөвлөгдсөн хүний тоо | Бодит тоо |
|---|---|---|
| Аж үйлдвэр, үйлдвэрлэлийн | 1562 | 1268 |
| Технологи инновацын | 1075 | 529 |
| Аялал жуулчлал, амралт зугаалгын | 754 | 7 |
| Боомтын | 84 | 10 |
| Бүгд | 3475 | 1814 |

**Аж үйлдвэрийн тусгай бүсүүд:**

Тус улсын томоохон аж үйлдвэрийн бүс нутагт байрладаг өргөн уудам нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн нөөц баазтай ойр, бэлэн дэд бүтэц, тээврийн гол хүртээмж нь үйлдвэрлэлийн бүсүүдийн давуу талыг тодорхойлдог гол шинж чанар юм. Үйлдвэрлэлийн бүсийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэлийг байршуулснаар зардлыг бууруулах замаар Оросын зах зээл дээрх бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломжийг олгодог.

**Технологи инновацын бүсүүд:**

Шинжлэх ухааны баялаг түүхтэй, албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны сургуулиудтай, шинжлэх ухаан, боловсролын томоохон төвүүдэд шинэлэг (технологи-шинэлэг) бүсийг байрлуулснаар инновацын бизнесийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, Орос болон олон улсын зах зээлд нэвтрүүлэх томоохон боломжийг нээж өгч байна.

Гаалийн хөнгөлөлт, татварын хөнгөлөлт, мэргэжлийн хүний нөөцийн хүртээмж, шинэ технологийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж, Оросын эдийн засгийн төрөл бүрийн салбарыг шинэчлэх зэргээр венч капиталын сан, түүнчлэн хөгжүүлэгчид, үйлдвэрлэгчдийн сонирхлыг татахуйц шинэлэг чөлөөт бүсийг бий болгож байна.

Долоон инновацын бүс байдгаас тэдгээр нь Татарстан (Иннополис), Томск, Санкт-Петербург, Москва (Зеленоград), Дубна, Фрязино (Москва муж) болон Саратов мужид байрлаж байна.

**Аялал жуулчлал, амралт зугаалгын бүс:**

Жуулчдын эрэлт хэрэгцээ өндөртэй, Оросын хамгийн үзэсгэлэнтэй бүс нутагт байрладаг аялал жуулчлалын (жуулчны болон амралт зугаалгын) тусгай бүсүүд нь аялал жуулчлал, спорт, амралт зугаалгын болон бусад төрлийн бизнесийг зохион байгуулах таатай нөхцөлийг бүрдүүлдэг.

Аялал жуулчлалын долоон бүс байдгаас тэдгээр нь Эрхүү муж, Алтайн хязгаар, Бүгд Найрамдах Алтай Улс, Бүгд Найрамдах Буриад Улс, Калининград муж, Ставрополь муж, Приморскийн хязгаарт байрладаг. Шинээр байгуулагдсан өөр зургаан бүс нь Хойд Кавказын Холбооны тойрогт байрлаж байна.




**Боомтын бүсүүд:**

Боомтын бүсүүд нь дэлхийн томоохон транзит хонгилуудтай ойр байрладаг. Энэхүү байршил нь Алс Дорнод болон Оросын төв хэсэгт асар их эрэлт хэрэгцээтэй байгаа боомт, ложистикийн үйлчилгээний хурдацтай хөгжиж буй зах зээлд нэвтрэх боломжийг олгодог.

Ульяновск-Восточный нисэх онгоцны буудал дээр суурилсан эдийн засгийн тусгай бүсийн нэг онцлог шинж чанар нь Ульяновскийн нисэхийн кластерийн аж ахуйн нэгжүүдтэй ойр оршдогт байна. Энэ нь агаарын хөлгийн засвар үйлчилгээ, дахин тоног төхөөрөмжтэй холбоотой төслүүдийг боловсруулах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлдэг. Хабаровскийн нутаг дэвсгэрт боомт, ложистикийн бүсийг хөгжүүлэх гол чиглэл нь газарзүйн тохиромжтой байршил, одоо байгаа дэд бүтцийн бааз дээр тулгуурласан орчин үеийн олон профиль боомт, хөлөг онгоцны засварын төвийг бий болгох явдал юм.

2010 оны 10-р сарын 2-нд ОХУ-ын Ерөнхий сайд Владимир Путин ОХУ-ын Засгийн газрын 800 тоот “Мурманск” чөлөөт бүс байгуулах тухай тогтоолд гарын үсэг зурав. Аравдугаар сарын 26-ны өдрөөс эхлэн энэхүү шийдвэр хүчин төгөлдөр болсон билээ. “Мурманск” бүсийн нутаг дэвсгэр дээр задгай болон шингэн ачааг хүлээн авах, шилжүүлэн

ачих, ачих зориулалттай чингэлэг терминал барих, одоо байгаа боомтыг шинэчлэх, шинээр барих боломжтой. Үүнээс гадна өрөмдлөгийн машин угсрах боломжтой бөгөөд энэ нь далай дахь газрын тос, байгалийн хийн ордуудыг амжилттай ашиглахад чухал ач холбогдолтой юм. "Мурманск" боомтын бүсийн хөрөнгө оруулагчид татвар, гаалийн хөнгөлөлт эдлэхээс гадна дэд бүтцийн байгууламжуудтай холбогдоно. Хөрөнгө оруулагчид эдийн засгийн тусгай бүсэд оршин тогтнох бүх хугацаанд татварын хөнгөлөлтөд ямар нэг өөрчлөлт оруулахгүй гэж заасан байдаг.

Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт бизнесийн таатай нөхцөл бүрдсэнээр хөрөнгө оруулагчдын зардлыг 90% хүртэл бууруулах боломжтой юм.

1. ОХУ-ын болон Ульяновск мужийн төсвийн зардлаар бэлэн болсон дэд бүтэц, эрчим хүчний сүлжээнд холбогдох.

2. Татвар, гаалийн хөнгөлөлт:

- Орлогын албан татвар - 10 жилийн хугацаанд 2% (ОХУ-д 20% -ийн оронд), дараа нь - төслийн бүх хугацаанд 15.5%;
- Үл хөдлөх хөрөнгийн татвар - 15 жилийн хугацаанд 0%;
- Газрын татвар - 10 жилийн хугацаанд 0%;
- Тээврийн татвар - 10 жилийн хугацаанд 0%;
- Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт импортолсон гадаадын бараанд гаалийн татвар, НӨАТ ногдуулахгүй байх (гаалийн чөлөөт бүсийн журам).

3.Бэлэн болсон үйлдвэрлэл, агуулах, оффисын талбай түрээслүүлэх.

4.Өөрийн үйлдвэрлэл, агуулахын цогцолбор барих зориулалтаар газрын хөнгөлөлттэй үнээр өгөх.

5.Төсөл боловсруулах бүх үе шатанд захиргааны бүрэн дэмжлэг үзүүлэх.

6.Ямар ч төрлийн тээврийн дэд бүтцэд нэвтрэх.

ОХУ-ын чөлөөт бүсүүд нь улсынхаа эдийн засагт дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан бизнесийн олон боломжуудыг санал болгодог хамгийн амбицтай төслүүдийн нэг юм. Олон жилийн туршид гүйлгээ хийхэд хялбар, хөнгөлөлттэй бодлого, хууль эрх зүй, гаалийн хялбаршуулсан журам, захиргааны дарамтыг багасгах зэрэг бизнесийн хамгийн таатай орчныг санал болгох үүднээс шинэчлэгдэж байдаг.

**Гадаад худалдаа:**

2012 оны 8-р сарын 22-нд Орос улс ДХБ-д албан ёсоор элсэж, 2012 оны 12-р сарын 20-нд АНУ ОХУ-тай байнгын хэвийн худалдааны харилцаа байгуулж, АНУ-д ОХУ-тай ДХБ-ын гэрээг хэрэгжүүлэх боломжтой болсон. ДХБ-д элсэх ажлын хүрээнд Орос улс мэргэжлийн үйлчилгээний худалдаанд нөлөөлж буй саад бэрхшээлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн худалдааны ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурав. Үйлчилгээний салбарт Орос улс санхүүгийн үйлчилгээ, харилцаа холбоо, түгээлт, эрчим хүч, хүргэлт, мэргэжлийн үйлчилгээ, дуу дүрсний үйлчилгээ зэрэг одоо байгаа олон хязгаарлалтыг арилгах зэрэг өргөн хүрээний ил тод байдлыг хангах үүрэг хүлээсэн.

2011 оны 10-р сарын 18-нд Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн (ТУХН) найман улс (Орос, Беларусь, Украин, Молдав, Тажикистан, Армен, Казахстан, Киргиз) гарын үсэг зурж, дараа нь Чөлөөт худалдааны хэлэлцээрийг соёрхон батлав. 2013 онд Узбекистан улс дээрх найман оронтой тусдаа гэрээ байгуулан нэгдсэн.(Хүснэгт 4)

**(Хүснэгт 4) Чөлөөт худалдааны хэлэлцээрийг соёрхон баталж, гэрээ байгуулсан улс орнуудын жагсаалт**

| State | Signature | Entry into Force[13] | Comment |
|---|---|---|---|
| Armenia[14] | 18 October 2011 | 17 October 2012 | EAEU member |
| Belarus | 18 October 2011 | 20 September 2012 | EAEU member |
| Kazakhstan | 18 October 2011 | 8 December 2012 | EAEU member |
| Kyrgyzstan | 18 October 2011 | 13 December 2013 | EAEU member |
| Moldova | 18 October 2011 | 9 December 2012 | EAEU observer |
| Russia[note 1] | 18 October 2011 | 20 September 2012 | EAEU member |
| Tajikistan | 18 October 2011 | 19 March 2016 | |
| Ukraine[note 2] | 18 October 2011 | 20 September 2012 | Former CIS participant |
| Uzbekistan | 13 December 2013 | 12 January 2014 | EAEU observer |

2015 оны 12-р сарын 30-нд Ерөнхийлөгч Путин ОХУ, Украины чөлөөт худалдааны хэлэлцээрийг зогсоох тухай Холбооны 410 дугаар хуульд гарын үсэг зурав. Үүний хариуд 2016 оны 1-р сарын 2-ны өдөр Украины Сайд нарын танхим 2015 оны 12-р сарын 30-ны өдрийн 1146-р тогтоолоор ОХУ-ын бараа бүтээгдэхүүний худалдааны хөнгөлөлтийг цуцалсан. Түүнээс хойш Орос, Украин хоёр худалдааны хөнгөлөлтийг харилцан цуцлахаа үргэлжлүүлсээр байгаа бөгөөд одоогоор Орос, Украины хооронд худалдааны давуу эрх байхгүй, үүний оронд Орос-Украины худалдаанд хоёр талын худалдааны хязгаарлалт нэмэгдэж байна.

2015 оны 1-р сарын 1-нээс эхлэн 2010 онд байгуулагдсан Орос-Казахстан-Беларусийн Гаалийн холбоонд (БНХ) өмнө нь тусгагдсан зохицуулалтыг нэгтгэж, үйлчилгээний тарифын заалтыг өргөжүүлж, нэгдсэн стандартыг бий болгосон Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ) байгуулагдав. 2015 оны 1-р сарын 2, 8-р сарын 12-ны өдрөөс Армени, Киргиз улс тус тус нэгдэн орсон. 2016 оны аравдугаар сард ЕАЗХ болон Вьетнамын хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр хүчин төгөлдөр болсон. 2019 оны аравдугаар сард ЕАЭЗХ болон Серби, ЕАЭЗХ болон Сингапурын хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурсан бол ЕАЭЗХ болон Ираны хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр хүчин төгөлдөр болсон. ЕАЭЗХ-ны гишүүд Энэтхэг, Израиль, Египеттэй чөлөөт худалдааны хэлэлцээрийг үргэлжлүүлж байна.

ОХУ-ын Аж үйлдвэр, худалдааны яам 2022 оны арванхоёрдугаар сарын 31-ний өдрийг хүртэл тус улсад татвараас чөлөөлөх туршилтаа Амур, Владимир, Эрхүү, Псков, Камчатка зэрэг таван бүс нутагт сунгахаар төлөвлөж байна. (Зураг 3)

**(Зураг 3) ОХУ-ын Аж үйлдвэр, худалдааны яамнаас татвараас чөлөөлөх бүс нутгуудын тойм зураг**




ОХУ-ын Аж үйлдвэр, худалдааны яамнаас ОХУ-ын Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, татваргүй үйлчилгээ үзүүлэх журам буюу Евроазийн эдийн засгийн гаалийн нутаг дэвсгэрээс гадуур бараа тээвэрлэх үед гадаадын иргэдэд НӨАТ-ыг буцаан олгох төслийг боловсруулсан байна.

Татваргүй туршилтын хугацааг 2022 оны 12-р сарын 31 хүртэл сунгаж, төслийн газарзүйн байршлыг өргөтгөж, үйлчилгээний газруудын жагсаалтад хэд хэдэн бүс нутгийг нэмж оруулахыг санал болгож байна" гэж яамнаас мэдэгдэв.

Татваргүй дэглэмийг сунгаснаар жижиглэнгийн худалдааны сегмент дэх ажлын байр нэмэгдэхэд эергээр нөлөөлнө гэж үзжээ. Гадаадын жуулчдын худалдан авалтыг идэвхжүүлэхийн тулд яамнаас Амур, Владимир, Эрхүү, Псков, Камчатка зэрэг бүс нутгуудыг багтаасан татваргүй бүсүүдийн жагсаалтыг өргөжүүлэхийг санал болгож байна.

2022 оны 02 дугаар сард ОХУ, Украинд цэргийн хүчний түрэмгийлэл үзүүлсний дараа Европын Холбоо эрчим хүч, тээвэр, технологи, санхүүгийн салбарыг чиглүүлсэн нэмэлт хориг арга хэмжээ авч, хувь хүмүүст хязгаарлалтын арга хэмжээ авч эхэлсэн.

Энэ нь ОХУ-ын эдийн засгийн урсгалыг олон талаар саармагжуулсан бөгөөд барууны хөрөнгө оруулалттай чөлөөт бүсүүдийн үйл ажиллагаа үндсэндээ зогссон гэж хэлж болно.

**АЗИ ЕВРОПЫГ ХОЛБОСОН ЭХ ГАЗРЫН БООМТ (Зүүн Сибирийн эдийн засгийн бүс, мужууд)**

Эрхүү мужийн нийт газар нутгийн 80.0 хувийг нь ой мод эзэлдэг ба үйлдвэрлэлийн гол салбарууд нь хар ба өнгөт металлурги, ойн мод үйлдвэрлэл, үйлдвэр, машин боловсруулах нефть химийн үйлдвэрлэлүүд үйл ажиллагаагаа явуулдаг.

Бүгд Найрамдах Буриад Улсын нийт газар нутгийн 83.0 хувийг ой мод эзэлдэг ба энэ нь чөлөөт бүсэд мод боловсруулах, модон үйлдвэр байгуулах эдлэлийн боломжтойг харуулж байна.

Тус улсад Ми- 8 нисдэг тэрэгний үйлдвэр болон Бурядмяспром махны үйлдвэрүүд үйл ажиллагаагаа явуулдаг.

ОХУ-ын Засгийн газрын 2007 оны 2-р сарын 3-ны өдрийн №1-р тогтоолын дагуу “Байгаль нуурын боомт” аялал жуулчлал, амралт зугаалгын төрлийн эдийн засгийн тусгай бүсийг Буриад улсын “Прибайкальский район” хотын захиргааны нутаг дэвсгэр дээр байгуулсан. Эдийн засгийн тусгай бүсийн нийт нутаг дэвсгэр нь 3622.76 га бөгөөд:

- Эмчилгээ ба эрүүл мэнд;
- Далайн аялал;
- Цана, уулын гулгалт;
- Үзвэр үйлчилгээ;
- Шашин шүтлэг зэрэг ерөнхий чиглэлүүдтэй.

**(Хүснэгт 5) Хөрөнгө оруулагчдад татвар, гаалийн хөнгөлөлт үзүүлсэн жагсаалт:**

| Татвар | ОХУ | Чөлөөт бүс |
|---|---|---|
| Ашиг | 20% | 15.5% - оршин суугчийн статусыг авсан өдрөөс хойш 10 жилийн дотор |
| Үл хөдлөх хөрөнгө | 2.2% | 0% эд хөрөнгийн бүртгэлд хамрагдсан өдрөөс хойш 10 жилийн дотор |
| Газар | 1.5% | 0% Өмчлөлийг бүртгэсэн өдрөөс хойш 5 жилийн дотор |

Чөлөөт бүсийг байгуулахад их хэмжээний хөрөнгө оруулалт, тогтвортой хэрэгжих төрийн зөв бодлого, оролцоо маш чухал үүрэгтэй юм. Эрх зүйн орчныг бүрдүүлэх нь хангалтгүй бөгөөд түүнийг хэрэгжүүлэх засгийн газрын үүргээ гүйцэтгэх байдлаас хамаарч хөгжлийн тулгуур болох бизнесийн оролцоог хангах явдал төрийн бодлогоос шалтгаалдаг. Тийм ч учраас тухайн чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгжүүдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон гаалийн хялбарчилсан горимыг санал болгодог.

Дэлхийн эдийн засаг дахь өрсөлдөөн улам бүр нэмэгдэж бараа бүтээгдэхүүний үнээс илүүтэй чанар, шинэлэг байдал, шинжлэх ухааны ололт амжилтыг шингээсэн байдал нь хэрэглэгчдийн татах чухал хүчин зүйлс болсон бөгөөд өрсөлдөөн дундаас ашиг олох гэсэн тэмцэл улам бүр ширүүссээр байна.

Монгол Улс ч гэсэн энэхүү өрсөлдөөн дундаас ангид байх боломжгүй учир өөрийн давуу тал, нөөц баялагтаа тулгуурлан хөгжих гарцыг хайж олон тулгуурт эдийн засгийг бий болгох ирээдүйдээ үлдээх нөөцийг бодолцон тогтвортой хөгжихийг эрмэлзсээр байна.

Үүний нэг нь чөлөөт бүсийг хөгжүүлэх замаар орон нутгийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжих явдал юм.

Орчин үед дэлхийн чөлөөт бүсүүд чөлөөт боомтоос шинжлэх ухаан, технологи үйлдвэрлэлийн төв болон өөрчлөгдөн байгаа үед Монгол Улсын чөлөөт бүсийн хөгжил, эдийн засаг оруулах хувь нэмэр, эрх зүйн зохицуулалт болон хөрөнгө оруулалтын үр дүнг бодит байдалтай харьцуулан шинжлэх замаар асуудлыг хөндөхийг зорилоо.

### §1.3.Дэлхийн зарим улс орнуудын эдийн засгийн чөлөөт бүсүүдийн харьцуулсан судалгаа, практик жишээ

**1. БНХАУ-д:**

Хятад улс анхны ХЧБ-дээ Хайнань, Шенжень, Шантоу, Шиамен, Жухай зэрэг таван эргийн хотуудад 1980 оноос эхлэн байгуулж эхэлсэн ба энэ хотуудад зах зээлийн эдийн засгийн бодлого хэрэгжиж байсан бусад муж хотуудад төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо үйлчилсэн хэвээр байсан.

ХЧБ-ийн ашиг тусыг Хятад дахь орон нутгийн эрх баригчид мэдэх болсноор чөлөөт худалдааны асуудал улс даяар түгж эхэлсэн.

Өнөөгийн байдлаар Хятад улсад үндэсний хэмжээний 204 бүс, мужийн хэмжээний тусгай бүс (хотын хэмжээний бүсүүд байдаг ч олонх нь албан ёсны ХЧБ-д үл хамааран, ямар нэг тусгай хөнгөлөлт, таатай нөхцөл эдэлдэггүй) байна.

Эдгээр бүсүүд нь голдуу Хятадын үр шимтэй далайн эргийн бүс нутгийн дагуу төвлөрч байгуулагдсан байдаг ч баруун хэсгийн мужуудад бүсчлэн хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлсээр байна.

Хятад улсын хувьд газар нутаг нь бүхэлдээ төрийн эзэмшилд байдаг ба зөвхөн газар ашиглах эрхийг хувь хөрөнгө оруулагч нарт худалдаж болдог хуультай юм.

Фермер зэрэг одоогийн эзэмшигч нарын газрыг ХЧБ байгуулахаар албадан хурааж болох боловч газрын нөхөн олговрын тухай илүү хатуу чанга журмыг батлах шаардлагатай байдаг аж.

Бүсийг хөгжүүлэх мөн зохицуулах асуудлыг төв засгийн газар, мужийн болон орон нутгийн засаг захиргааны нэгжүүд гэх гурван түвшинд хариуцаж хэрэгжүүлдэг.

Төв засгийн газар үндэсний хэмжээний бүсүүдийг байгуулж, түүнээс доод түвшний бүсүүдийн үндсэн чиглэлийг тодорхойлж тогтоож өгнө.

Дээрх үндсэн чиглэлд тулгуурлан төв засгийн газар нь батлан, мужийн хэмжээний бүсүүдийг байгуулж болдог.

Тухайн бүсэд хөрөнгө оруулж буй хөрөнгө оруулагчид харьяа мужаас зөвшөөрөл авах ёстой байдгаас гадна зарим тохиолдолд төв засгийн газраас зөвшөөрөл авах тохиолдол бий. Зөвшөөрлийг олгохдоо нарийн шалгуураар шүүдэг бөгөөд төр засгийн янз бүрийн түвшин дэх өөр хоорондоо зөрчилдөх дүрэм, журам нь зөвшөөрөл авах явцыг хүндрэлтэй болгодог байна.

Өмнө нь хэрэгжиж байсан хөнгөлөлтийн тогтолцоо нь ХЧБ-ийн хөрөнгө оруулагчдад илүү таатай байсан бол саяхан хийсэн өөрчлөлтөөр газарзүйн байрлалд бус харин татварын жишиг хэмжээ нь тухайн салбарт илүү ач холбогдол өгөх болсон байна.

Хөнгөлөлтийн тогтолцоог хэрэгжүүлснээр Хятад улс ХЧБ-ийг үйлдвэрлэлийн баазын чухал хэсэг болгон хөгжүүлэхэд гол түлхэц хөшүүрэг болгож байна.

**2. Энэтхэг Улсад:**

Үйлчилгээний салбарын хөгжлийг үргэлжлүүлэх, үйлдвэрлэлийн салбарыг шат шатаар хөгжүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, мөн сул байгаа

ажиллах хүчин болон ХАА-н зориулалтаар ашиглаж байгаа газрыг үр дүнтэй ашиглах зорилгоор Энэтхэг улсын төр засаг ЭЗТБ-ийг аж үйлдвэрийн хөгжлийг түргэтгэх нэгэн арга хэрэгсэл болгон ашигладаг.

Урьд өмнө нь ЭЗТБ байгуулахад хөрөнгө оруулалт ихээхэн дутагдаж байсан туршлага байгаа учраас тус улсын төр засаг 2005 онд ЭЗТБ-ийн тухай хуулийг баталж гаргасан байна.

Энэ хуульд зааснаар 63 бүсийг байгуулахад бэлэн болсон бөгөөд шинээр 234 бүсийг байгуулахаар баталсан. (эцсийн шатандаа явж байгаа). Мөн 162 бүсийг зарчмын хувьд баталсан ч газрын асуудал шийдэгдээгүй байгаа аж. Эдгээр ЭЗТБ-д урьдчилсан тооцоогоор 2028 он гэхэд 4 сая шинэ ажлын байр бий болж, 72.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт төвлөрч, экспортын жилийн хэмжээ 16.2 тэрбум ам.долларт хүрэх аж.

Өнөөдрийг болтол шийдээгүй байгаа нэг бэрхшээл бол газрын асуудал хэвээр байна. ЭЗТБ-ийн төслийг боловсруулагчид газрын асуудлыг шийдэж чадаагүй бөгөөд орон нутгийн оршин суугчид ЭЗТБ-ийн төслийг эрс эсэргүүцэж байсан.

Энэхүү улс төрийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд газар ашиглах болон олгохтой холбоотой журамд өөрчлөлт оруулсан аж.

ЭЗТБ-ийн үйл ажиллагааг холбогдох яамдын сайдуудаас бүрдсэн зөвлөл ерөнхийд нь удирдан зохицуулдаг. Уг зөвлөл шинээр байгуулах бүсүүдийг баталж ЭЗТБ-ийн тухай Хуулийн хэрэгжилтийг хянан зохицуулах үүрэгтэй.

Бүсүүдийг байгуулах асуудлыг ЭЗТБ-ийн тухай хуулиар тогтоож өгсөн стандартын дагуу шийдвэрлэдэг. ЭЗТБ-ийн түвшинд бүсүүдийг хянан удирдах мөн ЭЗТБ-ийн тухай хууль болон Зөвлөлийн тогтоосон шалгуурыг ашиглан хөрөнгө оруулагч нарт зөвшөөрөл олгох үүрэг бүхий төр засгийн холбогдох яам агентлагуудаас гишүүд нь бүрдсэн зөвшөөрлийн хороог байгуулдаг.

Уг хороо нь хөрөнгө оруулагч нарт нэг цэгийн үйлчилгээг үзүүлэх зорилготой. Дээрх хороод нь хөрөнгө оруулагч нарын хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх үндсэн чиг үүрэгтэй байгуулагджээ.

ЭЗТБ-ийн тухай хуулиар мөн ЭЗТБ-ийн төслийг боловсруулагч болон хөрөнгө оруулагч нарт хөнгөлөлтийн бодлого хөтөлбөрийг тогтоож өгсөн.

Хөнгөлөлт гэдэгт шинээр орж ирэх хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжихэд чиглэгдсэн татварын хөнгөлөлт эдлэх болон татвараас чөлөөлөх зэрэг асуудал багтаж байгаа юм.

ЭЗТБ нь Энэтхэг улсад дутагдаж байгаа дэд бүтцийг бий болгох зорилготой бөгөөд тус улсын төр засгаас үзүүлж буй хөнгөлөлт нь дэд бүтцийн төсөл боловсруулагч нарт ашиг тусаа өгөхөд багагүй дэмжлэг болно гэдэгт эрх баригчид итгэлтэй байдаг байна.

**3. Малайз Улсад:**

Малайз улс аж үйлдвэрийн шийдэмгий бодлогыг хэрэгжүүлж байгаа ба үүнд нь өндөр хөнгөлөлтүүд мөн аж үйлдвэрийн бүс болон паркуудын сүлжээ зэрэг багтаж байгаа юм. Дээрх бүс болон паркуудыг хөгжүүлэх асуудлыг Малайзын аж үйлдвэрийн хөгжлийн

удирдах газрын удирдлага дор ажилладаг орон нутгийн эдийн засгийн хөгжлийн газрууд хариуцдаг.

Одоогоор Малайзад 200 гаруй Аж үйлдвэрийн бүс буюу парк, 14 аж үйлдвэрийн чөлөөт бүс мөн олон тооны тусгай паркууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Үүнээс хамгийн гол аж үйлдвэрийн тусгай төслийн нэг бол Куала Лумпур хотын ойролцоо байдаг мэдээлэл, харилцаа холбооны технологийн үйл ажиллагааны төв болгон хөгжүүлж буй “Мултимедиа” супер коридор юм. Өөр нэг том төсөл бол 547,669 акр (2,216 хавтгай дөрвөлжин километр) газар дээр байгуулагдсан Искандарын хөгжлийн бүс юм.

Аж үйлдвэрийн бүс буюу паркуудыг ихэнхдээ Улсын эдийн засгийн хөгжлийн корпорац, Бүсийн хөгжлийн удирдах газар, боомтын засаг захиргаа, хотын засаг захиргаа гэх мэт төр засгийн байгууллагууд байгуулж хөгжүүлдэг.

Улсын Эдийн Засгийн Хөгжлийн Корпорацуудыг ерөнхийдөө төр засгаас байгуулдаг ба аж үйлдвэрийн өмчийг бий болгож, эзэмших эрхтэй байдаг.

Малайзын аж үйлдвэрийн хөгжлийн удирдах газрын үүрэг роль бол холбогдох бүх байгууллагын үйл ажиллагааг нь зохицуулж, аж үйлдвэрийн үйл ажиллагааг нэгтгэн удирдах явдал байдаг.

Тэд үйлдвэрлэл явуулах лиценз зөвшөөрөл олгох мөн хөнгөлөлтөд хамруулах зэрэг ажлыг хариуцаж ажиллана. Гол тавигдах шалгуур буюу шаардлагад капиталын багтаамж, санхүүжилт бэлэн байх, ажиллах хүчин ба хүрээлэн буй орчныг хамгаалах зэрэг асуудал юм.

Малайзын төр засаг хөхүүлэн дэмжиж буй чиглэлд хөрөнгө оруулагчдыг хөнгөлөлтийн тогтолцоогоор хангаж өгсөн.

Хамгийн томд тооцогдох хөнгөлөлт бол 1986 онд батлагдсан “Хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль”-д зааж өгсөн хөнгөлөлт юм.

Биотехнологи болон мэдээлэл, харилцаа холбооны технологи зэрэг тодорхой салбарууд үндсэн хөнгөлөлтийн хажуугаар хөнгөлөлтийн нэмэлт хөтөлбөрт хамрагдах эрхтэй байдаг.

**4.Тайланд Улс:**

Тайланд улс хөрөнгө оруулалтыг татахын тулд дэд бүтэц болон хөнгөлөлтийн зохих орчныг бүрдүүлэх тал дээр маш идэвхтэй ажилласаар байгаа ба үр дүн нь ч сайн байна.

Тус улс бүхэлдээ эдийн засгийн бүс шиг болсон ба хөнгөлөлтийг нийт улс даяар мөрддөг.

Хөнгөлөлтийн түвшин нь бүс бүрд Тайландын Хөрөнгө оруулалтын зөвлөлийн тогтоосноор өөр өөр байдаг.

Дээрх бүсүүд бол муж аймгуудын бүлэг бөгөөд хөрөнгө оруулагч нар тухайн муж аймгийн эдийн засгийн хөгжлийн түвшнээс үл хамаарах хөнгөлөлтийг эдэлдэг.

Тухайлбал хөгжил буурай аймаг мужид илүү том хөнгөлөлт эдэлдэг. Эдгээрийг ЭЗТБ гэж хэлж болох Аж үйлдвэрийн бүс буюу паркуудын сүлжээ тус улсад байдаг хэдий ч Тайландын засаг захиргаа үүнийг ЭЗТБ-т тооцдоггүй байна.

Экспортыг дэмжигч бүсүүдийг оруулаад Тайландад нийт 34 Аж үйлдвэрийн бүс байдаг ба эдгээр бүсүүдийг Тайландын Аж Үйлдвэрийн Бүсийг Удирдах Газраар дамжуулан төрийн оролцоотойгоор байгуулсан.

Эдгээрээс 12 нь бүхэлдээ Тайландын Аж үйлдвэрийн бүсийг удирдах газрын эзэмшилд байдаг бол үлдсэн 22 бүсийг хувийн компаниуд эзэмшиж, удирддаг байна.

Харин Аж үйлдвэрийн паркуудыг ямар нэг төрийн оролцоогүйгээр дан хувийн секторынхон байгуулдаг бөгөөд одоогоор ийм паркийн тоо 20-д хүрээд байна.

Аж үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын асуудлыг зохицуулах гол байгууллага нь Аж Үйлдвэрийн Яамны харьяанд ажилладаг Хөрөнгө Оруулалтын Зөвлөл юм.

Хөрөнгө Оруулалтын Зөвлөл нь хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлж, хөрөнгө оруулалтыг сурталчлан дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулагч нарт үзүүлдэг хөрөнгө оруулалтын хөнгөлөлтүүдийг хянан зохицуулах үүрэгтэй агентлаг юм. Тайландын Аж Үйлдвэрийн Бүсийг Удирдах Газар нь Аж Үйлдвэрийн Яамны харьяанд ажиллахаас гадна хамтарсан компаниудыг байгуулах, түүнд хувь оролцох, мөн Аж Үйлдвэрийн Бүсийн төслүүдийг батлах зэрэг үүргийг гүйцэтгэдэг байна.

Шилдэгт тооцогддог ЭЗТБ-ийн төслийг ихэнхдээ “Хемараж”, “Амата” гэх мэт хувийн пүүс компаниуд байгуулж хөгжүүлсэн байдаг.

Тайландын Аж Үйлдвэрийн Бүсийг Удирдах Газар Аж Үйлдвэрийн Бүсүүдийг дэд бүтэц, санхүү болон хүрээлэн буй орчны хувьд тавьсан зорилтуудаа хэрхэн биелүүлж байгааг нь хянах стандарттай байдаг.

Аж Үйлдвэрийн Бүсэд үйлдвэрийн газар байгуулахаар зорьж буй хөрөнгө оруулагч нарын хувьд Тайландын Аж Үйлдвэрийн Бүсийг Удирдах Газрын зүгээс газар ашиглалт, барилга байгууламж болон үйл ажиллагааны хувьд тавигдах шаардлагуудыг хэрхэн хангасныг үндэслэн зөвшөөрөл олгодог.

Хэрвээ тухайн пүүс Хөрөнгө Оруулалтын Зөвлөлөөс холбогдох хөнгөлөлтийг авахыг хүсэж байвал зохих шалгууруудыг хангаж байгаагаа Зөвлөлд харуулж батлах ёстой байдаг.

Тайландын хувьд дэд бүтэц ерөнхийдөө сайн хөгжсөн. Эрчим хүч, цахилгааны салбарын хөгжилд анх өндөр хөнгөлөлтийн ачаар орж ирсэн хувийн секторын хөрөнгө оруулалт маш их түлхэц болж өгсөн.

**5. Арабын Нэгдсэн Эмират Улс:**

Арабын Нэгдсэн Эмират Улс газрын тос болон байгалийн хийн салбарыг хөгжүүлэхийн тулд чөлөөт бүсүүдийг байгуулсан.

Хамгийн анх “Жебел Алиг”-ийн Чөлөөт Бүсийг 1980 онд байгуулж 1985 онд албан ёсоор нээсэн. Өнөөдөр АНЭУ-д 12 чөлөөт бүс байгуулагдаад байна.

Эдгээр бүсүүдийн амжилт нь дэд бүтцэд их хэмжээний хөрөнгө хаясан, татвар болон дүрэм журмаас жинхэнэ утгаар нь чөлөөлж байгаа зэрэгтэй салшгүй холбоотой юм.

АНЭУ-д бүх бүсийг төрийн оролцоотойгоор байгуулж төр эзэмшдэг. Яамны түвшинд Санхүү, Аж Үйлдвэрийн Яам нь аж үйлдвэрийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг.

Тусгай бүсүүдийг Эмирүүдийн баталсан хуулийн дагуу байгуулдаг ба хууль ёсны эзэмшигч нь ерөнхийдөө төрийн эзэмшлийн корпорацууд байдаг.

Тусгай бүсийн төслийг боловсруулагч хэрэгжүүлэгчид нь ихэнх тохиолдолд нисэх буудлаас илүү далайн боомтын удирдлагууд байдаг.

Тухайн бүсэд чухам ямар төрлийн пүүс компанийг байгуулж болох журмыг ихэнхдээ хууль тогтоомжид зааж өгсөн байдаг боловч хэт ерөнхий заалттай байдаг.

Тухайн бүсийн удирдлага өөрсдийн баталсан шалгуурт үндэслэн хөрөнгө оруулагч нарт зөвшөөрөл өгөх асуудлыг шийддэг.

Бүх бүс нэг цэгийн үйлчилгээ санал болгодог учраас зөвшөөрөл олгох шат дамжлага ихэнх бүсэд маш хялбар байдаг.

АНЭУ нь хөрөнгө оруулагч нарт үзүүлэх хөнгөлөлтийн бодлогоороо дэлхийд дээгүүрт ордог.

Чөлөөт бүсүүд нь хөрөнгө оруулагч нарыг аж ахуйн нэгж болон хүн амын орлогын албан татвараас бараг бүрэн чөлөөлдөг. Хөрөнгө оруулагч нар бас импортын гаалийн татвараас чөлөөлөгддөг.

Хөрөнгө оруулалтыг ЭЗТБ руу татах бас нэг давуу тал нь АНЭУ-д дэд бүтэц маш сайн ялангуяа далайн болон агаарын тээвэр маш сайн хөгжсөн байдаг. Ихэнх бүс олон улсын зэрэглэлийн далайн болон агаарын боомтод холбогдсон нь олон давуу талыг бий болгосон.

Цахилгаан хангамж ерөнхийдөө хангалттай, үнэ хямд бөгөөд цахилгаан хангамжийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд олон улсын хамтарсан компаниудыг оруулж ирэх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа юм байна.

**6. Вьетнам Улс:**

Вьетнамд 1991 онд анхны Аж Үйлдвэрийн Парк нээгдэж байсан бол одоо 139 гаруй парк үйл ажиллагаагаа явуулж байна. Вьетнамын хувьд бүсүүдийг дараах байдлаар ангилдаг. Үүнд:

-Аж Үйлдвэрийн Бүс - ийм төрлийн бүсэд аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэл эрхэлдэг;
-Экспортыг Дэмжигч Бүс - энд пүүс компаниуд зөвхөн экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг;

Өндөр Технологийн Бүс - энд пүүс компаниуд технологи болон шинжлэх ухааны үйл ажиллагаа эрхлэн явуулдаг байна.

Үүнээс гадна аж үйлдвэрийн бүс нутаг болгон хөгжүүлж буй Эдийн Засгийн Нээлттэй Бүс 9 байдаг ба эдгээр нь тарифын мөн тарифын бус бүс нутгууд юм. Тэдгээр бүсүүдэд 2,433 гаруй гадаадын хөрөнгө оруулагч нар нийт 30 тэрбум ам.долларын шууд хөрөнгө оруулалтыг оруулаад байна.

2006 онд тусгай бүсүүд тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 17 тэрбум ам.доллар буюу 20 хувийг, экспортын 8 тэрбум доллар буюу нийт экспортын 21 хувийг эзэлсэн байна.

Вьетнамд газрыг төр бүрэн өмчилдөг. Хэрвээ ашиглаж байгаа газар дээр шинээр бүс байгуулах бол нөхөн төлбөрийг тодорхойлж өгсөн тодорхой зохицуулалт байхгүй ба үүнтэй холбоотой асуудлыг төсөл боловсруулагч, оршин суугч болон орон нутгийн засаг захиргаа хоорондоо зөвшилцөж тохиролцох маягаар шийдвэрлэдэг.

Аж үйлдвэрийн бүсийг байгуулахын тулд төв Засгийн газраас чиглэл авч, зөвшөөрөл авах ёстой ба түүнийг хэрэгжүүлэх, зохицуулах асуудлыг мужуудын аж үйлдвэрийн бүсийг удирдан зохицуулах хороо хариуцан ажилладаг.

64 мужийг хариуцсан бүсийн менежерүүдийг удирдах төвлөрсөн нэг байгууллага байхгүй учир тус улсад бүсийн хөгжил төвлөрсөн шинжийг бараг агуулдаггүй. Аж Үйлдвэрийн Яам болон Аж Үйлдвэрийн Бүсийг Зохицуулах Хороотой хамтран Хөрөнгө Оруулалтын Яам нь ЭЗТБ-д холбогдох бодлогыг нь тогтоож өгч, шинэ төслүүдийн өргөдлийг хянан шийдвэрлэх үүрэгтэй ажилладаг.

Муж, бүс нутгийн түвшинд Ардын Хороо болон түүний мужуудын аж үйлдвэрийн бүсийг удирдан зохицуулах хороо нь бүсийг байгуулах, хөгжүүлэх ажлыг хуулийн хүрээнд зохицуулж, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй, Хувийн секторын пүүс компаниуд ЭЗТБ-ийг засгийн газартай хамтран байгуулж болдог.

Төр засгийн газраас тогтоодог хөнгөлөлт байдаг боловч төвлөрсөн бус тогтолцоотой учраас ихэнхдээ мужийн болон бүсийн засаг захиргаа өөрийн тогтоосон хөнгөлөлтийг хөрөнгө оруулагч нарт санал болгодог. Вьетнамын дэд бүтэц ерөнхийдөө муу хөгжсөн учраас ЭЗТБ-дэд чанартай дэд бүтцийг бий болгохын тулд дэд бүтцэд хөрөнгө оруулагч нарт зориулсан хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн.

**7.Казакстан Улс:**

БНХАУ, Казакстан Улсын Засгийн газар хоорондын 2004 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн хэлэлцээрээр “Хоргос” олон улсын хилийн хамтын ажиллагааны төв байгуулсан ба БНХАУ-ын төрийн зөвлөлөөс 2006 оны 03 дугаар сард тусгай журам гаргаж, тус төвийн үйл ажиллагааны чиглэл, хөнгөлөлттэй бодлогыг тодорхойлсон байдаг.

Энэхүү эдийн засгийн бүсийг байгуулах төрийн зөвлөлийн шийдвэр 2011 онд гарсан бөгөөд бүс нь 73 км квадрат нутаг дэвсгэртэйгээр 2015 онд байгуулагдсан байна.

БНХАУ-ын талаас уг төвд барилга байгууламж барих, материал тоног төхөөрөмж оруулахад экспортод гаргаж байна гэж тооцож, татварыг буцаан олгодог бол Казакстаны талаас уг төвийн хятад талын хэсэгт барилга, дэд бүтэц, барих, бараа материал, тоног төхөөрөмж оруулахад импорт гэж тооцон, импортын НӨАТ, гаалийн татвараас чөлөөлдөг байна.

Харин тус төвөөс Хятадын нутаг руу бараа бүтээгдэхүүн оруулахад ерөнхий худалдааны татвар хураах зарчмыг баримталдаг байна.

“Хоргос” олон улсын хилийн хамтын ажиллагааны төв рүү зорчиход 30 хоногийн хугацаатай визгүй зорчихыг зөвшөөрдөг бөгөөд орсон гарцаараа буцаж гарах зарчмыг баримталдаг ба үйлчлүүлэгчид нь Юань, Тенге, Доллароор гүйлгээ хийх боломжтой юм.

Тус олон улсын хилийн хамтын ажиллагааны төв нь дараах бодлогыг баримтлан ажилладаг. Үүнд:

-Эдийн засгийн чөлөөт бүсийн дэд бүтцийг бүрдүүлэх, ая холбогдолтой төсөл хөтөлбөрүүдийг төр засгаас банкны зээлийн хүүгийн хөнгөлөлттэй бодлогоор дэмжих;

-Эдийн засгийн бүсэд оруулсан үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтад холбогдох нөхцөлүүдийг дагуу дэмжлэг үзүүлэх;

-Эдийн засгийн хөгжлийн бүсэд шинээр байгуулагдсан дэмжлэг үзүүлэх гол аж үйлдвэрийн жагсаалтад орсон чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн орлого олсон өдрөөс эхлэн 5 жилийн турш ААН-ийн орлогын алан татвараас чөлөөлөх;

-Дотоодын үйлдвэрлэх боломжгүй тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл импортолсон тохиолдолд холбогдох гэрээнд нийцүүлэн тодорхой хүрээнд хураамжаас чөлөөлөх;

-Тухайн боомтыг тээврийн хэрэгсэл импортлох боломжтой боомт гэж үзэн, хүлээн зөвшөөрөгдсөн импорт, экспортын хилийн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд квот хүсвэл давуу эрх олгох;

-Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн судалгаа шинжилгээ, хөгжлийн төвийг бодлогоор дэмжих;

-Дурын санхүүгийн байгууллага салбараа нээх боломжийг нээлттэй байлгахад анхаарч, хөрөнгө оруулагч нарыг татах;

-Хятадын бусад нутаг дэвсгэрээс технологийн ололтуудыг эдийн засгийн бүсэд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

-Газар ашиглалтын талаар ШУӨЗО болон Шинжааны үйлдвэрлэлийн компаниудад давуу эрх олгох;

-Боомт дахь хяналт шалгалтыг сайжруулах, төмөр зам болон хурдны зам барих ажлыг үе шаттайгаар явуулах зэрэг болно.

Эдийн засгийн бүсэд газрын төлбөр, газар ашиглах татварыг дараах байдлаар зохион байгуулдаг. Үүнд:

-Аж ахуйн нэгжүүдэд хуульд заасны дагуу газрыг 50 жилээр ашиглуулах зөвшөөрөл олгож, газрын төлбөрийг үйл ажиллагаа эхлэхээс өмнө барагдуулсан байх шаардлага тавьдаг;

-Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг ААН газар ашиглах татвараас 5 жилийн хугацаатай чөлөөлөгддөг;

-Нэхмэлийн үйлдвэрлэл эрхэлдэг ААН-ийг өөрийн эзэмшил газарт газар ашигласны татвараас чөлөөлдөг байна.

Тухайн бүсэд хэрэг зөрчил гарвал аль талын улсын нутагт байгааг тодорхойлж,, өөр өөрсдийн зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэдэг зарчимтай юм

**8.БНХАУ-ын Шинжаан:**

БНХАУ-ын баруун хойд нутагт орших Шинжааны чөлөөт худалдааны туршилтын бүсийг 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр албан ёсоор нээж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн.

Тухайн чөлөөт худалдааны туршилтын бүс (ЧХБ) нь “Өрөмч”, “Туняз”, “Хоргос” болон Кашкарын нутаг дэвсгэрийг хамарсан бүсүүдэд лиценз олгожээ.

Энэхүү ЧХБ нь 180 орчим хавтгай дөрвөлжин км талбайтай бөгөөд газар зүйн байрлалын давуу тал, аж үйлдвэрлэлийн бааз суурийг ашиглан, бүтээн байгуулалтыг чанар стандартын өндөр түвшинд гүйцэтгэснээрээ онцлогтой юм.

Шинжааны чөлөөт худалдааны туршилтын бүс нь Шинжааныг дотоодын болон олон улсын зах зээлийн хос эргэлтэд нэгтгэх “Бүс ба зам” санаачилгын хэрэгжүүлэхэд томоохон хувь нэмэр болж, Ази-Европ тивийг холбосон суваг байгуулахад чухал үүрэг гүйцэтгэх Хятад улсын баруун тийш холбогдох эдийн засгийн гарц болно гэж үзсэн байна.

**9.Пакистаны ЭЗЧБ-ийн үнэлгээ:**

Энэхүү судалгааны дэд бүлэгт ЭЗЧБ-ийг эдийн засгийн тусгай бодлого бүхий бус нутаг хэмээн тодорхойлсон бол уг тодорхойлолт хязгаарлагдмал хүрээнд хэрэглэгдэж байна.

Аж үйлдвэрийн бүс байгуулах санаачилгыг ихэнхдээ муж дүүргүүдэд хэрэгжүүлсэн хэдий ч тэдгээр нь ямар нэг тусгай хөнгөлөлт авдаггүй байсан. 2001 онд Азийн Хөгжлийн Банкны хийсэн судалгаагаар Пакистанд ойролцоогоор 82 Аж Үйлдвэрийн Парк байсны ихэнх нь боломжийн үйл ажиллагаа явуулж байжээ.

Байгуулагдаад удсан төслүүд муу дэд бүтэцтэйгээс гадна үл хөдлөх хөрөнгийн дамлан худалдаалагчдаас газрыг дамлан наймаалахаас сэргийлж чадахгүй байв.

Одоо үйл ажиллагаа явуулж байгаа төслүүдээс гадна дөнгөж байгуулагдаад байгаа мөн үйл ажиллагаагаа явуулж байгаа аж үйлдвэрийн олон бүс байдаг.

Хэдийгээр Сундарын Аж Үйлдвэрийн Парк зэрэг тэдгээр төслүүдийн зарим нь өндөр стандартын дагуу байгуулагдсан ч хөрөнгийг хамгийн зөв гэсэн хөрөнгө оруулалтад оруулах буюу зориулах зохицуулалт ерөнхийдөө дутмаг байсаар байна.

Холбооны засгийн газар Экспортыг Дэмжигч Бүс, Үндэсний Аж Үйлдвэрийн Парк болон зарим нэг аж үйлдвэрийн төслүүдээр дамжин тодорхой хэмжээгээр оролцдог боловч муж аймаг болон хувийн секторууд тус улсад Аж Үйлдвэрийн Бүс болон Парк байгуулах ихэнх ажлыг гүйцэтгэдэг ба “Ноу Хау” бүсийн хөгжилд улам ихээр татан оруулж байна.

Орон нутгийн энэ хөгжил нь холбооны засгийн газрын оролцоогүйгээр бие даасан байдлаар явагддаг. Тухайн бүсийн захиргаа өөрийн тогтоосон шалгуураар хөрөнгө оруулагч нарт зөвшөөрөл олгодог.

Өнгөрсөн хугацаанд зохих шалгуур дутагдаж байсан учраас бүсийн газрыг үр ашиггүй олгож байсан аж. Засгийн газрын цөөн тооны хэдэн хөтөлбөрийг эс тооцвол хөрөнгө оруулалтыг дэмжих хөнгөлөлтийн цогц бодлого дутагдсаар байна.

ЭЗТБ-ийн улсдаа өгөх нэг чухал ашиг тус бол аж үйлдвэрлэгч нарт дэд бүтэц бүхий газар олоход нь тус болох явдал юм.

Гол бэрхшээл нь бүсийн төслийг хэрэгжүүлэгч нарт зах зээлээс мөн төрөөс газар авахад хүндрэлтэй байгаа юм.

Бүсэд илүү чанартай дэд бүтцийг бий болгоход улам бүр их оролцох болсноор аж үйлдвэрийнхэн Пакистанд хөрөнгө оруулах илүү сайхан боломжтой болжээ.

2.1.2 Харьцуулсан судалгааны хураангуй.

**(Хүснэгт 6) Газрын өмчлөлийн хэлбэр**

| **Улсын нэр** | **Өмчлөлийн хэлбэр** | **Төрөөс газрыг хувийн эздээс нь албадан хураах байдал** | **Газар эзэмших эрх түрээслэх** | **Газрын хөнгөлөлт** |
|---|---|---|---|---|
| Хятад | Төрийн | Их | Түрээс | Өмнө нь байсан ч одоо цуцалсан |
| Энэтхэг | Төрийн/хувийн | Их | Хоёулаа | Байхгүй |
| Тайланд | Төрийн/хувийн | Бага | Ихэнхдээ газар эзэмших | Байхгүй |
| Малайз | Төрийн/хувийн | Бага | Ихэнхдээ газар эзэмших | Байхгүй |
| АНЭУ | Төрийн | Бага | Газар эзэмших | Байхгүй |
| Вьетнам | Төрийн/Хамтар сан | Их | Газар эзэмших | Тийм |
| Пакистан | Төрийн/хувийн | Дунд зэрэг | Хоёулаа | Тийм |

**Хүснэгт 7. Удирлагын бүтэц**

| Улсын нэр | Засгийн газрын үүрэг роль | Мужийн үүрэг роль | Бүсийн удирдлага |
|---|---|---|---|
| Хятад | Бодлого боловсруулж, бүс байгуулах | Бодлогын хэрэгжүүлэх & бүс байгуулах | Бүсийг Удирдах Хороо |
| Энэтхэг | Зөвшөөрөл Олгох Зөвлөл ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, бүс байгуулах өргөдлийг хянан шалгах | Бүс байгуулах | Хөгжлийн Комиссариат, Зөвшөөрөл Олгох Зөвлөл |
| Тайланд | Хөрөнгө Оруулалтын Зөвлөл хөнгөлөлт, бодлогыг боловсруулж, Тайландын Аж Үйлдвэрийн Бүсийн Удирдах Газар мөн хувийн сектор Аж | | Аж Үйлдвэрийн Бүсийн Дарга |
| Малайз | Бүс байгуулах ажлыг гүйцэтгэх төрийн өмчийн корпорацуудад эрх мэдлийг нь олгож, удирдах | Бүс байгуулах ажлыг гүйцэтгэх төрийн өмчийн корпорацуудад эрх мэдлийг нь олгож, удирдах, хилийн чанад дах үйл ажиллагааг удирдана | Корпорацын захирал, хөгжлийн удирдлага |
| АНЭУ | Төлөвлөгөө боловсруулах | Эмирүүд бүс байгуулах корпорац байгуулах | Бүс байгуулах төрийн корпорацууд |
| Вьетнам | Төлөвлөгөө боловсруулах, зөвшөөрөл олгох, бүсийн төслийг батлах гопез | Бүс хариуцсан хороог байгуулах | Мужийн бүс хариуцсан хороо |
| Пакистан | Экспортыг Дэмжих Бүс байгуулах | Аж Үйлдвэрийн Бүс байгуулах | Бүсийн Комиссартай |

Журмыг дараах байдлаар ангилж болно: 1) бүсийг байгуулах журам, 2) бүсэд хэн хөрөнгө оруулж болохыг заасан журам, 3) пүүс компаниудын бүс доторх үйл ажиллагааны тухай журам зэрэг юм.

Бүсийг байгуулах асуудал дээр харьцуулалт хийсэн бараг бүх улс оронд бүсийг үүсгэн байгуулагч нар тодорхой шалгуур, шаардлагыг хангаж байж зөвшөөрөл авах ёстой гэсэн нарийн заасан стандарттай байдаг.

Бүсийн хөрөнгө оруулагч нарт зөвшөөрөл олгох ажлыг төв засгийн газар нь Мужийн болон бүсийн удирдлагуудад хариуцуулах хандлагатай байдаг.

**Дэд бүтэц:**

Харьцуулалт хийсэн улс орнуудаас Малайз, АНЭУ болон Тайланд зэрэг улсууд ерөнхийдөө бусдаасаа илүү сайн дэд бүтэцтэй. Тайландын хувьд хувийн секторыг хөхүүлэн дэмжиж, том хэмжээний өндөр зэрэглэлийн бүсийг байгуулж амжилтад хүрсэн.

**Бусад асуудлууд:**

Малайз, АНЭУ болон Тайланд зэрэг улсууд өрсөлдөх чадвар өндөр салбар чиглэлд бүсийг амжилттай байгуулсаар байна. Мөн бүсийг өөрийгөө тэтгэх чадвар бүхий аж үйлдвэрийн хот болгон хөгжүүлэх хандлага илт байна.

**Үр нөлөө:**

Хятад, Тайланд, АНЭУ, Вьетнам болон Малайз зэрэг улсуудад ЭЗТБүсүүд нь аж үйлдвэрийн хүчин чадал, чадамжийг дээшлүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг татагч гол хүчин зүйл болсон. ЭЗТБүсүүдийн эдгээр улс оронд үзүүлсэн зарим нэг гол нөлөөнөөс дурдвал:

-Хятадын ЭЗТБ-дэд үйл ажиллагаа явуулж буй компаниуд 1.5 триллион доллартой тэнцэх бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ДНБ-ий 68.0 хувийг эзэлж байна.

-Хятадын нийт экспортын 87.0 хувийг ЭЗТБ бүрдүүлж байна.

-Хятадын үндэсний хэмжээний бүсүүд 2004 онд нийт 9.2 тэрбум долларын гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татсан.

-Энэтхэг улсын ЭЗТБүсүүд нь 2008 он гэхэд 4 сая шинэ ажлын байр бий болгож, шинээр 72.3 тэрбум долларын хөрөнгө оруулалтыг татаж, жилийн нийт экспорт 16.2 тэрбум долларт хүргэнэ гэж төлөвлөж байна.

-Вьетнамын тусгай бүсүүд 30 тэрбум долларын гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татаж чадсан.

-Вьетнамын тусгай бүсүүд 17 тэрбум долларын- бүтээгдэхүүн гаргаж улсынхаа дотоодын нийт бүтээгдэхүүний 20 хувийг бүрдүүлж байна.

-Вьетнамын тусгай бүсүүд 8 тэрбум долларын бараа бүтээгдэхүүнийг экспортолж улсынхаа нийт экспортын 21 хувийг бүрдүүлж байна.

Пакистаны Засгийн Газрын хөгжлийн эцсийн зорилт нь эдийн засгийн хөгжлийг эдийн засгийн бүхий л салбар чиглэлд хангах явдал юм.

Харин тэдгээрийг ач холбогдлоор нь зэрэглэж ангилбал ядуурлыг арилгах мөн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх хоёр хамгийн нэн тэргүүнд биелүүлэх зорилт гэж засаглалын бүх түвшнийхэн хариулах болно.

Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх хамгийн гол хүчин зүйл бол хувийн секторын хөрөнгө оруулалт бөгөөд нь энэ нь бараа, үйлчилгээг бүтээх зардал болон тэдгээр бүтээгдэхүүний дотоодын болон гадаадын зах зээл дэх эрэлт хэрэгцээ зэргээс шалтгаалдаг. Зардал талаас нь авч үзвэл Пакистан нь ажиллах хүчин дутмаг, газар болон эрчим хүчний үнэ өндөр учраас Хятад, Энэтхэг, АНЭУлсуудтай өрсөлдөхөд улам бүр хэцүү болж байгаа юм.

Хэдийгээр хэрэглэгчдийн хэрэгцээ өсөж байгаа ч дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүд импортоор орж ирсэн бараа бүтээгдэхүүнтэй өрсөлдөхөд хэцүү байгаа олон салбар байна.

Экспортын зах зээлд Хятад, Энэтхэг Вьетнам зэрэг улсуудад үнэ ханш харьцангуй бага байсаар байгаагаас гадна бүтээгдэхүүний чанар нь улам бүр сайжирсаар байгаа учраас эдгээр орнуудын зах зээлийн төлөө өрсөлдөөн улам бүр ширүүн болсоор байна.

2005-2006 оны хооронд Пакистан улс 16.5 тэрбум долларын бүтээгдэхүүн экспортолж, 28.6 тэрбум долларын импорт хийснээр худалдааны алдагдал нь 12.1 тэрбум болсон.

**Дэлхийн Өрсөлдөх Чадварын Индекс:**

**(Хүснэгт 8) Харьцуулалт хийсэн улс орнуудын эзэлж буй байр**

| Улсын нэр | 125 орноос хэддүгээрт жагсаж байгаа | Оноо |
|---|---|---|
| Малайз | 26 | 5.11 |
| АНЭУ | 32 | 4.66 |
| Тайланд | 35 | 4,58 |
| Энэтхэг | 43 | 4.44 |
| Хятад | 54 | 4.24 |
| Вьетнам | 77 | 3.89 |
| Пакистан | 91 | 3.66 |

*Эх үүсвэр: Дэлхийн Эдийн Засгийн Чуулган, 2006-2007 оны Дэлхийн Өрсөлдөх Чадварын Илтгэл*

Дээрх асуудлуудын шалтгаан нь янз бүр байгаа ч газар, ажиллах хүчин, дэд бүтэц, хөрөнгө мөнгө, зохицуулах механизм гэх мэт хамгийн гол саад бэрхшээлүүдийн заримыг ЭЗТБ-ийг зөв ашиглах замаар шийдэж болно.

Нэг талаар богино хугацаанд сайжруулах боломжгүй муу өрсөлдөх чадварыг сайжруулах нэг чухал арга зам нь ЭЗТБ-ийн хөнгөлөлтийн тогтолцоо байж болох юм.

Хэрвээ өрсөлдөх чадварт тулгарч буй бэрхшээлийг багасгаж, бизнесийн илүү боломжийг бүрдүүлэхэд ЭЗТБ-ийг үр дүнтэй ашиглаж чадвал хөрөнгө оруулалт болон ажил эрхлэлтийн ашиг тус нь үлэмж их байж болох юм.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

### §2.1.Замын-Үүдийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн өнөөгийн байдал



Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 126 дугаар тогтоолоор “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг баталсан бөгөөд 2004-2008 онд Үйлдвэр худалдааны яам, 2008-2012 онд Монгол Улсын Тэргүүн шадар сайд, 2012 онд Монгол Улсын Шадар сайд, 2012 онд Эдийн засаг хөгжлийн яам, 2012-2015 онд Аж үйлдвэрийн яам, 2016-2021 онд Монгол Улсын Шадар сайдын харьяалалд үйл ажиллагаагаа явуулж байгаад 2022 оны 01 дүгээр сараас Эдийн засаг, хөгжлийн яамны харьяа болж үйл ажиллагаагаа явуулж байна.

Замын-Үүдийн “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс” -ийг Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах зорилгоор анх байгуулсан бөгөөд тухайн чөлөөт бүсийг ***“Олон улсын жишигт нийцсэн, дэвшилтэт технологи, инновацад суурилсан, байгаль орчинд ээлтэй “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс” болгоно”*** гэж Монгол Улсын Засгийн газрын “Алсын хараа 2050” хөгжлийн хөтөлбөрт тусгасан байдаг.

БНХАУ болон Зүүн хойд Азийн орнуудын зах зээлд нэвтрэх, уламжлалт бус үйлдвэрлэлийн чиглэлээр өрсөлдөх чадварыг сайжруулах, ажилгүйдлийн түвшнийг бууруулах, хүн амын орлогыг нэмэгдүүлэх, нарийн мэргэжлийн ажлын байруудыг шинээр бий болгох, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татаж, уламжлалт бус бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжоог дотоодын бизнес эрхлэгчдэд олгох, авто зам, тээврийн сүлжээ, инженерийн дэд бүтэц бий болгох, аялал жуулчлалыг хөгжүүлэх, энэ төрлийн шинэ брэндийг бий болгох зорилт дэвшүүлэн үйл ажиллагааг нь эхлүүлж байсан бөгөөд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд дараах зорилтууд тусгагдсан байдаг. Үүнд:

**Алсын хараа 2050 хөтөлбөрт:**

- Аж үйлдвэрийг хөгжүүлэх тааламжтай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон чөлөөт бүсийг хөгжүүлнэ.
- Хил дамнасан худалдааны байнгын сүлжээг байгуулна.

**Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт:**

• Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана.

• Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж “Замын-Үүд” чөлөөт бүсийг байнгын үйл ажиллагаанд шилжүүлнэ.

**Шинэ сэргэлтийн бодлогод:**

• Эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ.

• Эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж төвлөрлийг сааруулна.

**Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд:**

Чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ гэж тус тус тусгасан ба “Үйлдвэрлэл”, “Аялал жуучлал”, “Худалдаа үйлчилгээ”, “Тээвэр ложистик” гэсэн 4 чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх боломжтой гэж үзсэн байна.

**Чөлөөт бүс дэх үйл ажиллагааны тусгай дэглэм:**

Чөлөөт бүсэд гаалийн, визийн, Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих, хуулийн этгээдийн бүртгэлийн, валют зохицуулалтын, мэргэжлийн хяналтын, хөдөлмөр эрхлэлтийн татварын болон бусад бусад дэглэм үйлчилнэ.

**Тусгай дэглэмийн төрөл:**

- Гаалийн тусгай дэглэм;
- Визийн тусгай дэглэм;
- Хуулийн этгээдийн бүртгэлийн зохицуулалт;
- Төлбөр тооцоог гүйцэтгэх зохицуулалт;
- Мэргэжлийн хяналтын зохицуулалт;
- Хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэм;
- Татварын тусгай дэглэм.

**Чөлөөт бүс дэх газрын харилцаа:**

Чөлөөт бүсийн нутаг дэвсгэр нь боомтын газар нутагт хамаарахгүй бөгөөд бүс доторх газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах шийдвэрийг чөлөөт бүсийн Захирагч гаргаж, түүний ажлын алба газар ашиглагчтай гэрээ байгуулах бөгөөд уг шийдвэрт ашиглах газрын хэмжээ, хугацааг тусгасан байна. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах газрын суурь үнэлгээг болон газрын төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтооно.

**Газрын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт:**

-Худалдаа, аялал жуулчлал,зочид буудлын үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс чөлөөт бүсэд ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний 5 жилд 100 хувь, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.

-Чөлөөт бүсэд дэд бүтэц болон үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, түүний салбарыг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс чөлөөт бүсэд эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний 10 жилд 100 хувиар чөлөөлнө.

**Олон улсын зах зээлд нэвтрэх боломжууд:**

- Европын Холбооны Улс руу **7200** нэр төрлийн барааг ямар нэгэн тарифын хязгаарлалтгүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр оруулах;
- Япон улс руу **9300** нэр төрлийн барааг хөнгөлөлттэй нөхцөлөөр оруулах;
- Давхар татвараас чөлөөлөх" хэлэлцээрийг **33** улстай, хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах 2 талт хэлэлцээрийг **42** улстай хийсэн;
- Монгол Улс "Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр"-т нэгдэн орсон. 2021 оны 01 дүгээр сарын 01-с үйлчилж эхэлсэн хэлэлцээрийн дагуу гишүүн улс руу хийх бараа бүтээгдэхүүний экспортод тарифын хөнгөлөлт эдлэх юм;
- АНУ-ын Худалдааны хөнгөлөлтийн системд Монгол улсаас гарал үүсэлтэй **3400** нэр төрлийн бараа бүтээгдэхүүнд гаалийн татварын хөнгөлөлтийг эдэлдэг.

**Дэд бүтэц:**

"Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албанаас "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл"-ийг санаачлан боловсруулсан нь дэмжигдэж, Монгол улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 58,8 сая долларын хөнгөлөлттэй зээлээр бүсийн 3, 4 дүгээр хэсэгт авто зам, холбоо дохиолол, усан хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамж, дулааны станцын барилга байгууламжуудыг барьж байгуулсан байна.

**Авто зам, холбоо дохиолол:**

Чөлөөт бүсийн эхний ээлжийн хатуу хучилттай авто зам, холбоо дохиоллын барилгын ажил дуусаж барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах Улсын комисс ажиллаж, чөлөөт бүс дэх хатуу хучилттай 13,5 км авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, холбоо дохиоллын сувагчлалын ажил хийгдсэн.

**Дулаан хангамж:**

"Замын-Үүд" суманд 90 мв хүчин чадалтай дулааны станц, чөлөөт бүсэд 5 ЦТП холбогдох шугам сүлжээний хамт хийгдсэн.

Монгол Улсын Засгийн газар "Замын-Үүд дулааны станцын ТӨҮГ"-т 1,5 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийг Засгийн газрын нөөцөөс гаргахаар шийдвэрлэсний дагуу 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн "Замын-Үүд" чөлөөт бүс болон Замын-Үүд сумыг дулааны станцтай холбож, байнгын үйл ажиллагаанд оруулан, хэрэглэгчдийг дулаанаар хангаж эхэлсэн.

**Усан хангамж, ариутгах татуурга:**

Замын-Үүд сумын нийт 20 мянга гаруй иргэд болон "Замын-Үүд" чөлөөт бүсийг цэвэр усаар хангах хоногт 3400 $м^3$ хүчин чадалтай ус цэвэршүүлэх үйлдвэр, чөлөөт бүсэд байрлах 1600$м^3$/цагт хүчин чадалтай станцийг шугам сүлжээний хамт барьж байгуулсан.

**Цахилгаан хангамж:**

Замын-Үүд сумын 110/10кВ-ийн дэд станцыг өргөтгөж ЦДАШ-аар "Замын-Үүд" чөлөөт бүсэд 2х16 мВт хүчин чадалтай дэд өртөөг барьж холбосон.

Мөн холбогдох 10 кВ-ын 2 ширхэг хуваарилах байгууламж, 10/04 кВ-ын 16 дэд өртөөг тус тус барьж байгуулсан. Мөн чөлөөт бүс доторх цахилгаан хангамжийн дэд

өртөөний тоноглолын ажилд шаардагдах 1,4 тэрбум төгрөгийн зардлыг 2022 оны улсын төсөвт оруулсан.

**Хэрэгжүүлж буй төсөл:**

“Замын-Үүд” чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөнд тодотгол хийх ажил болон 30 сая ам.долларын зээлийн санхүүжилтийн хүрээнд “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл” амжилттай хэрэгжиж байна.

**Төслийн хүрээнд:**

1. Чөлөөт бүсийн 300 га газрын дэд бүтцийн хангамж барих багц:

- 2022-2025: 3 км авто зам, 4 эгнээ явган хүний зам, гэрэлтүүлэг;
- 2022-2025: Инженерийн дэд бүтцийн салбар шугам сүлжээ;
- 2022-2025: Орц, гарц;
- 2023-2025: Хог дахин боловсруулах үйлдвэр;
- 2023-2025: Аюулгүйн зурваст хашаа.

2. “Замын-Үүд” чөлөөт бүсийн тогтвортой менежмент, үйл ажиллагааг дэмжих багц ажил:

- 2021-2023: Бизнес, зах зээлийн стратеги боловсруулах;
- 2021-2025: Төр, хувийн хэвшлийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих;
- 2021-2025: Худалдаа эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломжийг дэмжих.

3.”Замын-Үүд” чөлөөт бүсийн боомтын нэвтрэх системийг байгуулах багц ажил:

- 2020-2025: Зорчигч, тээврийн хэрэгслийн хяналтын систем;
- 2020-2025: Хилийн менежментийн нэгдсэн систем.

**Эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:**

Ажлын байр:

- 2025 онд **9400**
- 2030 онд **15000**
- 2035 онд **18000**

Цаашид гарах үр нөлөө:

- Жил бүр ДНБ **1,6-2,3%** өснө.
- **2500** нэр төрлийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой.
- **2026** Үйл ажиллагаагаа явуулж буй хөрөнгө оруулагчид 70.0 хувиар нэмэгдэнэ.
- Гадаадын хөрөнгө оруулалт 2034 онд **2,9 тэрбум** ам.долларт хүрнэ.

**Одоогийн байдлаар чөлөөт бүсэд:**

- Барилгын материалын үйлдвэр 2,
- Мах махан бүтээгдэхүүний үйлдвэр 1,
- Агуулах, логистикийн 1 төвийн эхний шатны бүтээн байгуулалтын ажил,
- Худалдаа үйлчилгээний 2 төвийн барилгын ажил эхэлсэн байна.

2021 онд “Замын-Үүд” чөлөөт бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт зарлаж 13.5 га газрыг 15 аж ахуйн нэгжид олгосон.

Үүний үр дүнд “Замын-Үүд” чөлөөт бүсэд хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдсэн бөгөөд нийт 88 төсөл хөтөлбөр хэрэгжихээр төлөвлөгдсөн.

Одоогийн байдлаар 36 ААН үйл ажиллагаагаа эхлүүлэхээр зураг төслөө боловсруулаад байгаа бол 11 ААН шинээр үйл ажиллагаагаа эхлүүлэхээр бэлтгэн ажлуудаа хийгээд явж байна.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар нь хоёр улсын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг бэхжүүлэн хөгжүүлэх, Монгол Улсын “Хөгжлийн зам” хөтөлбөр болон БНХАУ-ын “Бүс ба Зам” санаачилгын уялдааг бэхжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааны түвшнийг дээшлүүлэх зорилгоор тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх үзэл санааг баримтлан, эрх тэгш, харилцан ашигтай хөгжих зарчмын үндсэн дээр “Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийг байгуулахаар тохиролцсон.

Хоёр улсын Засгийн газраас бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаа болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлснээр Монгол, Хятадын найрсаг хамтын ажиллагааны жишиг бүсийг өөрсдийн нөөц боломж, давуу талд тулгуурлан, хоёр талын эдийн засгийн ашиг сонирхлыг харгалзаж, хөрөнгө оруулалт болон бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, хамтын ажиллагааны механизмыг боловсронгуй болгох замаар нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгах зарчмыг баримтлан, хамтын ажиллагааны бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж байна.

Уг төлөвлөгөөг талууд өөр өөрсдийн талын бүсийн төлөвлөлт, бүтээн байгуулалт, худалдаа, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, тээвэр ложистик, аялал жуулчлал, үйлчилгээ зэрэг салбаруудыг уялдаа холбоотойгоор ижил түвшинд хөгжүүлэхийг үндэс болгож, хамтын ажиллагааны бүсийн ерөнхий төлөвлөгөөг харилцан уялдаатай боловсруулахын зэрэгцээ үйл ажиллагаа явуулах аюулгүй байдлыг хангахад чиглэсэн зүйл заалтыг төлөвлөгөөний хавсралтад тусгаж, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг дээдлэн, хуулийн хүрээнд хамтран ажиллахаар болсон.

Хамтын ажиллагааны бүсийн Монголын талын нутаг дэвсгэрт Монгол Улсын, Хятадын талын нутаг дэвсгэрт БНХАУ-ын талын хууль тогтоомж тус тус үйлчлэхээр хэлэлцээрт тусгагдсаны дагуу “Монгол Улс, БНХАУ хооронд байгуулсан хоёр талт олон улсын гэрээ болон талуудын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээ хамтын ажиллагааны бүсийн тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчилнэ” гэж[4] заасан байна.

Тухайлбал, эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн монголын талын хэсэг нь Монгол Улсын Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт орших Замын-Үүд чөлөөт бүсийн 900 га газар нутаг бөгөөд координат нь зүүн талаараа хилийн Замын-Үүд боомт, баруун талаараа Борхойн тал, хойд талаараа хилийн зурвас, урд талаараа монгол Улсын хилээс 800 метр зайд байрлахаар, Хятадын талын хэсэг нь БНХАУ-ын Өвөр

[4] Замын-Үүд, Эрээний хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Уб., 2019 он.

Монголын өөртөө Засах Орны Эрээн хотын нутаг дэвсгэрт байрлах 903 га газар нутаг бөгөөд координат нь зүүн талаараа ачаа тээврийн замаас 70 метр, баруун талаараа хилийн шалган нэвтрүүлэх байрнаас 600 метр зайд, хойд талаараа хил хамгаалалтын зориулалт бүхий тусгай бүсийн өмнөд хэсэгтэй, урд талаараа хил хамгаалалтын зориулалт бүхий тусгай хашаатай залгаа байхаар тус тус тогтоосон.

Дээр дурдагдсан нутаг дэвсгэр нь улсын хилийн шугамаас 800 метр зайд БНХАУ-ын талтай зах нийлэн оршиж байгаа талаар хоёр улсын Засгийн газрын хэлэлцээрийн хоёрдугаар бүлгийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2 дахь хэсгүүдэд тус тус тусгагдсан нь хамтын ажиллагааны бүсийг улсын хилийн зурваст тэр тусмаа хилийн шугамын дагуу байгуулж, бүсийг хооронд нь хил дамнасан байгууламжаар холбохоор талууд харилцан тохиролцсон явдал юм.

Ийнхүү Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай хоёр улсын засгийн газрын шийдвэр гарсан нь далайд гарцгүй, хоёр хөрштэйгөө эх газраар хиллэдэг Монгол Улсын хувьд худалдаа, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэхэд ололттой байж болох хэдий ч тухайн бүсийг улсын хил дамнуулан байгуулах нь манай улсын хувьд цоо шинэ асуудал бөгөөд энэ нь дэлхийн улс орнуудад амжилттай хэрэгжсэн нь харьцангуй цөөхөн юм.

Хил орчмын бүс нутгийг онцгой бодлогоор дэмжих нь чухал хэдий ч хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг байгуулахдаа учрах эрсдэлийг урьдчилан тодорхойлох, Монгол Улсын хууль хяналтаас гадуурх бүс болж хувирах, хил орчмын ард иргэдийн аюулгүй байдал хөндөгдөх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал алдагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд онцгойлон анхаарах, чөлөөт бүсийн тухай хуулийг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад хуулиудтай нягт уялдуулах, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын санал, дүгнэлтийг эрсдэлийн үнэлгээнд тусгах зэрэг өргөн хүрээтэй арга хэмжээг авч ажиллах нь чухал юм.

**Хамтын ажиллагааны талаар.**

**1) Газар зүйн байршлын давуу тал:** Монгол, Хятад хоёр орон нь Евро-Азийн эх газарт хэдэн мянган километрийн хөрш орны хилийн шугамаар зааглагдан оршино. Газар зүйн байршлын ижил төстэй байдал, мөн эртний тал нутгийн нүүдэлчин соёл, түүх, шашин шүтлэг, оюун санааны итгэл үнэмшил зэрэг байдал нь хамтын ажиллагааны бүс байгуулах нийгмийн соёлын таатай орчныг бүрдүүлж байгаа юм.

Түүний зэрэгцээ Хятадын “Бүс ба зам” санаачилга, Монголын ”Хөгжлийн зам” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн гарц, Монгол, Хятад, Орос гурван орны эдийн засгийн коридорын цөм хот болж далайд гарцтай олон улсын стратеги бүхий байршил нь хамтын ажиллагааны бүсэд давуу нөхцөл байдлыг бүрдүүлж байгаа юм.

**2) Хамтын ажиллагаа:** Монгол улс 2004 онд Замын-Үүд чөлөөт бүсийг байгуулж, улмаар 2015 онд Монгол Улсын Их хурлаар “Чөлөөт худалдааны бүсийн тухай хууль”- ийг батлан, хэрэгжүүлснээр хамтын ажиллагааны бүсэд хууль эрхзүйн орчныг бүрдүүлж өгсөн.

Сүүлийн жилүүдэд хоёр орон хөршийн найрсаг харилцаагаа улам бүр бэхжүүлж улс төр, эдийн засаг, соёлын харилцаа хамтын ажиллагаагаа өргөн цар хүрээтэйгээр тэлж олон талт, олон түвшний, олон салбарыг хамарсан хамтын ажиллагааг бий болгосон байна.

2014 оны 8 дугаар сард БНХАУ-ын дарга Ши Зиньпин Монгол Улсад төрийн айлчлал хийж “Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал” болон бусад хоёр талт хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурж Монгол, Хятадын харилцааг иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаанд хүргэсэн.

Хоёр орон мөн оны тухай санамж бичиг”-ийг байгуулан хамтын ажиллагааны бүс байгуулах үндэс суурийг бат бөх тавьж өгсөн.

Өнөөгийн байдлаар Монголын тал өөрийн хэсгийн 9 км2 талбайн ерөнхий тоймыг гаргаж зам харилцаа, ус, цахилгаан, дулаан хамгамж, холбоо дохиолол зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж дууссан бол Хятадын тал өөрийн хэсгийн 9.03 км2 талбайн дэд бүтцийг шат дараатайгаар гүйцэтгэж байна.

2019 оны 6 дугаар сард Монгол, Хятад хоёр орон “Монгол Улс, БНХАУ-ын засгийн газар хоорондын Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай хэлэлцээр”-ийг албан ёсоор байгуулсан.

Монгол, Хятад, Орос гурван улсын төрийн тэргүүнүүдийн тав дахь удаагийн дээд хэмжээний Албан бус орчуулга 5 Хятад, Монголын Эрээн хот-Замын-Үүдийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хамтад нь хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө (2019-2035) уулзалт Киргизстаны нийслэл Бишкек хотноо зохион байгуулагдаж, гурван орны тэргүүнүүд бүх талаар хамтран ажиллах чухал асуудлуудыг хэлэлцэн хамтын ажиллагааны хөгжлийн чиг хандлагыг илүү тодорхой болгосон.

**3) Нөөц боломжоороо харилцан нөхөх асуудал:** Монгол Улс нь далайд гарцгүй бөгөөд нүүрс, газрын тос, байгалийн хий болон өнгөт металл зэрэг байгалийн нөөц баялаг ихтэй орон юм. Мөн малын идэш тэжээл, хонь үхэр зэрэг мал амьтан болон эмийн ургамлын нөөц баялгаараа давуу талуудтай бөгөөд эдийн засгийн хурдтай хөгжих үе шатандаа байгаа орон юм.

Харин БНХАУ-ын хувьд дэлхийн хоёр дахь том эдийн засагтай орон бөгөөд эдийн засгийн эрчимтэй хөгжил, аж үйлдвэрлэлийн боловсронгуй систем, асар том зах зээлийн орон зай, техник технологийн хурдацтай хөгжиж, дэвжиж байгаа орон болно.

Цаашид Хятад Монгол хоёр орон байгалийн нөөц баялаг, зэх зээл, хөрөнгө мөнгө, технологи, далайн гарц гарам зэрэг талаар хамтран ажиллах ихээхэн боломжтой байна.

Эрээн хот олон улсын худалдаа, логистик болон импорт, экспортын боловсруулалт зэрэг боомтын эдийн засгийн чадавхаа эрчимтэйгээр хөгжүүлж байгаа бөгөөд 2017 онд хотын ДНБ 10.18 тэрбум юань, импорт экспортын худалдаа 20.5 тэр бум юань, 2018 онд ДНБ болон импорт, экспортын худалдааны хэмжээ тус бүрдээ 4.0-15.0 хувиар нэмэгдсэн.

Замын-Үүд нь Хятад улсад түшиглэсэн хамгийн том хуурай замын боомт бөгөөд худалдаа, логистик болон холбогдох үйлчилгээ үйлдвэрлэлээ эрчимтэй хөгжүүлж байгаа ба импортын бараа нь Монгол Улсын импортын барааны нийт хэмжээний 90.0 хувиас дээш хувийг эзэлж, татварын орлого улсын нийт төсвийн 30%-иас дээш хувийг бүрдүүлж байна.

Мөн дэд бүтцээ тасралтгүй сайжруулж ЗамынҮүдийн чөлөөт бүсийн үндсэн бүтээн байгуулалтыг барьж дуусгасан нь Монгол улсын эдийн засгийн хөгжилд чухал байр суурийг эзлэх юм.

Хоёр тал нь хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалт, худалдаа, байгаль орчныг хамгаалах зэрэг тал дээр голлон хамтарч ажилласаар ирсэн.

Хоёр тал хамтын ажиллагааны бүс байгуулснаар давуу талаараа харилцан нөхөж хамтдаа хөгжих нөхцөл бүрдэх юм.

**4) Хамтран ажиллах хүсэл эрмэлзэл:** Хятадын "Бүс ба зам" санаачилга болон Монголын "Хөгжлийн зам" хөтөлбөрийн хүрээнд, хоёр тал хамтын ажиллагаагаа бэхжүүлсээр байгаа бөгөөд хоёр орны тэргүүнүүд олонтоо харилцаж, өргөн хэмжээний уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж улс төрийн харилцан итгэлцлээ нэмэгдүүлж, Монгол, Хятадын иж бүрэн хамтын ажиллагааны түншлэлийн харилцаа хүрээгээ улам бүр тэлж, хоёр талын худалдааны хэмжээ тасралтгүй өсөн нэмэгдэж байна.

Хятад, Монголын Эрээн хот-Замын-Үүдийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хамтад нь хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө (2019-2035) тэрбум ам. долларт хүрч, нийт гадаад худалдааны 64,1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 35,8 хувиар нэмэгдсэн нь 2020 он гэхэд хоёр талын худалдааны нийт хэмжээ 10 тэрбум ам.долларт хүрнэ гэж тооцсон байна.

Өнөөгийн байдлаар, олон улсын худалдааны байдал тогтворгүй, монополчилсон байдал, хаалттай худалдааны бодлого газар авч байгаа нь олон талт худалдаа хийхэд томоохон саад учруулж байгаа юм.

Иймд олон улсын худалдааны зах зээлд шинэ гарцыг эрэлхийлэн, Монгол, Хятад хоёр орны засгийн газар хамтын ажиллагаагаа улам бүр бэхжүүлэх байр суурьтай байгаагаа илэрхийлж хил дамнасан хамтын ажиллагааны бүс байгуулах ойлголцолд хүрсэн билээ.

Харилцан итгэлцлийн сууриа батжуулж, хамтран ажиллах чин хүсэлтэй байгаа нь хамтын ажиллагааны бүсийг хөгжүүлэхэд нөхөрсөг таатай уур амьсгалыг бүрдүүлж байгаа юм.

Хамтын ажиллагааны бүс байгуулах ач холбогдол Хятад, Монгол хоёр орны Эрээн, Замын-Үүдийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг бүтээн байгуулснаар Олон улсын аж үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, үндэстэн дамнасан бүсийн бүтээн байгуулалт, хил дамнасан нийгмийн хамтын ажиллагааны шинэ арга замуудыг эрэлхийлэхийн зэрэгцээ хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэх чухал алхам болж, хоёр улсын төрийн тэргүүн хоорондын зөвшилцлийг хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх гол арга зам юм.

Түүнчлэн "Бүс ба зам" санаачилга болон "Хөгжлийн зам" хөтөлбөрийг хооронд нь уялдуулан, Монгол, Хятад, Орос гурван орны эдийн засгийн коридорыг хамтран байгуулах чухал зангилаа болж, хоёр орныг гадаад зах зээлтэй холбох гол гүүр, харилцан итгэлцэж, хамтран ажиллах, хамтдаа хөгжих үр шимийн тусгал байх болно.

Мөн давуу талаа ашиглан сул талаа нөхөх процессыг хурдасгаж, үндэстэн дамнасан үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлэхэд ажлаа хуваарилан, хамтран ажиллаж, хоёр талын үйлдвэрлэлийн зүй зохистой бүтцийг урагш ахиулж, тэнцвэртэй хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх юм.

Үүний зэрэгцээгээр хилийн бүс районы үндсэн дамнасан эко зохицуулалт болон хамтран урьдчилан сэргийлэх, хамтран засан сайжруулах, экологи байгаль орчныг

хамгаалах болон эко соёлыг бүтээн байгуулж, ногоон хөгжлийг авчрах болно.

Тэрээр үндэстэн дамнасан аж үйлдвэрийн районы шинэ загварыг бүтээж, шинээр бий болж буй үндэстэн дамнасан хамтын ажиллагааны бүтцийг хамтаар цогцлон байгуулж, хамтран менежмент хийж, хамтран засан хөгжүүлнэ.

Энэ нь алсын хараатай, улам өргөн хүрээг хамарсан олон улсын хамтын ажиллагаанд туршлага хуримтлуулах бодит жишээ болох болно.

**Хамтын ажиллагааны бүс байгуулах ач холбогдол:**

Хятад, Монгол хоёр орны Эрээн, Замын-Үүдийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг бүтээн байгуулснаар Олон улсын аж үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, үндэстэн дамнасан бүсийн бүтээн байгуулалт, хил дамнасан нийгмийн хамтын ажиллагааны шинэ арга замуудыг эрэлхийлэхийн зэрэгцээ хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэх чухал алхам болж байгаа ба хоёр улсын тэргүүн хоорондын зөвшилцлийг хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх гол арга зам юм.

Түүнчлэн “Бүс ба зам” санаачилга болон ”Хөгжлийн зам” хөтөлбөрийг хооронд нь уялдуулан, Монгол, Хятад, Орос гурван улсын эдийн засгийн коридорыг хамтран байгуулах чухал зангилаа болж, хоёр орныг гадаад зах зээлтэй холбох гол гүүр, харилцан итгэлцэн, хамтран ажиллах, хамтдаа хөгжих үр шимийн тусгал байх болно гэж үзэж байна.

Мөн давуу талаа ашиглан, сул талаа нөхөх процессыг хурдасгаж, үндэстэн дамнасан үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлэхэд ажлаа хуваарилан хамтран ажиллаж, хоёр талын үйлдвэрлэлийн зүй зохистой бүтцийг урагш ахиулж, тэнцвэртэй хөгжүүлэх боломж юм.

Үүнээс гадна хилийн бүс орчимд үндэстэн дамнасан эко зохицуулалт болон хамтран урьдчилан сэргийлэх, хамтран засаж сайжруулах, экологи байгаль орчныг хамгаалах болон эко соёлыг бүтээн байгуулж, ногоон хөгжлийг авчрах болно.

Тэрээр үндэстэн дамнасан аж үйлдвэрийн районы шинэ загварыг бүтээж, шинээр бий болж буй үндэстэн дамнасан хамтын ажиллагааны бүтцийг хамтаар цогцлон байгуулж, хамтран менежмент хийж, хамтран засан хөгжүүлэх нь алсын хараатай, улам өргөн цар хүрээг хамарсан олон улсын хамтын ажиллагаанд туршлага хуримтлуулах бодит жишээ болох юм.

**Стратегийн ач холбогдол:**

Хамтын ажиллагааны бүсийн газарзүйн байршил, нөөц баялаг, давуу талуудаа бүрэн дүүрэн гаргаж, хил дамнасан хамтын ажиллагаа, гаалийн татвар болон чөлөөт худалдааны тухай хэд хэдэн бодлогуудыг нэгтгэн, илүү уян хатан нээлттэй бодлоготой болохын төлөө хамтран “Гурван бүс, хоёр бааз, нэг уулзвар”-ыг бүтээнэ.

1) “Гурван бүс” гэдэг нь Монгол, Хятад хоёр орны иж бүрэн стратегийн хамтын ажиллагааны түүчээ бүс, хилийн чөлөөт худалдаа хамтын ажиллагааны туршилтын бүс, хил дамнасан аялал жуулчлалын жишиг бүс болно.

**Монгол, Хятад хоёр орны иж бүрэн стратегийн хамтын ажиллагааны түүчээ бүс:**

Хамтын ажиллагааг чөлөөтэй хэрэгжүүлэх шинэ механизм, шинэ загварыг бий

болгож, хамтын ажиллагааны бүс дэх хоёр орны төрийн бодлогыг бүрэн хэрэгжүүлж, системийн нэгдэл шинэчлэлийг нэмэгдүүлж, Монгол, Хятад хоёр орны ажил хэргийн хамтын ажиллагааг улам бүр гүнзгийрүүлж, хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны утга агуулгыг улам бүр баяжуулж, эдийн засгийн өсөлтийн цэг болсон орчин цагийн шинэлэг газрыг байгуулж, хилийн бүс нутгийг нээн хөгжүүлэхэд үлгэр дууриал болхуйц бүсийг хамтран байгуулах юм.

**Хилийн чөлөөт худалдаа, хамтын ажиллагааны туршилтын бүс:**

Чөлөөт худалдааны бүсийн загварыг хамтын ажиллагааны бүсийн бодит байдал, хөгжлийн зорилттой уялдуулан, дүрэм журмын шинэчлэл, системийн шинэчлэлт хийн хэрэгжүүлэх арга замыг эрэлхийлж, олон улсын худалдаа, хяналт шалгалт, боловсрол шинжлэх ухаан технологи, хил дамнасан цахим худалдаа, санхүү, аялал жуулчлал, олон улсын эмчилгээ зэрэг шинэ салбар үйлчилгээний үйл ажиллагааг дэмжин боловсон хүчний, барааны, хөрөнгө оруулалтын, худалдаа, тооцооны эрх чөлөөг бүрэлдүүлж хилийн чөлөөт худалдааны бүсийг хамтран байгуулна.

Хил дамнасан аялал жуулчлалын жишээ бүс: Эрээн хот болон Замын-Үүдийн өөрийн гэсэн онцлог бүхий нөөц боломжийг ашиглан, хамтын ажиллагааны бүсийн “хил гаалиар нэвтрүүлэхэд хялбар, хүн бараа чөлөөтэй нэвтэрдэг” давуу талыг ашиглан, аялал жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалт болон барилга байгууламжуудыг сайжруулж, худалдааны болон чөлөөт цагаа өнгөрүүлэх зориулалттай барилга байгууламжуудыг барьж байгуулан, “хамтын ажиллагааны бүсийн үндэстэн дамнасан аялал жуулчлалын тусгай маршрут шугам”-ыг хэрэгжүүлж эхэлнэ.

Энэхүү маршрут нь хилийн гаднах бусад аялал жуулчлалын маршруттай холбогдож байгаа бөгөөд хоёр бүс нутгийн хүмүүс хилийн цаадах бүсэд аялал жуулчлалаар шууд нэвтэрдэг замыг бий болгоно.

Эрүүл мэнд биеэ сувилах, татвараас чөлөөлөгдсөн худалдаа, спортын тэмцээн, соёлын шинэ санаачилга зэрэг үндэстэн дамнасан эрүүл мэндийн аялал жуулчлал зэргийг шинээр хөгжүүлэн нээж, үндэстэн дамнасан аялал жуулчлалынхаа төрөл зүйл болон хүмүүсийн харилцааг тасралтгүй нэмэгдүүлж, “үндэстэн дамнасан үлгэр жишээ бүс”-ийг хамтаар бүтээн байгуулна.

2) “Хоёр бааз” гэдэг нь олон улсын логистикийг хүлээн авах, тараах үйлчилгээний бааз, мөн Монгол, Хятад, Орос болон европын орнууд руу чиглэсэн импорт экспортын барааны боловсруулалтын бааз юм.

**Олон улсын логистикийг хүлээн авах, тараах үйлчилгээний бааз:**

Хамтын ажиллагааны бүсийн хил дамнасан байршлын давуу тал, гаалийн нэгдсэн чөлөөлөлтийн бодлогод түшиглэн авто-төмөр замын хосолсон тээврийн логистик боомт, гаалийн баталгаат агуулах, хил дамнасан ачаа тээвэрлэх зориулалтын зам, шугам болон бусад дэд бүтцийн бүтээн байгуулах ажлыг хурдасган, өндөр нэмүү өртөг шингэсэн гаалийн татваргүй барааг хадгалах, тээвэрлэх, тараах, төвлөрүүлэх зэрэг олон улсын логистикийн дамжин өнгөрөх, түгээлтийн үйлчилгээг эрчимтэй хөгжүүлнэ.

Газрын тос, байгалийн хийн стратегийн нөөц, баталгаат засвар үйлчилгээ гэх мэт Хятад, Монголын Эрээн хот-Замын-Үүдийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг

хамтад нь хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд (2019-2035) логистикийн үйлчилгээг идэвхтэй хөгжүүлэх, барааны урсгалын мэдээллийг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх, логистикийн шинэ загварыг эрэлхийлэх, удирдлага менежментийг тасралтгүй сайжруулах, олон улсын нөөц боломжийг зөв хуваарилах чадвараа нэмэгдүүлж, логистик үйлчилгээ болон худалдааг хослуулан хөгжүүлэх зэрэг багтсан байна.

**Хятад, Орос болон европын орнууд руу чиглэсэн импорт, экспортын барааны боловсруулалтын бааз:**

Олон улсын зах зээлд хүрэх зорилготойгоор, хамтын ажиллагааны бүсийн гаалийн татвараас чөлөөлөх болон чөлөөт худалдааны нэгдсэн бодлогыг ашиглан, Монгол, Хятад, Орос гурван улсын болон барууны бусад улс орнуудын зах зээлд чиглэсэн хүнсний бүтээгдэхүүн, хувцас эдлэл, үнэт эдлэл, металл тоног төхөөрөмжийн импорт, экспортын бараа бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрүүдийг эрчимтэйгээр хөгжүүлэх;

Монгол Улсад хэрэгжиж буй Хөнгөлөлтийн Ерөнхий Системийг ашиглан Монгол, Хятадын гарал үүслийн гэрчилгээжүүлэлтийн системийг үүсгэх ажлыг эрчимжүүлж, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээг хялбаршуулах, олон улсын зах зээлд нөлөө бүхий импорт экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бааз болгон хөгжүүлнэ.

3) “Нэг уулзвар” гэдэг нь Монгол, Хятад, Орос гурван орны эдийн засгийн коридорын чухал цэг болохыг хэлнэ.

**Хятад, Монгол, Орос гурван орны эдийн засгийн коридорын цэг:**

-Орчин үеийн логистикийн үйлчилгээг дагаад, хил дамнасан дэд бүтцийн бүтээн байгуулалтын болон барилга байгууламжийн хоорондын уялдаа холбоог сайжруулан, Хятад Монгол хоёр орны хил гаалийн хяналт шалгалтын дүрэм, журмыг улам сайжруулж, хамтарсан хяналт шалгалт хийж харилцан зөвшөөрөх тогтолцоог бүрдүүлэн, хил гаалийн нэвтрүүлэх процессыг хялбар болгож, олон улсын бараа нэвтрүүлэх зам сувгийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, хамтын ажиллагааны бүсийг олонургалч, биет, өө сэвгүй, байгальд ээлтэй, эко ухаалаг систем бүхий цогц зам харилцааны тээвэрлэлтийн системийг бүрдүүлэх;

-Олон төрлийн хамтарсан тээвэрлэлт болон олон улсын тээврийн төв цэг болгохын төлөө ажиллана. Монгол улсын Улаанбаатар төмөр зам, Оросын Евро-Ази дамнасан төмөр замын тээврийн сүлжээнд идэвхтэй оролцож, хамтын ажиллагааны бүсийг Хятад, Монгол, Орос эдийн засгийн коридор дэх чухал зангилаа цэг болгон хөгжүүлэх зэрэг юм.

**Хөгжлийн зорилт:**

“Эхний гурван жил дэд бүтцээ байгуулж, дараагийн таван жилд томоохон хэмжээний бүтээн байгуулалтыг хийж, түүний дараах арван жилд их хөгжлийг авчрах” зорилт дор, төлөвлөгөө гаргаж, үе шат болгон хуваан хэрэгжүүлж, тогтвортойгоор урагш явуулж, цаг хугацаа, хөгжлийн агуулгаа тодорхой гарган ойрын 15 жилийн хугацаанд хамтын ажиллагааны бүсийг нийгэм эдийн засаг нь хөгжсөн, байнгын худалдаа хийгддэг, экологи, байгаль орчин тэнцвэртэй, эв эеийг эрхэмлэсэн нийгэмтэй, үйлдвэрлэл ба хүн соёлын харилцаа тэнцвэртэй, орчин үеийн хилийн үйлдвэрлэлийн шинэ хотыг бүтээн байгуулсан байна.

Хамтын ажиллагааны бүсэд зам, усан хангамж, ус дамжуулах зайлуулах хоолой,

цахилгаан хамгамж, дулааны хангамж, байгалийн хий, харилцаа холбоо, хашлага зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд үндсэндээ хийгдэж дууссан байна.

Боомтын хүчин чадал нэмэгдэж хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагаа илүү боловсронгуй болж, логистик, боловсруулах үйлдвэрлэл, хил дамнасан аялал жуулчлал, шинэ үйлчилгээний салбар гэх мэт өөрийн гэсэн онцлог бүхий эко үйлдвэрлэлийн систем байгуулж Монгол, Хятад хоёр орны хамтын ажиллагаа хөгжлийн шинэ шатанд хүрнэ.

Бүсийн эдийн засгийн ерөнхий чадавхи мэдэгдэхүйц нэмэгдэж, хамтын ажиллагааны бүсийн ДНБ 6 тэрбум юаньд хүрч, үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт 15 хувиас илүү, нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 5 тэрбум юань давж, импорт экспортын нийт хэмжээ 5 тэр бум ам долларт хүрнэ.

2030 он гэхэд хамтын ажиллагааны бүтээн байгуулалт үргэлжлэн хийгдэх, логистик, импорт, экспортын бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэл зэрэг голлох аж үйлдвэрүүд хурдацтай хөгжиж, өндөр технологийн үйлдвэрлэл, орчин үеийн үйлчилгээний салбар цэцэглэн хөгжиж, харилцан ашигтай хамтын ажиллагааны шинэ нөхцөл байдлыг бий болгох; талуудын хамтын ажиллагаа цар хүрээгээ тэлж, бүс нутгийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлж, хамтын ажиллагааны бүсийн ДНБ 8.5, нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 8 тэрбум юаньд хүрч, импорт, экспортын нийт хэмжээ 12 тэрбум ам доллар давах болно.

2035 он гэхэд хамтын ажиллагааны бүтээн байгуулалтын ажил бүрэн дуусч, нээлттэй, инновацын өндөр чадавхи бүхий үлгэр жишээ хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны загварыг бий болгосон байна.

Аж үйлдвэрлэлийн систем өдрөөс өдөрт боловсронгуй болж бүтэц, цар хүрээ нь өсөн сайжрах бөгөөд бүс нутгийн эдийн засгийн хөгжил үр өгөөжөө өгч, ДНБ болон үйлдвэрлэлийн нийт хэмжээ 10 тэрбум юаньд, импорт, экспортын нийт хэмжээ 20 тэрбум ам долларт хүрэх тус тус хүргэхээр зорилт тавин ажиллах юм.

**(Хүснэгт 9) Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн хөгжлийн голлох үзүүлэлтүүд**

| Д/д | Гол үзүүлэлтүүд | Нэгж | Хугацаа | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Богино хугацааны 2025 он | Дунд хугацааны 2030 он | Урт хугацааны 2035 он |
| 1 | Бүс нутгийн ДНБ | 100 сая юань | 60 | 85 | 100 |
| 2 | Үйлдвэрлэлийн нийт хэмжээ | 100 сая юань | 50 | 80 | 100 |
| 3 | Импорт, экспортын нийт хэмжээ | 100 сая ам.доллар | 50 | 120 | 200 |
| 4 | Монгол, Хятадын худалдааны хэмжээ | 100 сая ам.доллар | 40 | 90 | 120 |
| 5 | Хил дамнасан цахим худалдааны хэмжээ | 100 сая ам.доллар | 10 | 20 | 50 |
| 6 | Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ | 100 сая ам.доллар | 25 | 32 | 40 |
| 7 | Ачаа бараа нэвтрүүлэх хүчин чадал | 10 мянган тонн | 500 | 1100 | 2400 |
| 8 | Орлогын Юаний нийт гадаад валютад эзлэх хувь хэмжээ | хувь | 70 | 60 | 50 |
| 9 | Бүсээр орж гарах хүний тоо | 1 удаа 10 мянган хүн | 100 | 180 | 250 |
| 10 | Үйлдвэрийн бохир усыг дахин ашиглалтын хувь | хувь | 95 | 100 | 100 |
| 11 | Олон улсын логистикийн үйл ажиллагааны давтамж | Удаа | 5 | 7 | 10 |
| 12 | Хил дамнасан аялал жуулчлалын нийт орлого | 100 сая юань | 10 | 15 | 25 |

**Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн эрх зүйн орчин:**

Монгол Улсын УИХ-аас улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх, өндөр технологийг нутагшуулах, хөрөнгө оруулалтын таатай орчныг бий болгох, эдийн засгийг төвлөрүүлэх зорилгоор дараах эрх зүйн актуудыг боловсруулан батлуулж, мөрдөн ажиллаж байна. Үүнд:

-Монгол Улсын Их хурлын 1995 оны 87 дугаар тогтоолоор "Эдийн засгийн чөлөөт бүсийн үзэл баримтлал"-ыг баталсан;

-2002 онд "Чөлөөт бүсийн тухай хууль"-ийг баталсан

-2003 онд "Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийг баталсан

-Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 17 дугаар тогтоолоор "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулахаар шийдвэрлэж, нутаг дэвсгэрийн хэмжээг 900 га-гаар тогтоосон;

-Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 187 дугаар тогтоолоор "Замын-Үүд чөлөөт бүсийн Мастер төлөвлөгөө"-г батлуулсан

-2014 оны 09 дүгээр сард Тажикстан улсын Душанбе хотод анхны гурван улсын уулзалт зохион байгуулагдаж, Хятад, Орос, Монголын Эдийн засгийн коридор байгуулах боломжтой гэж үзэн, дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэхээр болсон,

-2015 оны 07 дугаар сард ОХУ-ын Уфа хотод Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хооронд Эдийн засгийн коридор байгуулах тухай санамж бичиг болон Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хооронд худалдааны хөгжлийг дэмжих таатай нөхцөл бүрдүүлэх талаар хамтран ажиллах тухай бусад баримт бичигт гурван улсын холбогдох албан тушаалтнууд гарын үсэг зурсан

-2015 оны 12 дугаар сард "Чөлөөт бүсийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга батлагдаж, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтэц, орон тоо шинэчлэгдсэн

-2019 оны 06 дугаар сард "Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т хоёр талын төлөөлөл гарын үсэг зурсан

-2021 оны 12 дугаар сарын 07-нд "Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл"-ийг УИХ баталсан.

-2021 оны 12 дугаар сарын 23-нд "Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг УИХ соёрхон баталсан.

-2022 оны 01 дүгээр сарын 31-нд "Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр" хүчин төгөлдөр болж, "Замын-Үүд"-ийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах хууль эрх зүйн орчин бүрдсэн байна.

УИХ-аас 2004 онд "Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай" 17 дугаар тогтоолыг баталж, нутаг дэвсгэрийн хэмжээг 900 га байхаар тогтоон, хилийн заагийг тодорхойлсон юм.

Гэтэл хил дамнасан чөлөөт бүсийн асуудал манай улсын хувьд шинэ сэдэв бөгөөд 2014 оноос албан ёсоор яригдах болсон. Учир нь 2014 онд БНХАУ-ын дарга Ши Жинь Пин Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр Монгол Улс, БНХАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах асуудлыг судлах тухай харилцан ойлголцлын санамж бичигт Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам БНХАУ-ын Худалдааны яамны төлөөлөгчид гарын үсэг зурсан билээ. Энэ нь эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах талаарх албан ёсны анхны санаачилга юм.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч БНХАУ-д 2015 оны 11 дүгээр сард төрийн айлчлал хийх үеэр Монгол Улсын Аж үйлдвэрийн яам, БНХАУ-ын худалдааны яам хооронд хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар санамж бичиг байгуулсан.

Уг санамж бичгийн долоодугаар зүйлд "Замын-Үүд болон Эрээний боомтод хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах талаар хамтран судалж, хамтын ажиллагааны зарчмыг тодорхойлно.

Талууд хил дамнасан хамтын ажиллагааны бүс байгуулах урьдчилсан ТЭЗҮ хийх эрсдэлийн үнэлгээ ба менежментийн судалгааг хийх чиглэлээр хамтран ажиллана" гэж[5] заасан.

Энэ хүрээнд "Замын-Үүд болон Эрээний боомтод хил дамнасан эдийн засгийн

[5] "Стратегийн судалгаа" Стратеги судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг сэтгүүл. №84. Уб., 2022 он. 104 дэх тал.

хамтын ажиллагааны бүс байгуулах асуудлыг судлах ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 216 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд хөрөнгө санхүүгийн асуудлыг БНХАУ-ын тал бүрэн хариуцахаар болж, хоёр талаас нэмж 474 га газрыг нэмснээр хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг бүрдүүлэхээр заасан байдаг.

Гэтэл хоёр улсын Засгийн газрын 2019 оны хэлэлцээрт "Хамтын ажиллагааны бүсийг хооронд нь хил дамнасан байгууламжаар холбох бөгөөд улсын хилийн шугамын явалтыг тодорхой байлгах зорилгоор улсын хилийг огтлон гарах цэгийн байршлыг талуудын эрх бүхий байгууллага харилцан хэлэлцэн тохиролцож, газар дээр нь тогтоон протокол үйлдэж, дипломат шугамаар харилцан баталгаажуулна. Аль нэг тал хилийн шугам дээр дангаараа тэмдэглэгээ хийхийг хориглоно.

Талууд хамтын ажиллагааны бүсийн монгол, хятадын хэсгийг холбох хил дамнасан байгууламжийн асуудлаар харилцан хэлэлцэж, тохиролцоно" гэж[6], заажээ.

Дээрх тодорхойлолтыг харахад Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 216 дугаар захирамжид тусгагдсан "Хоёр талаас 474 га газрыг нэмэх" гэсэн хэсэг хоёр улсын Засгийн газрын хэлэлцээрээр өөрчлөгдөж, эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн Монголын талын хэсэг нь Монгол Улсын Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт орших Замын-Үүд чөлөөт бүсийн 900 га газар, хятадын талын хэсэг нь БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө Засах Орны Эрээн хотын нутаг дэвсгэрт байрлах 903 га газар байх бөгөөд газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр инженерийн байгууламжаар холбохоор хоёр улсын хэлэлцээрт тусгасан байна.

**Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд хилийн аюулгүй байдлыг хангахад тулгамдаж буй асуудлууд:**

- Одоогийн мөрдөгдөж буй хилийн тухай болон чөлөөт бүсийн тухай хуулиуд, хил хамгаалалтын дүрэм, хилийн дэглэмийн гэрээнд чөлөөт бүсийн аюулгүй байдал, хамгаалалтын талаар тодорхой зүйл, заалтууд тусгагдаагүй нь хилийн аюулгүй байдлыг хангахад сөргөөр нөлөөлөх;
- Чөлөөт бүс бүхий суурин газруудын оршин суугчид болон чөлөөт бүсээр үйлчлүүлэгчдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрсдэлийн үнэлгээг бодитоор хийж, түүнд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлээгүйн улмаас хил орчмын нутаг дэвсгэр дэх гэмт хэргийн гаралт нэмэгдэж, хэлбэр, агуулгын хувьд илүү төвөгтэй болох;
- Чөлөөт бүс бүхий хилийн боомтууд, хил орчмын нутаг дэвсгэрт төрөл бүрийн тээвэр ложистик, банк санхүү, бизнесийн болон үйлчилгээний аж ахуй эрхлэгчдийн тоо, зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн эрс нэмэгдэж, хилийн дэглэм зөрчигдөх;
- Нийгмийн хэв журам, хууль сахиулах бодлогын хүрээнд зохион байгуулалттай санхүүгийн гэмт хэрэг, татварын хөнгөлөлт, тусгай зөвшөөрөл олголт, гаалийн хяналт шалгалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн бүтээн байгуулалт, хөдөлмөр эрхлэлт, үйлчилгээтэй холбогдолтой авлигын гэмт хэргийн тоо нэмэгдэх;
- Гэмт хэргийн бүлэглэлүүд харилцан тохиролцож, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан бараа бүтээгдэхүүн, зэвсэг, сум галт хэрэглэл, хар тамхи,

[6] "Замын-Үүд, Эрээний хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай" Монгол Улсын Засгийн газар БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2019 оны хэлэлцээрийн хоёр дугаар бүлгийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг.

мансууруулах төрлийн бодис хууль бусаар наймаалцах;

- Техник технологийн хөгжилд тулгуурлан сүүлийн үеийн өндөр хүчин чадал бүхий дуу намсгагчтай нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дрон ашиглан, нам өндрөөр улсын хил зөрчин хууль бус бараа бүтээгдэхүүн зөөвөрлөх, тандалт, судалгааны ажил явуулах зэрэг үйлдлүүд нь үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх зэрэг асуудлууд тулгамдаж байна.

Харин БНХАУ-ын Ерөнхийлөгч Си Жинь Пин 2014 оны 8-р сард Монгол Улсын Их Хуралд үг хэлэх үеэрээ Хятад, Монгол хоёр улсын Эрээн хот-Замын-Үүд болон бусад газарт хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах санал гаргав.

Сүүлийн таван жилийн хугацаанд Хятад, Монгол хоёр улс янз бүрийн түвшинд зөвлөлдөх уулзалт, хэлцлүүдийг зохион байгуулсан бөгөөд Хятад, Монгол улсын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн судалгаа, бүтээн байгуулалтыг идэвхтэй урагшлуулах, Эрээн хот-Замын-Үүд хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ажлыг хурдтайгаар урагшлуулах хэрэгтэй гэжээ.

Хятад, Монголын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд (БНХАУ-ын тал) дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэх стратегийн хамтын ажиллагааны иж бүрэн гэрээг 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр ӨМӨЗО-ны Эрээн хотод байгуулсан бөгөөд Хятад, Монгол Улсын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нь иж бүрэн бүтээн байгуулалтын шатандаа орсныг тэмдэглэжээ.

Тухайн өдрийн Эрээн хотын захиргаанаас гаргасан мэдэгдэлд дурдсанаар, Хятадын 22-р төмөрлөгийн групп болон Эрээн хот нь төр хувийн хэвшлийн хамтарсан хэлбэрээр Хятад, Монголын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн (БНХАУ-ын тал) барилгын ажлыг бүтээн байгуулахаар ажиллаж байна гэжээ.

Хятад-Монголын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн Хятадын талын дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын нийт хөрөнгө оруулалт 824 сая юань бөгөөд бүтээн байгуулалтын хугацаа 2 жил гэж тогтоожээ.

Энэ жил газар доорх иж бүрэн хоолой коридор, стандартчилагдсан цехийн суурь барилгын ажил дуусгахаар ажиллаж байна.

Хятад, Монгол Улсын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн 22-р төмөр замын группийн ерөнхий менежер Шэнь Вэнбинь Хятад, Монголын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нь гурван асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж буй талаар танилцуулав. Үүнд:

1.Хил дамнасан бүс дэх авто зам ба газар доорх шугам сүлжээ.

2.Хил орчмын газар доорх иж бүрэн шугам хоолойн коридорын төсөл 4536 метр орчим.

3.Үйлдвэрүүд болон оффисын зориулалттай барилга байгууламжийн стандартчилагдсан төсөл.

Төслийн хамтын ажиллагааны хугацаа 15 жил байх бөгөөд тэдгээрийн дотор барилгын хугацаа 2 жил, ашиглалтын хугацаа 13 жил байна гэж тусгажээ.

Хотын намын хорооны нарийн бичгийн дарга, Эрээн хотын захирагч Тиан Юүнь хэлэхдээ, 2014 онд энэхүү хотыг үндэсний түлхүүрийн бүтээн байгуулалт, нээлтийн

туршилтын бүс болгон нээхээр баталснаас хойш туршилтын бүс байгуулах ажлыг яаралтай эхлүүлж, Хятад, Монголын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг гол бүтээн байгуулалт, нээлтийн туршилтын бүс болгохоор туршилтын төсөл болгон тодорхойлсон байна.

Энэ нь хилийн дагуу нээх шинэ загварыг судлах, Хятад, Монголын олон талт солилцоо, хамтын ажиллагааг дэмжих, олон талт хөгжил, харилцан ашигтай байх зэрэг ач холбогдолтой юм гэжээ.

Хятадын мэдээ, мэдээллийн агентлагийн сурвалжлагч хэлэхдээ, одоогийн байдлаар Хятад, Монгол Улсын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд захын цэргийн байгууламж, зам, хашаа барих болон бусад төслүүдийн бүтээн байгуулалт дуусжээ.

Хил дамнуулахаар төлөвлөж буй талбай нь 18 хавтгай дөрвөлжин км бөгөөд үүнээс 9 км нь Хятад, Монгол улс тус бүрд зориулагдсан бөгөөд хоёр улсын “хоёр улс нэг бүс, хилийн хилийн дотор гаалийн гадна, хаалттай үйл ажиллагаа” загвараар дамжин олон улсын худалдаа, ложистик, агуулах, импорт экспортын боловсруулалт, цахим худалдаа, аялал жуулчлал, үзвэр үйлчилгээ, санхүүгийн үйлчилгээ гэх мэт чиг үүрэг бүхий нэг цогц нэгдсэн хөгжлийн жишиг болох юм гэжээ.

## §2.2.”Алтанбулаг” эдийн засгийн чөлөөт бүсийн өнөөгийн байдал



УИХ-ын 1996 оны 66 дугаар тогтоолоор “Алтанбулаг” чөлөөт бүсийн хилийн заагийг тогтоосон бөгөөд УИХ-ын 2002 оны 38 дугаар тогтоолд “Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутагт 500 га газарт “Алтанбулаг” чөлөөт бүс байгуулахаар болж, ЗГ-ын 2014 оны 153 дугаар тогтоолоор “Алтанбулаг” чөлөөт бүс нь байнгын үйл ажиллагааны дэглэмд шилжүүлсэн.

Монгол улсад чөлөөт бүс байгуулах эрх зүйн орчин бүрдсэнээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, чөлөөт бүсийг хөгжүүлэх чиглэл, төлөвлөлтийг зохистой шийдэхтэй холбогдуулан Засгийн газар болон чиглэлийн яамны ажлын хүрээнд “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албыг бий болгох явдал байлаа.

Манай орны хувьд чөлөөт бүс гэдэг ойлголт цоо шинэ зүйл гэдэг утгаараа хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, чөлөөт бүсийг барьж байгуулах, үйл ажиллагааг нь эхлүүлэх, зохих хуулийг боловсронгуй болгох, холбогдох дүрэм журмыг нягтлан төгөлдөржүүлэхэд Захирагчийн ажлын албыг байгуулах нь нэн чухал байв.

Иймд Засгийн газрын 2002 оны 227 дугаар тогтоолоор “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны бүтцийг Тамгын газар, Бүртгэл, мэдээлэл, сурталчилгааны хэлтэс, Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтэс, Худалдаа, бизнес, хамтын ажиллагааны хэлтэс, төсөв, санхүүгийн хэлтэс, мэргэжлийн хяналтын алба, татварын тасагтай байхаар бүтэц орон тоог батлав.

Чөлөөт бүсийн тухай” хуулийг 2002 онд боловсруулж батлахад, чөлөөт бүсийн дэд бүтцийг улсын төсвийн хөрөнгөөр байгуулж худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт хөрөнгө оруулагчидтай гэрээ байгуулан менежментийг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба хэрэгжүүлэх үзэл баримтлалыг мөрдөж энэ хүрээнд чөлөөт бүсийн эрх зүйн орчинг бүрдүүлсэн юм.

Засгийн газрын 2003 оны 55 дугаар тогтоолоор "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсэд барих барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, мастер төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төслүүдийг боловсруулах ажлыг эрчимжүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авахаар болж “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн болон “Алтанбулаг” сумын Ерөнхий төлөвлөгөө, мастер төлөвлөгөөг боловсруулахаас ажлаа эхлүүлсэн юм.

Энэ ажлыг 2003 онд ”Мипс” ХХК, “Идеал групп” ХХК-ын түншлэл хамтран боловсруулж, Алтанбулаг сумын Ерөнхий төлөвлөгөөг Сэлэнгэ аймгийн ИТХ баталж, чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар дэмжүүлэн Үйлдвэр худалдааны яаманд хүлээлгэн өгсөн.

ЗГ-ын 2015 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 126 тоот тогтоолоор "Алтанбулаг", "Замын-үүд", "Цагааннуур" чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсан бөгөөд 2015 онд "Чөлөөт бүсийн тухай" хууль шинэчлэгдэн мөрдөгдөж байна.

“Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба нь Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Монгол Улсын үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн дагуу “Алтанбулаг” чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

ОХУ-Монгол Улс-БНХАУ-ын эдийн засгийн коридор, “Бүс ба Зам”төслийн хүрээнд Монгол улсын холбогдох яам, газрууд болон ОХУ-ын төлөөлөгчийн газар, Хиагт боомтын удирдлагуудтай “Алтанбулаг” чөлөөт бүсээс ОХУ-руу орох гарц нээх, чөлөөт бүсээр транзит тээврийг дайран өнгөрүүлэх, аялал жуулчлалын бүс, хамтарсан логистикийн төв байгуулах талаар хамтран ажиллаж, Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын 20, 21, 22 дугаар комиссын хуралдааны протоколд “Алтанбулаг” чөлөөт бүсийн талаарх саналуудыг тусгаж ирсэн.

Монгол Улсын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.17 дахь хэсэгт чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана гэж тусгасны дагуу Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор Алтанбулаг” чөлөөт бүс ажлын албаны конторын барилгыг төрийн өмчид бүртгэн зориулалтаар ашиглах, үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх зөвшөөрөл олгохыг төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт даалгасан байдаг.

Үүнтэй уялдуулан Монгол Удсын Засгийн газрын 2020 оны 105 дугаартай тогтоолоор “Чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зорчигчийн худалдан авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааны нэр төрлийн жагсаалт”-ыг баталсан юм.

Монгол Улс бол Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улсын дунд байрладаг хүн амын нягтрал хамгийн багатай улсуудын нэг.

Далайд гарцгүй, өргөн уудам (1.5 сая хавтгай дөрвөлжин километр) газар нутагтай улсын хувьд эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг бий болгоход бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа ба худалдаа чухал ач холбогдолтой.

Монгол Улсад тулгарч буй хөгжлийн сорилтууд дээр худалдаа эрхлэх зардал газарзүйн байршлаас улбаатайгаар өндөр байгаа нь асуудал болж байна.

Гадаад худалдаа эрхлэхэд зарцуулж буй мөнгөн болон цаг хугацаагаар хэмжигдэх зардлыг бууруулахын тулд бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах нь зүйтэй гэж үзсэн.

Манай улс нээлттэй, чөлөөт худалдааны бодлого хэрэгжүүлж, олон талт худалдааны тогтолцоог бэхжүүлэн, эдийн засгийг төрөлжүүлэх, худалдааг хөнгөвчлөх, экспортод

чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр идэвхтэй бодлого баримталж ирсэн бөгөөд цаашид хөрөнгө оруулалтын орчин, худалдааны бодлого зохицуулалтын ил тод байдлыг хангах, эдийн засаг дахь төрийн оролцоо мөн худалдаан дахь техникийн зохицуулалтыг сайжруулах, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага зайлшгүй байна.

Өнөөдөр, Монгол Улсад чөлөөт бүсийг хөгжүүлэх 3 төсөл хэрэгжиж байгаа ба чөлөөт бүс байгуулах эрхэм зорилго нь "Хөрөнгө оруулагчдад эрх зүй, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар бүс нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах"-д оршдог. Эдгээр чөлөөт бүсүүдийн нэг нь Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд байрлах "Алтанбулаг" чөлөөт бүс юм.

"Алтанбулаг" чөлөөт бүс нь ОХУ-ын Буриад Улсын хилийн боомт бүхий газар болох Хиагт хоттой хил залгаа оршдог. Энэ утгаараа тус чөлөөт бүс нь дэлхийн эдийн засгийн үйл ажиллагаанд чухал байр суурь эзлэх томоохон зах зээлийг холбосон газарзүйн таатай байрлалд оршдог, Евро Азийг холбосон хамгийн дөт зам болдог.

"Алтанбулаг" чөлөөт бүсийн нийт талбай нь 500 га бөгөөд аялал жуулчлал, худалдаа үйлчилгээ, олон улсын банк санхүү, төлбөрт таавар, бооцоот тоглоом, үйлдвэрлэл, хангамж агуулах, логистик чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад зориулан үйл ажиллагаа явуулахаар төлөвлөгдөж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 227 дугаар тогтоолоор "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны болон бүсэд ажиллах мэргэжлийн хяналтын албаны бүтэц, орон тоог баталж, үйл ажиллагааг нь эхлүүлэхээр болсон ба Үйлдвэр худалдааны яам (Одоогийн Эдийн засгийн хөгжлийн яам)-ны сайдын шийдвэрээр ерөнхий менежерийг томилж, ажлын алба нь 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан бөгөөд одоогоор 42 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газраас өгсөн үүргийн дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, аймгийн ИТХ-ын 2003 оны 67 дугаар тогтоолоор батлуулж, төлөвлөгөөнд 2003 онд чөлөөт бүсийн цэвэр усны нөөцийг тогтоох геологи хайгуулын ажлын даалгаврыг боловсруулах, усан хангамжийн ойрын ирээдүйн болон хэтийн төлөвийн дагуу газрын доорх усны эх үүсвэрийг хэрэглэгчдэд аль болох ойр зайд илрүүлэн тогтоох зэрэг асуудлууд тусгагдсан байдаг.

Дээрх төлөвлөгөөний хүрээнд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумаас зүүн урагш 5-7 км зайд орших "Улаан бургас" нэртэй газар 7 цооногт 812 тууш метр өрөмдлөгийн ажлыг хийж, энэ нь "Алтанбулаг" чөлөөт бүсийн болон Алтанбулаг сумын цэвэр усны хэрэгцээг бүрэн хангахаар болсон байна.

Мөн түүнчлэн аж ахуйн нэгжүүдийн дунд чөлөөт бүсийн хамгаалалтын хашаа, харуулын байрны эскиз зургийн уралдаан зарлан дүгнэж, гүйцэтгэгч байгууллагыг тендерээр сонгон шалгаруулсан бөгөөд 2004 оны 08 дугаар сараас эхлэн нийт 11.8 км урт бетон суурьтай төмөр хашаа, 10 харуулын байр барьж, 2005 онд ашиглалтад өгч, чөлөөт бүсийн хилийн цэсийн дотор байрлах зарим айл, аж ахуй нэгжүүдийн барилгыг Монгол Улсын газрын тухай хууль болон Засгийн газраас баталсан "Газрын улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах журам"-ын дагуу нүүлгэн шилжүүлж, нөхөн олговрыг олгох ажил хийгджээ.

2006 оноос эхлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудтай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж эхэлсэн бөгөөд 2014 оны 06 сард албан ёсоор нээлтээ хийж,

байнгын ажиллагааны дэглэмд шилжсэн байна. Хамгийн сүүлийн үеийн мэдээллээр “Алтанбулаг” чөлөөт бүсэд 173 аж ахуйн нэгжийн 6.1 тэрбум төгрөгийн хувийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар дараах бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн байна. Үүнд:

1. “Намир Инвест” ХХК нь 150 тонны даац бүхий авто түүний барилгын ажил;
2. “Өгөөмөр Баянбулаг” ХХК нь бетон зуурмагийн үйлдвэр;
3. “Норс барс” ХХК нь худалдаа үйлчилгээний төвийн барилга зэрэг болно.

Мөн БНХАУ-ын хөрөнгө оруулалттай компани “Урсгал зам” ХХК нь 8.3 сая долларын хөрөнгө оруулалтаар “Шинэ наймаачин хотхон” төслийг хэрэгжүүлэхээр болж байгаа бөгөөд ингэснээр 3 том худалдааны төв, хөргөлттэй агуулах зэрэг байгууламжууд баригдахаар төлөвлөгдөж байна.

Чөлөөт бүсийг амжилттай явуулахад тодорхой нөхцөл бүрдсэн байх шаардлагатай гэж үздэг байна. Үүнд:

-Дунджаас дээгүүр түвшний бизнесийн дэд бүтэц;
-Газар, оффис, талбай, бизнесийн үйлчилгээ, олон нийтийн үйлчилгээ;
-Ажиллах хүчний нөөц, түүхий эд материал, бусад баялаг ордог байх;
-Бизнесийн уян хатан зохицуулалттай байх;
-Гаалийн хяналт, шалгалтыг оновчтой зохион байгуулах;
-Хүнд суртал, зардал чирэгдэлгүй байх;
-Нэг цэгийн үйлчилгээтэй, хууль эрхзүйн орчин уян хатан байх зэрэг юм.

Чөлөөт бүсийг аль болох хамгийн бага зардалтайгаар бизнес эрхлэх боломжтой, тээврийн сүлжээ бүхий газар байгуулах нь онцгой ач холбогдолтой ба экспортод чиглэсэн байх нь чухал юм.

Чөлөөт бүсэд байгуулагдсан ихэнх үйлдвэрүүдийн үндсэн зорилго нь экспортын зах зээлд гарах явдал байдаг.

Гадаад хөрөнгө оруулагчдад инсентивийг санал болгодог ба хөрөнгө оруулагчдад хөнгөлөлт, урамшууллыг санал болгодог.

Монгол Улс нь Бүгд Найрамдах Алтай Улс, Бүгд Найрамдах Тува Улс, Бүгд Найрамдах Буриад Улс, Өвөр Байгалийн хязгаар зэрэг багтана.

**Монгол Улсын ОХУ-тай хиллэдэг боомтууд:**

1.Хилийн Цагааннуур авто замын боомт
2.Хилийн Боршоо авто замын боомт
3.Хилийн Тэс авто замын боомт
4.Хилийн Арцсуурь авто замын боомт
5.Хилийн Ханх авто замын боомт
6.Хилийн Ульхан авто замын боомт
7.Хилийн Эрээнцав авто замын боомт
8.Хилийн Эрээнцав төмөр замын боомт
9.Хилийн Алтанбулаг авто замын боомт
10.Хилийн Сүхбаатар төмөр замын боомт зэрэг юм. (Зураг 4)

**(Зураг 4) ОХУ-тай хиллэдэг хилийн боомтуудыг харуулсан бүдүүвч зураг**




-Олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны зориулалттай байнгын ажиллагаатай Сүхбаатар-Наушки, Алтанбулаг-Хиагт, Цагааннуур-Ташанта, Эрээнцав-Соловьевск, Боршоо-Хандгайт;

-Хоёр талын зорчигч, ачаа тээврийн зориулалттай байнгын ажиллагаатай Тэс-Шарсуурь, Арцсуурь-Цагаантолгой, Ханх-Монд, Бага-Илэнх-Айнек, Зэлтэр-Желтура, Агацын гол-Алтан, Ульхан-Дээд Ульхан, Эрээнцав-Соловьевск /төмөр зам/;

-Түр буюу улирлын ажиллагаатай Баянзүрх-Тарис, Шишгэд гол-Ушь Бэлдир, Хээгт-Санага, Хонгор овоо-Боций, Цагаан-Арал-Наушки, Хутаг-Өндөр-Киран, Хүдэр-Цагаанчулуутай, Тогтор-Өвөртогтор, Ямалхын гол-Новый Дурулгүй;

-Дамжин өнгөрөх Асгатын гол-Аспайт, Бөхмөрөн-Кызылхая, Харигийн гол-Мугур Аксы, Тээл-Хандгайт, Тээл-Торгалыг, Давст-Сарыг Холь, Тэс-Сарыг Холь гэсэн 7 бүгд 29 боомт байдгаас Булган, Завхан, Хэнтий аймаг тус бүрт 1, Баян-Өлгий аймагт 2, Хөвсгөлд 4, Дорнод аймагт 5, Сэлэнгэ аймагт 7, Увс аймагт 8 байрладаг.

**Алтанбулаг чөлөөт бүсийн тулгамдаж буй асуудал:**

Алтанбулаг чөлөөт бүс байнгын дэглэмд шилжин үйл ажиллагаа явуулж байгаа ч дэд бүтцийн асуудал бүрэн шийдэгдээгүй байгаа нь нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал болж байна.

Чөлөөт бүсийн хөгжлийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас дэд бүтцийн ажилд 2006 оноос 2022 он хүртэл нийт 26.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Гэсэн хэдий ч чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөлийн барилга угсралтын ажил, кабелийн телевиз, телефон утас, интернэтийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор холбооны шугам сүлжээг барих барилга угсралтын ажил, чөлөөт бүс болон Алтанбулаг сумын хэрэглээг хангахуйц хүчин чадалтай дулааны станц барих болон чөлөөт бүсийн дотор хатуу хучилттай авто зам тавих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

Эдгээр хүлээгдэж буй дэд бүтцийн төслүүдийг 2015 онд Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар концессын зүйлийн жагсаалтад оруулан баталсан бөгөөд 2016 онд бүрэн хийгдэж дуусгахаар төлөвлөсөн хэдий ч тодорхойгүй шалтгааны улмаас 4 жилийн хугацаагаар хойшлогдож, 2020 оноос дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан дахин хойшлогдсоор 2023 онд багтаан ашиглалтад өгөхөөр ажиллаж байна.

**“Алтанбулаг” чөлөөт бүсийн эрх зүйн орчин:**

**А) Монгол улсын хуулиуд)**

“Чөлөөт бүсийн тухай хууль”-ийг 2002 оны 06 дугаар сарын 22-ны өдөр баталсан бөгөөд энэ хуулийн зорилт нь чөлөөт бүс байгуулах, түүний хэлбэр, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гаалийн дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

-2002 оны 06 дугаар сарын 22-ний өдөр “Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрхзүйн байдлын тухай” хууль;

-2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их хурлын чуулганаар “Чөлөөт бүсийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга;.

-2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Чөлөөт бүсийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;

**Б) Монгол Улсын Их хурлын тогтоолууд:**

-1995 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалыг батлах тухай” 87 дугаар тогтоол,

-2002 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутагт 500 га газарт “Алтанбулаг“ худалдааны чөлөөт бүс байгуулах тухай 38 дугаар тогтоол;

-2003 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн хилийн заагийг өөрчлөн батлах тухай” 15 дугаар тогтоолыг тус тус баталсан.

**В) Монгол Улсын Засгийн газрын тогтоолууд:**

-1995 оны 12 дугаарсарын 04-ний өдрийн “Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай үзэл баримтлалыг батлах тухай” 87 дугаар тогтоолоор

-2002 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны цалингийн сан, бүтэц, орон тоо, чөлөөт бүсэд ажиллах мэргэжлийн хяналтын албаны бүтэц, орон тоог батлах тухай” 227 дугаар тогтоол;

-2003 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсэд барих барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, мастер төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төслүүдийг боловсруулах ажлыг эрчимжүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай” 55 дугаар тогтоол,

-2005 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 150 дугаар тогтоол,

-2006 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 169 дүгээр тогтоол,

-2008 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 32 дугаар тогтоол

-2009 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 43 дугаар тогтоол

-2009 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 37 дугаар тогтоол

-2014 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 153 дугаар тогтоол

-2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 34 дугаартай тогтоол.

-2015 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 126 дугаар тогтоол.

-2015 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 291 дүгээр тогтоол.

-2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 497 дугаар тогтоол.

-2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаартай тогтоол зэрэг болно.

**“Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас эрхлэн боловсруулж, батлуулсан дүрэм, журам, чөлөөт бүс байгуулах зорилгоор хийгдсэн бэлтгэл ажлууд:**

- “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн хөгжлийн Ерөнхий болон мастер төлөвлөгөө, Алтанбулаг сумыг хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөө зэргийг Засгийн газрын хуралдаанаар дэмжүүлж, Сэлэнгэ аймгийн ИТХ-аар батлуулсан;
- Худалдааны чөлөөт бүс болон Алтанбулаг сумын дэвсгэр зургийг 1:1000 масштабаар “Асме Мон” ХХК-д хийлгэсэн;
- Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн;
- Цэвэр усны эрэл хайгуулын ажил хийж, хоногт 6800 м.куб ашиглалтын нөөцтэй ундарга илрүүлсэн;
- Засгийн газрын 2005 оны 150 дугаар тогтоолоор худалдааны чөлөөт бүсийг дотоодын цэргийн гэрээт хамгаалалтад оруулж, зардлыг Сангийн Яам шийдвэрлүүлсэн;
- Үйлдвэр, худалдааны сайдын 2005 оны 48 дугаар тушаалаар “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсэд хөрөнгө оруулах үйл ажиллагааг “Чөлөөт бүсийн тухай” хуулийн хүрээнд “хэсэгчилсэн” хэлбэрээр гэрээний үндсэн дээр зохион байгуулахыг Захирагчийн ажлын албанд зөвшөөрч, үүний дагуу чөлөөт бүсэд хэсэгчлэн хөрөнгө оруулах 40 гаруй компаниас санал ирүүлсэн;
- Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн үзэл баримтлалыг Үйлдвэр, худалдааны сайдын зөвлөлийн 2006 оны дөрөвдүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн;
- Газрын төлбөрийг газар ашиглалтын ангиллаар ялгавартай тооцох илтгэлцүүрийн тоон утга болон 1 м.кв газрын төлбөрийн хэмжээг Ерөнхий менежерийн тушаалаар батлуулсан;
- Дэд бүтцийн байгууламжуудын болон үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний төслийг техникийн шаардлага, хүчин чадлын болон зардлын тооцоог боловсруулж дуусгасан зэрэг ажлуудыг гүйцэтгэж байсан байна.

Захирагчийн ажлын алба нь бүсэд баригдах дэд бүтцийн барилга байгууламжийн хүчин чадлын тооцоо, цэвэр, бохир, усны шугам сүлжээ, цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн тооцоо болон агуулахын аж ахуйд тавигдах шаардлага, стандарт, үйл ажиллагааны төслүүдийг боловсруулан, нээлттэй сонгон шалгаруулалт явуулах бэлтгэлийг хангасан.

2004 оны 05 дугаар сард чөлөөт бүсийг хөгжүүлж буй улс орнуудын туршлагад тулгуурлан бүсэд байгуулж хөгжүүлэх бизнесийн болон дэд бүтцийн объектуудын барьж байгуулах асуудлаар олон улсын нээлттэй тендер зарлан явуулсан бөгөөд гол агуулга нь объектуудыг өөрийн хөрөнгөөр барьж байгуулан, үйл ажиллагааг нь эрхлэх сонирхол бүхий гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад оршиж байсан. Бизнес, дэд бүтцийн төсөл бүрээр хөрөнгө оруулагч олох зорилгоор зарласан энэ тендер амжилтгүй

болсон гол шалтгаан нь томоохон хөрөнгө оруулагчид тус тусад нь зарласан төслүүдэд хөрөнгө оруулах сонирхол бага, менежментийг нь бие даан хэрэгжүүлэх сонирхолтой байсан явдал юм.

Дээрхи байдлыг харгалзан “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсэд олгосон 500 га газрыг бүхэлд нь хамруулан бүсийг барьж байгуулах, менежментийг нь эрхлэх стратегийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендер зарлаж, дүгнэх журмыг боловсруулан батлуулж тендерийг зарласан байдаг.

Тендерт 2 компани санал ирүүлсэн боловч урьдчилсан шалгуур үзүүлэлтийг хангасан компани гараагүй тул энэ ажил хэрэгжээгүй байна.

Монгол улсын Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн газрын нэг жилийн төлбөрийн дээд болон доод хязгаарыг батлуулсан нь, “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөний дагуу Чөлөөт бүсийн тухай хуулийн хүрээнд бизнесийн үйл ажиллагаагаа зохион байгуулах өргөн боломжийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, бизнесменүүдэд олгож байсан байна.

## §2.3.Цагааннуур эдийн засгийн чөлөөт бүсийн өнөөгийн байдал




Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 87 дугаар тогтоолоор "Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал"-ыг баталж, Монгол Улсын их хурлын 2005 оны 66 дугаар тогтоолоор "Цагааннуур" эдийн засгийн чөлөөт бүсийг олон улсын түвшинд хүрсэн жишиг чөлөөт бүс болгон өргөжүүлж, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалаар тэргүүлэгч эрчимтэй хөгжлийн төв болгохоос гадна баруун бүс нутгийн хөгжлийг хурдасгах, Монгол Улсын нийгэм эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор анх байгуулсан.

Дээрх хугацаанаас хойш 2003 онд Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль, мөн оны 12 дугаар сарын 18-ны өдөр "Цагааннуур худалдааны чөлөөт бүс байгуулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай" УИХ-ын 58 дугаар тогтоол, 2005 онд "Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн хилийн заагийг тогтоох болон бүсийг байгуулах тухай" 74 дүгээр тогтоолууд тус тус батлагдсан байна.

Улмаар 2008 онд 15.6 км урт, харуулын 5 шалган нэвтрүүлэх байртай чөлөөт бүсийн хамгаалалтын хашааг барьж, мастер төлөвлөгөө, байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ зэрэг ажлуудыг хийсэн.

2011 онд уславлтын систем бүхий ногоон байгууламж байгуулах, чөлөөт бүсийн хашаа дотор усан сан бүхий инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах, бүсийн хил, гаалийн шалган нэвтрүүлэх цогцолбор, худалдаа, тээвэр логистикийн талбай, байр байгууламжуудын зураг төсөл боловсруулах ажлуудыг гүйцэтгэжээ. Энэ хугацаанд нийтдээ 1,5 тэрбум орчим төгрөгийн бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн юм.

Цагааннуур чөлөөт бүс нь Монгол Улсын баруун хойд хэсэгт Улаанбаатар хотоос 1700, Баян-Өлгий аймгийн төвөөс 65, улсын хилээс 28 км-т байрладаг бөгөөд Евроазийг холбосон босоо тэнхлэгийн авто замын дагуу 708.4 га талбайд оршдог юм.

Тус чөлөөт бүс нь Монгол Улсын баруун бүс нутаг ОХУ-ын Алтайн хязгаар, БНХАУ-ын Шинжаан-Уйгарын Өөртөө Засах орон, Казакстан улсын зүүн бүс нутгийг хамаарах цэгт оршдогоороо эдийн засгийн чухал ач холбогдолтой ба зах нийлэн орших энэхүү бүс нутгуудад нийт 32 сая орчим иргэн оршин суудгаар бүс нутгийн зах зээл нь жилийн олон тэрбум доллароор хэмжигддэг онцлогтой.

Мөн Ази-Европыг холбосон авто замын дагуу оршдог тул БНХАУ-н баруун хойд бүсээс ОХУ-руу ачаа тээвэрлэлтийг хамгийн богино хугацаанд хямд өртгөөр тээвэрлэх үүрэг бүхий тээвэр логистикийн төв болох бүрэн боломжтой юм.

Цагааннуур чөлөөт бүс нь үйл ажиллагаагаа эхлүүлснээр баруун бүс нутгийн зах зээл, эдийн засгийн барааны эргэлтийг нэмэгдүүлэх, хямд чанартай бараа бүтээгдэхүүнээр төвөөс алсдагдсан аймаг, сумдыг хангах давуу талтай болно гэж үзэж байна.

Түүнчлэн үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлснээр чөлөөт бүсийн тухай хуулиар олгогдсон татварын газрын төлбөрийн, гадаад ажиллах хүчний гэх мэт олон хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэх бүрэн боломжтой юм.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 412 дугаар тогтоолоор “Цагааннуур” чөлөөт бүсийг байнгын үйл ажиллагаанд шилжүүлэх шийдвэр гарч, Монгол Улсын Засгийн газрын “Боомтын сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Цагааннуур чөлөөт бүсийг ийнхүү байнгын үйл ажиллагаанд шилжүүлжээ.

Төр засгийн зүгээс Цагааннуур чөлөөт бүсийг олон улсын түвшинд хүрсэн жишиг чөлөөт бүс болгон хөгжүүлэх, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын төв болгох замаар баруун бүсийн хөгжлийг хурдасгах, улс орны нийгэм, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэхийг зорьж, тус зорилгын хүрээнд чөлөөт бүсийг байнгын үйл ажиллагаатай болгон, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон инженерийн шугам сүлжээний зураг төсвийг боловсруулж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг 2024 оноос эхлүүлэхээр төлөвлөж байна.

Тухайн чөлөөт бүс болон Цагааннуур боомтыг Даян боомттой авто замаар холбох судалгааны ажлуудыг хийж, тухайн зам ашиглалтад орсон тохиолдолд БНХАУ, Монгол Улс, ОХУ-ууд хамгийн дөт замаар авто замаар холбогдох боломж бүрдэх юм.

Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэжээ. Үүнд:

-Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Боомтын сэргэлтийн хүрээнд “Цагааннуур” чөлөөт бүсийг 2023 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн зорчигч, ачаа тээврийн хэрэгслийг чөлөөт бүсэд нэвтрүүлэх байнгын ажиллагаанд шилжүүлэх.

- Үүнтэй холбогдуулан гааль, мэргэжлийн хяналт, дотоодын цэрэг зэрэг төрийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн албадын үйл ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг хангуулах.

-Цагааннуур тосгоноос чөлөөт бүс хүртэл шилэн кабелийн сүлжээ байгуулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сайд нар хариуцан гүйцэтгэх.

-Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй сэргээгдэх эрчим хүчний төсөлтэй холбогдуулан арга хэмжээ авч хэрэгжүүлэх Засгийн газрын тогтоол гаргах зэрэг асуудлыг шийдвэрлэсэн байна.

Энэхүү тогтоол хэрэгжсэнээр Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагчдад тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх, үйл ажиллагаа явуулахтай холбоотой үүссэн гомдлыг шийдвэрлэх, үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжийг бүрдүүлж, хөрөнгө оруулалт хийх чиглэлээр хамтран ажиллах боломж бүрдэнэ гэж үзжээ.

Цагааннуур чөлөөт бүсийг нээснээр Хятад, Орос, Казахстанаас орж ирэх импортын барааны нэр төрөл нэмэгдэж, хямд, чанартай бараа бүтээгдэхүүнээр баруун аймгийн иргэдийг хангах, чөлөөт бүсийг эдийн засгийн эргэлтэд оруулах, ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийн орлогыг өсгөх ач холбогдолтой. Мөн малын гаралтай түүхий эд боловсруулах, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүнийг Хятад, Орос, Казахстан улс,

цаашлаад Ойрхи Дорнодын улсуудад экспортлох боломжтой төдийгүй Зүүн Өмнөд Азийн орнуудыг дундад Ази, Зүүн Европын орнуудтай холбох, бараа бүтээгдэхүүний урсгал бий болгох бүрэн боломжтой гэж үздэг.

# ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХАМГААЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ

## §3.1.Монгол Улсын эдийн засгийн чөлөөт бүсийн хамгаалалт, аюулгүй байдлын асуудал

Монгол Улсын Их Хурлаас улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх, өндөр технологийг нутагшуулах, хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгох, эдийн засгийг төвлөрүүлэх зорилгоор 1995 онд “Эдийн засгийн чөлөөт бүсийн үзэл баримтлал”, 2002 онд “Чөлөөт бүсийн тухай хууль”, 2003 онд “Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн тухай хууль”-ийг тус тус баталснаар эдийн засгийн чөлөөт бүс байгуулах хууль эрх зүйн орчин бүрдсэн гэж үздэг.

УИХ-аас 2004 онд “Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” 17 дугаар тогтоолыг баталж, нутаг дэвсгэрийн хэмжээг 900 га байхаар тогтоон, хилийн заагийг тодорхойлсон юм.

Гэтэл хил дамнасан чөлөөт бүсийн асуудал манай улсын хувьд шинэ сэдэв бөгөөд 2014 оноос албан ёсоор яригдах болсон.

Учир нь 2014 онд БНХАУ-ын дарга Ши Жинь Пин Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр Монгол Улс, БНХАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах асуудлыг судлах тухай харилцан ойлголцлын санамж бичигт Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам БНХАУ-ын Худалдааны яамны төлөөлөгчид гарын үсэг зурсан билээ. Энэ нь эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах талаарх албан ёсны анхны санаачилга юм.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч БНХАУ-д 2015 оны 11 дүгээр сард төрийн айлчлал хийх үеэр Монгол Улсын Аж үйлдвэрийн яам, БНХАУ-ын худалдааны яам хооронд хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар санамж бичиг байгуулсан.

Уг санамж бичгийн долоодугаар зүйлд “Замын-Үүд болон Эрээний боомтод хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах талаар хамтран судалж, хамтын ажиллагааны зарчмыг тодорхойлно.

Талууд хил дамнасан хамтын ажиллагааны бүс байгуулах урьдчилсан ТЭЗҮ хийх эрсдэлийн үнэлгээ ба менежментийн судалгааг хийх чиглэлээр хамтран ажиллана” гэж[7] заасан.

Энэ хүрээнд Замын-Үүд болон Эрээний боомтод хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах асуудлыг судлах ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 216 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд хөрөнгө санхүүгийн асуудлыг БНХАУ-ын тал бүрэн хариуцахаар болж, хоёр талаас нэмж 474 га газрыг нэмснээр хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг бүрдүүлэхээр заасан байдаг.

Гэтэл хоёр улсын Засгийн газрын 2019 оны хэлэлцээрт “Хамтын ажиллагааны бүсийг хооронд нь хил дамнасан байгууламжаар холбох бөгөөд улсын хилийн шугамын явалтыг тодорхой байлгах зорилгоор улсын хилийг огтлон гарах цэгийн байршлыг талуудын эрх

[7] “Стратегийн судалгаа” Стратеги судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг сэтгүүл. №84. Уб., 2022 он. 104 дэх тал.

бүхий байгууллага харилцан хэлэлцэн тохиролцож, газар дээр нь тогтоон протокол үйлдэж, дипломат шугамаар харилцан баталгаажуулна. Аль нэг тал хилийн шугам дээр дангаараа тэмдэглэгээ хийхийг хориглоно. Талууд хамтын ажиллагааны бүсийн монгол, хятадын хэсгийг холбох хил дамнасан байгууламжийн асуудлаар харилцан хэлэлцэж, тохиролцоно” гэж[8], заажээ.

Дээрх тодорхойлолтыг харахад Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 216 дугаар захирамжид тусгагдсан “Хоёр талаас 474 га газрыг нэмэх” гэсэн хэсэг хоёр улсын Засгийн газрын хэлэлцээрээр өөрчлөгдөж, эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн монголын талын хэсэг нь Монгол Улсын Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт орших Замын-Үүд чөлөөт бүсийн 900 га газар, хятадын талын хэсэг нь БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө Засах Орны Эрээн хотын нутаг дэвсгэрт байрлах 903 га газар байх бөгөөд газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр инженерийн байгууламжаар холбохоор хоёр улсын хэлэлцээрт тусгасан байдаг.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2022 оны 05 дугаар сард чөлөөт бүсийн одоогийн хүчин төгөлдөр хууль, эрх зүйн орчныг сайжруулах, цаашдын хөгжлийн чиглэлийг тодорхойлоход оролцогч талуудын саналыг тусгах зорилгоор “Чөлөөт бүсийн хөгжлийн бодлого” хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гаргасан саналыг Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгаснаар цаашид хилийн зурвас, бүс дэх худалдааны чөлөөт бүсүүдийн үйл ажиллагаа эрчимжих хандлагатай байна.

**Эдийн засгийн чөлөөт бүсийн аюулгүй байдлыг хангахад мөрдөж буй эрх зүйн орчин:**

Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 87 дугаар тогтоолоор “Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал”-ыг баталж, Монгол Улсын их хурлын 2002 оны 38 дугаар тогтоолоор “Алтанбулаг”, 2004 оны 17 дугаар тогтоолоор “Замын-Үүд”, 2005 оны 66 дугаар тогтоолоор “Цагааннуур” эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах шийдвэр гарч, “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн харуул, хамгаалалтыг Хил хамгаалах байгууллага, “Алтанбулаг” “Цагааннуур” эдийн засгийн чөлөөт бүсийн харуул, хамгаалалтыг Цагдаагийн байгууллага тус тус хариуцахаар эрх зүйн зохицуулалт хийсэн.

Монгол Улсын чөлөөт бүсийн тухай хууль 2015 онд батлагдаж, уг хуулийн шинэчилсэн найруулгын наймдугаар бүлгийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт “хилийн зурвас дахь чөлөөт бүсийн харуул, хамгаалалтын үүргийг хил хамгаалах байгууллага, бусад чөлөөт бүсийн харуул, хамгаалалтын үүргийг холбогдох байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр тус тус гүйцэтгэнэ” гэж[9], Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 497 дугаар тогтоолд “Алтанбулаг”, “Замын-Үүд”-ийн чөлөөт бүсүүдийн харуул, хамгаалалтын үүргийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Хил хамгаалах байгууллагаар гүйцэтгүүлэх” хэмээн[10] тус тус заасан байна.

[8] “Замын-Үүд, Эрээний хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай” Монгол Улсын Засгийн газар БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2019 оны хэлэлцээрийн хоёр дугаар бүлгийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг.
[9] Монгол Улсын хилийн тухай хууль. Уб., 2016 он.
[10] Монгол Улсын Засгийн газрын тогтоол. Уб., 2014 он.

Тус тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Цагдаагийн байгууллагын хамгаалалтад байх онц чухал обьектын жагсаалт”-ын “Цагдаагийн гэрээт хамгаалалтад байх обьектын жагсаалт”-аас “Алтанбулаг” эдийн засгийн чөлөөт бүс, “Цагааннуур” эдийн засгийн чөлөөт бүс гэсэн хэсгийг хасах талаар тогтоолд дурдсан тул хилийн зурвас дахь чөлөөт бүсийн хамгаалалтын асуудлыг 2016 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн Цагдаагийн байгууллагын “Объект хамгаалах тасаг”-аас Хил хамгаалах байгууллагад шилжүүлсэн.

Хил хамгаалах байгууллага хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж, хилийн зурвас дахь эдийн засгийн чөлөөт бүсийн хамгаалалт, аюулгүй байдлын асуудлыг хариуцан ажиллаж байгаа хэдий ч тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад хилийн болон чөлөөт бүсийн орчинд гарч болзошгүй хууль бус үйлдлийг шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн зохицуулалт байхгүй гэхэд болохоор байна.

Иймд Хил хамгаалах байгууллага болон чөлөөт бүс бүхий хилийн цэргийн анги, салбаруудын чиг үүргийг зөвхөн улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх боомтын үйл ажиллагаа руу төвлөрүүлэх биш чөлөөт бүсийн аюулгүй байдал, хамгаалалт руу хандуулан, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх замаар чөлөөт бүсийн захиргаа, тагнуул, цагдаа болон бусад харилцан ажиллагаатай байгууллагуудын уялдаа холбоог сайжруулахад чиглэсэн эрх зүйн орчинг бүрдүүлэх, холбогдох дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж батлуулах, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль дүрэм, журам, гэрээ хэлэлцээрүүдэд чөлөөт бүсийн аюулгүй байдлыг хангах асуудлын талаар тусгуулах санал боловсруулж, шийдвэрлүүлэх зэрэг асуудлыг цогцоор нь авч хэрэгжүүлэх нь нэн чухал юм.

**Эдийн засгийн чөлөөт бүсийн хамгаалалт, хөгжлийн чиг хандлага**



“Алтанбулаг” эдийн засгийн чөлөөт бүс нь 500 га талбайг хамарсан 11.8, “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс 900 га талбайг хамарсан 13.6 км урттай бетонон суурьтай төмөр сараалжин хашаагаар тохөөрөмжлөгдсөн бөгөөд “Алтанбулаг”-ийн чөлөөт бүсэд шалган нэвтрүүлэх 1 байр, харуулын 10 цэг, “Замын-Үүд”-ийн чөлөөт бүсэд шалган нэвтрүүлэх 1 байр, харуулын 5 цэгтэйгээр анх байгуулагдсан.

Чөлөөт бүсийн харуул, хамгаалалтын үүргийг 2016 онд Хил хамгаалах байгууллагад шилжүүлснээр “Замын-Үүд”-ийн чөлөөт бүсийн хамгаалалтыг Хилийн цэргийн 0108 дугаар ангийн шалган нэвтрүүлэх бэлтгэл заставын, “Алтанбулаг”-ийн чөлөөт бүсийн хамгаалалтыг Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн Бүргэдэй-Уулын хилийн заставын хүч хэрэгслээр тус тус зохион байгуулж ирсэн бөгөөд “Алтанбулаг”-ийн чөлөөт бүсэд хоногт 1 ахлагч, 3 гэрээт хилчин, “Замын-Үүд”-ийн чөлөөт бүсэд 1 ахлагч, 2 гэрээт хилчнийг тус тус томилон үүрэг гүйцэтгүүлэх замаар хамгаалалтыг зохион байгуулж ирсэн.

“Алтанбулаг”-ийн чөлөөт бүс нь улсын хилийн шугамаас 25, “Замын-Үүд”-ийн чөлөөт бүс нь 850 метрт тус тус байрладаг бөгөөд “Алтанбулаг”-ийн чөлөөт бүсэд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 28-30 аж ахуйн нэгж архи, тамхи, хүнсний бараа бүтээгдэхүүн худалдаалах, “Замын-Үүд”-ийн чөлөөт бүсэд 7 аж ахуйн нэгж дээрх нэр төрлийн бараа бүтээгдэхүүн худалдаалахаас гадна сав, баглаа, боодлын үйлдвэрлэл, авто машины худалдаа эрхлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

“Замын-Үүд” худалдааны чөлөөт бүсэд харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай инженер-техникийн хэрэгслүүдийг суурилуулах, дохиололт-хяналт, хамгаалалтын удирдлагын төвийн байрыг шинээр барих зэрэг бүтээн байгуулалт, дэд бүтцийн ажлууд хийгдэж, 2022 оны 08 дугаар сарын 14-ний өдөр хүлээлгэн өгсөн бөгөөд тухайн худалдааны чөлөөт бүсийг хил дамнасан болгож өргөжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх асуудал БНХАУ-ын талтай хэлэлцээрийн шатанд явагдаж байна.

Цаашид Монгол Улсын Засгийн газраас “Цагааннуур”, “Алтанбулаг” эдийн засгийн чөлөөт бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодит арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа нь чөлөөт бүс рүү нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдэж, Хил хамгаалах байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хил орчмын дэглэм сахиулах, чөлөөт бүсийн харуул, хамгаалалтын үүргийг гүйцэтгэх хүч хэрэгслийн боломж, техник технологийн дэвшил, инженерийн байгууламжийн чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа.

Зураг оруулах

“Цагааннуур”-ын чөлөөт бүс БНХАУ-ын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Бүс ба зам” санаачилгын хүрээнд БНХАУ, ОХУ-ыг холбосон эдийн засгийн коридор болон өргөжих чиг хандлагатай байгаа нь Ази, Европын улс орнуудын эдийн засгийн гарц болох магадлал өндөр байна.

Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Цагааннуур тосгоны төвд буюу улсын хилээс 35 км-т хилийн бүсэд байрлах “Цагааннуур” эдийн засгийн чөлөөт бүсийн харуул, хамгаалалт, аюулгүй байдлын асуудлыг чөлөөт бүсийн тухай хуулийн 25.2 дахь хэсэгт **“Бусад чөлөөт бүсийн харуул, хамгаалалтын үүргийг холбогдох байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр тус тус гүйцэтгэнэ”** гэж заасны дагуу Хил хамгаалах байгууллагын гүйцэтгэх үүрэгт хамаарахгүй гэж үзсэн.

Хил хамгаалах байгууллагаас “Алтанбулаг” чөлөөт бүсийн харуул, хамгаалалтын бодлогыг боловсруулах зорилгоор 2018 онд Сэлэнгэ аймгийн Гааль, Хилийн мэргэжлийн хяналт, Чөлөөт бүсийн захиргаатай хамтарсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээр Монгол Улсын чөлөөт бүсийн тухай хуулийн дагуу Хил хамгаалах байгууллага “Алтанбулаг” чөлөөт бүсийн харуул, хамгаалалтыг зохион байгуулах асуудлыг хэлэлцсэн.

Монгол Улсын чөлөөт бүсийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 25.2 дахь хэсэгт заасны дагуу чөлөөт бүс рүү орох, гарах иргэд, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, чөлөөт бүсэд тогтоосон дэг журмыг сахиулах, аливаа хууль бус үйлдлээс урьдчилан

сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хилийн “Алтанбулаг” чөлөөт бүсийн харуул, хамгаалалтыг зохион байгуулах журмыг баталсан.

Тус журамд чөлөөт бүсийн харуул, хамгаалалтыг хилийн дугаар ангийн “Хилийн боомт, чөлөөт бүсийн хамгаалалтын застав”-ын хүч хэрэгслээр зохион байгуулахаар тусгасан ба харуул, хамгаалалттай холбогдолтой дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр болсон.

“Алтанбулаг” чөлөөт бүс нь 500 га талбай бүхий 11.8 км урт хашаатай бөгөөд урд талаар нь Алтанбулаг сумын захиргаанаас иргэдэд газрыг хашаанд нь тулгаж олгосон, баруун урд талаар ус зайлуулах хоолойг хашаатай нь тулгаж барьсан, зүүн хойд талд нь оршуулгын газар байрлаж, энэ нь хашааны гадна талаар “Дохиолол-хяналт-хамгаалалтын нэгдсэн систем”-ийг байгуулж, манаа томилж үүрэг гүйцэтгүүлэх боломжгүй байсан тул хашаанаас дотогш 6 метрийн өргөн зурвас газарт “Дохиолол-хяналт-хамгаалалтын нэгдсэн систем”-ийг байгуулж, хашааны дотор талаар манаа томилон үүрэг гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн.

Гэсэн хэдий ч хөрөнгө санхүүгийн асуудлаас үүдэн чөлөөт бүсийн хашааг “Дохиолол-хяналт-хамгаалалтын нэгдсэн систем”-ээр төхөөрөмжлөөгүй, хашааны чанар байдал нь муудан нурж унасан зэргээс шалтгаалан, “Алтанбулаг” чөлөөт бүсийн хашааг давж, улсын хил зөрчсөн, чөлөөт бүсийн хашаан дахь аж ахуйн нэгжүүдийн агуулахаас иргэд их хэмжээний архи хулгайлж, дотоодын зах зээлд нийлүүлсэн зэрэг зөрчлүүд гарч байсан. Үүнд:

1. Бүргэдэй-Уулын заставын хариуцсан хэсэг хилийн 654 дүгээр тэмдгийн чиглэлээр 2020 оны 08 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын 1 иргэн согтуугаар чөлөөт бүсийн хашаа давж, улсын хил зөрчсөн үйлдлийг илрүүлж, хуулийн дагуу шийдвэрлэсэн;
2. “Алтанбулаг” чөлөөт бүсийн хашаанаас 2022 оны 03 дугаар сард 2 удаагийн, 07 дугаар сард 1 удаагийн үйлдлээр их хэмжээний архи согтууруулах ундааны зүйл хулгайлсан зөрил гарсныг илрүүлж, хэргийг Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн зэрэг жишээнүүдийг дурдаж болно.

Үүнээс гадна “Алтанбулаг” чөлөөт бүсэд импортын архи согтууруулах ундааны зүйлийг худалдан борлуулж эхэлсэн 2020-2022 онуудад чөлөөт бүс рүү нэвтрэх иргэд, тээврийн хэрэгслийн тоо эрс нэмэгдэж, үргэлжилсэн дараалал үүссэнээс иргэд, алба хаагчдын дунд үл ойлголцол бий болж улмаар хилийн зурваст эмх замбараагүй байдал үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болж байсан.

Иймд эдийн засгийн чөлөөт бүсийн хамгаалалт, аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээг Хил хамгаалах байгууллага, Чөлөөт бүсийн захиргаатай хамтран хэрэгжүүлж, шаардлагатай техник хэрэгслийг нэвтрүүлэх, инженерийн байгууламж байгуулах, тэнд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын амьдрах орчин, ахуй нөхцөлийг сайжруулах шаардлага бий болж байна.

Гэтэл гадаадын зарим улс орнуудад тэр тусмаа БНХАУ, Казакстан улсуудын хил дамнан байрлах “Хоргос” хуурай замын эдийн засгийн чөлөөт бүсийн хувьд харуул, хамгаалалт, аюулгүй байдлын асуудлыг БНХАУ-ын талаас Ардын чөлөөлөх армийн хил, далайн хамгаалалт хариуцсан байгууллага, Казакстан улсын талаас Хил хамгаалах

байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хариуцдаг бөгөөд хамгалалт, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай техник технологи, инженерийн байгууламжийн зардлыг тухайн Чөлөөт бүсийн захиргаа хариуцдаг байна.

**Чөлөөт бүсийн хөгжил ба хилийн аюулгүй байдал:**

Өнгөрсөн хугацаанд чөлөөт бүсийн хөгжлийн асуудал царцанги байдалтай байсан хэдий ч Монгол Улсын Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогод эдийн засгийн үр өгөөж бүхий зарим хилийн боомтуудын дахин төлөвлөлтийг гүйцэтгэх, чөлөөт бүсийн хөгжлийг сайжруулах замаар олон талт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тусгасан нь ажил хэрэг болж, цаашид энэ чиглэлийн томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг Засгийн газрын санхүүжилтээр хийж гүйцэтгэхээр шийдвэрлэсэн. Энэхүү бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж, эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагаа эрчимжих нь улс орны эдийн засаг, ард иргэдийн амьжиргаанд эергээр нөлөөлөх сайн талтай боловч хилийн аюулгүй байдал цаашлаад хил орчмын суурингуудад ажиллаж амьдардаг иргэдийн аюулгүй байдлын асуудал зайлшгүй хөндөгдөж байна.

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогод ***“хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдоно”*** гэж[11], Монгол Улсын хилийн тухай хуульд ***“хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг”*** мөн бөгөөд ***“хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ”*** гэж[12] хуульчилсан байна.

Дээрх тодорхойлолтыг нэгтгэн дүгнэвэл: Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогод зөвхөн хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдсон бол Монгол Улсын хилийн тухай хуульд хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт баталгаатай хангагдсаныг хэлнэ гэсэн байна.

Хилийн аюулгүй байдлын үндсэн үүрэг бол газар нутгийн бүрэн бүтэн байдал, улс орны тусгаар тогтнолыг хангах, улсын хил, хязгаар нутагт сайн хөршийн харилцаа, энх тайвнаар зэрэгцэн оршиход чиглэсэн, хилийн зөрчилгүй байлгах олон улсын зарчим, бусад улс хоорондын эрх зүйн хэм хэмжээг зохион байгуулах, улсын хилийн шугамын явалтыг хууль бусаар өөрчлүүлэхгүй байх, хилийн дэглэм, журмыг хувь хүмүүс, хуулийн этгээдүүдээр сахиулах явдал юм.

Хилийн зурвас, бүс дэх эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжил нь хилийн аюулгүй байдалд дараах байдлаар нөлөөлж болзошгүй гэж үзэж байна.

Хилийн аюулгүй байдлын обьект, субьект, тэдний орон зайн цар хүрээг тодорхойлсон тодорхойлолтод төрийн захиргааны төв байгууллагууд, орон нутгийн засаг захиргааны нэгжүүд, ард иргэд нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хилийн аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт оролцох эрх, үүргийг хүлээсэн байдаг.

---

[11] Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. Уб., 2002 он.
[12] Монгол Улсын хилийн тухай хууль. Уб., 2016 он.

Үүнээс үзэхэд чөлөөт бүсийн хөгжил түүнийг дагаж эрчимжих худалдааны болон үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа цаашид улам өргөжиж, хил орчмын нутаг дэвсгэрт байрлах аймаг, сум, суурингууд руу чиглэсэн хөдөлгөөний урсгал, хүн амын нягтаршил нэмэгдэн, тухайн чиглэлийн улсын хил хамгаалалт, хилийн дэглэм сахиулах арга хэмжээ, хилийн аюулгүй байдлыг хангах асуудлууд цаг үеийн нөхцөл байдалтай уялдан хувьсан өөрчлөгдөх болно гэж үзэж байна.

Эдийн засгийн хувьсал, нийгмийн харилцаа, хүн амын өсөлт, аж үйлдвэржүүлэлт, тээвэр логистик, цахим хөгжил, уул уурхай, үйлдвэрлэл худалдаа зэрэг олон хүчин зүйлүүдээс шалтгаалан түүнийг дагасан аюулгүй байдлын асуудлууд хөндөгддөг байна.

Үүний нэгэн адил хилийн зурвас дахь эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагаа эрчимжиж, хөгжин дэвших нь хилийн аюулгүй байдал, цаашлаад улс орны оршин тогтнохын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм.

## §3.2.Монгол Улсын чөлөөт бүсийн хөгжилд тулгамдсан зарим асуудал

Монгол Улсын Их Хурал "Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай[13] үзэл баримтлалыг 1995 онд баталж, чөлөөт бүс байгуулах үндэслэл, шаардлага, онцлог зарчим, угтвар нөхцөл, баримтлах шалгуур үзүүлэлтийг тодорхойлон өдгөө хүртэл гурван чөлөөт бүс байгуулахаар хууль батлан тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг хийсэн боловч бодит байдал дээр чөлөөт бүсийг жинхэнэ утгаар нь байгуулж чадаагүй гэдэг нь цаг хугацааны явцад харагдаж байна.

Чөлөөт бүсийг газар зүйн хувьд оновчтой байршилд байгуулан, гадаад худалдааны эргэлтийг сайжруулах, экспортыг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар тухайн улс эдийн засгийн олон талын үр ашгийг хүртдэг ч манай улсын хувьд чөлөөт бүсийн хөгжлийн асуудал байж болох хамгийн доод түвшиндээ хүрээд байгаа нь  харамсалтай.

Хөгжлийн суурь нь тавигдаагүй нурж унасан хашаа төдий байгаа энэ нөхцөлд чөлөөт бүсийн аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэх талаар ярих нь төдийлөн оновчтой биш ч Монгол Улсын Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогод чөлөөт бүсийг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар тусгагдсан нь хонгилын үзүүрт гэрэл харагдахтай төстэй сонсогдож, энэ сэдвийг сонгон судлах шалтгаан болсон гэж үзэж болно.

Судалгааны явцад ажиглахад чөлөөт бүсийг амжилтай хөгжүүлж чадсан улсуудын ихэнх нь далайн боомт болон бусад улстай хил залгаа эдийн засгийн ач холбогдол бүхий цэгийг сонгон байгуулсан байхад манай улс зөвхөн өөрийн талын нутаг дэвсгэрт 1990-ээд оноос хойно явагддаг байсан нэг талын яармаг худалдааны хашаатай төстэй зүйлийг эдийн засгийн чөлөөт бүс хэмээн нэрлэж, байгуулсан нь эдийн засгийн бус өөр ашиг сонирхол байсан байна гэж ойлгож болохоор байна.

Нөгөө талаас нь харвал Монгол Улсын хувьд газар зүйн байрлалын хувьд хоёр улстай хиллэдэг, далайд гарцгүй зэрэг онцлогоо харгалзан, Оросын Холбооны улстай хиллэдэг Алтанбулаг болон Цагааннуур боомт, Бүгд Найрамдах Хятад Ард улстай хиллэдэг Замын-Үүд боомтод тулгуурлан, энэхүү чөлөөт бүсийг байгуулсан байж ч болох юм. Гэтэл дээрх бүсүүдийн аль аль нь хөгжилгүй 20 гаран жил болсон нь ямар нэгэн алдаатай бодлого байсныг харуулж байна гэж үзэхэд хүргэсэн.

Чөлөөт бүсийн үйл ажиллагааг амжилтай, ашигтай явуулахад төрийн бодлого, орон нутгийн оролцоо, бизнес эрхлэгч буюу хөрөнгө оруулагчийн дэмжлэг маш чухал тулгуур хүчин зүйл болдог бөгөөд өнөөг хүртэл хөгжүүлэхээр зорьсон чөлөөт бүс нь 20 гаруй жилийн туршид ахиц гараагүй шалтгааныг судлаачид олон талаас нь харж, бичсээр байна.

Хувь судлаачийн хувьд миний харж дүгнэж буйгаар тухайн үед шийдвэр гаргасан төрийн өндөр албан тушаалтнууд чөлөөт бүсийг хууль бус үйл ажиллагаа чөлөөтэй явуулдаг талбар болгон ашиглах сонирхолтой байсан байж ч болох юм.

Гэтэл Монгол Улс нь "Дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна, төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна" гэж[14] заасны дагуу чөлөөт бүсийн

[13] Монгол Улсын Их Хурлын 87 дугаар тогтоол. Уб., 1995 он.
[14] Монгол Улсын Үндсэн хууль Уб., 1992 он.

тухай хуулийг батлан байгуулах зорилго, хэрэгцээ, шаардлагыг нь тухайн бүсэд эрх зүй, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлснээр иргэн, аж ахуйн нэгжийн экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, худалдаа, үйлчилгээний шинэ салбар, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг татах, транзит тээвэр, логистикийг нэмэгдүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилготой байгуулсан гэж томьёолоод байгааг өнгөрсөн 20 жилтэй нь харьцуулахаар үнэмшилтэй биш сонсогдоно.

Нийтлэг байдлаараа улсуудын чөлөөт бүсийг байгуулах зорилго нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах, үндэсний үйлдвэрлэгчид бизнесийн таатай орчин бүрдүүлэх, экспортоос орлого олох, технологи дамжуулах, бүс нутгийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн хөгжлөө хурдасгахаар байгуулж байна.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Ази, Номхон далайн орнуудын эдийн засаг, нийгмийн комиссоос хийсэн судалгаагаар улсуудын засгийн газрын чөлөөт бүс байгуулах үндсэн шалтгаан нь нэгдүгээрт хөрөнгө оруулалтыг татах, хоёрдугаарт ажлын байр нэмэгдүүлэх, гуравдугаарт орлого олох бол чөлөөт бүсэд бизнес эрхлэгчдийн хувьд шийдвэр гаргахдаа анхаардаг гурван гол хүчин зүйлийн нэгд байршил, хоёрт байршил, гуравт байршил гэсэн дүрмийг баримталдаг болох нь тогтоогдсон байна.

Тиймээс бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулах эсэхээ шийдвэрлэхэд зөвхөн байршлаас шалтгаалж хөрөнгө оруулалт хийх, бизнес эрхлэх эсэхээ шийдвэрлэдэг нь харагдаж байгаа бөгөөд чөлөөт бүсийг улсууд олон хэлбэрээр байгуулан ажиллаж байгаа бөгөөд сүүлийн үед аль болох төрийн оролцоог багасгах, үр ашигтай байдал, бүтээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн бие даасан хараат бус байдлыг нь бүрдүүлэх зорилгоор төрийн мэдлээс хувьд шилжүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.

Чөлөөт бүсийг хамтын ажиллагааны түвшин, өмчийн хэлбэр, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлээр нь олон хэлбэрээр ангилан үздэг.

Хамтын ажиллагааны түвшнээр нь гадаад зах зээлд чиглэсэн, үндэсний зах зээлд чиглэсэн, өмчийн хэлбэрээр нь улсын, хувийн, холимог, үйл ажиллагааны чиглэлээр нь худалдааны, үйлдвэрлэлийн, технологийн, үйлчилгээний, цогцолбор, зохион байгуулалтаар нь нутаг дэвсгэрийн болон үйл ажиллагааны гэж ангилдаг.

Нутаг дэвсгэрийн нь тухайн газар үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгж үйл ажиллагааны хөнгөлөлтэй журмыг ашигладаг. Тухайлбал, Цагааннуур чөлөөт бүс, Замын Үүд чөлөөт бүс, Алтанбулаг чөлөөт бүс юм. “Үйл ажиллагааны гэдэг нь холбогдох аж ахуй нэгж эх орныхоо хаана байгаагаас үл хамааран худалдаа, үйлдвэрлэлийн үйл ажиллагааныхаа тодорхой төрөлд хөнгөлөлтэй журам хэрэглэхийг хэлнэ”[15] хэмээн тодорхойлжээ.

Орчин үед чөлөөт бүсийн төрөл нэмэгдэж аялал жуулчлал, хөдөө аж ахуй, ложистик, мэдээллийн технологийн чиглэлээр бүс байгуулах болсон байна. Монгол Улсад үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, олон улсын банк, санхүү, төлбөрт таавар, бооцоот тоглоом зэрэг бүх төрлийн үйл ажиллагаа явуулж болохоор хуульчилсан.

[15] 7 Отгонсайхан, Н. “Олон улсын бизнес” Уб., 2009 он.

Монгол Улс 1995 онд “Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай үзэл баримтлалыг Улсын Их Хурлын 1995 оны 87 дугаар тогтоолоор баталж улмаар 2002 онд Чөлөөт бүсийн тухай хууль, 2002 онд “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай, 2003 онд “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрхзүйн байдлын тухай, “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиуд баталсан боловч 2015 онд Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлагдсанаар тус тусдаа байсан чөлөөт бүсийн хуулиудыг хүчингүй болгосон.

Мөн чөлөөт бүсийн тухай хуулиас гадна гаалийн тухай хууль, гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай Киотогийн конвенцын зарим холбогдох заалт, Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/43 дугаар тушаалаар батлагдсан “Чөлөөт бүсийн горимыг хэрэгжүүлэх журам” зэрэг хэм хэмжээгээр чөлөөт бүстэй холбогдох харилцааг зохицуулж байна.

Чөлөөт бүсийг амжилттай явуулахад тодорхой нөхцөл бүрдсэн байх шаардлагатай гэж үздэг. Үүнд:

-Дунджаас дээгүүр түвшний бизнесийн дэд бүтэц: Газар, оффис, талбай, бизнесийн үйлчилгээ, олон нийтийн үйлчилгээ, ажиллах хүчний нөөц, түүхий эд, материал бусад баялаг;

-Бизнесийн уян хатан зохицуулалт: Гаалийн хяналт, шалгалтыг оновчтой зохион байгуулах, хүнд суртал, зардал чирэгдэлгүй байх, нэг цэгийн үйлчилгээтэй, хууль эрхзүйн орчин уян хатан байх;

-Оффшор байрлал: Чөлөөт бүсийг аль болох хамгийн бага зардалтайгаар бизнес эрхлэх боломжтой, тээврийн сүлжээ бүхий газар байгуулах нь онцгой ач холбогдолтой байх;

-Экспортод чиглэсэн байх: Чөлөөт бүсэд байгуулагдсан ихэнх үйлдвэрүүдийн үндсэн зорилго нь экспортын зах зээлд гарах боломжтой байх;

-Гадаад хөрөнгө оруулагчдад инсентивийг санал болгох: Хөрөнгө оруулагчдад хөнгөлөлт, урамшууллын таатай нөхцөлийг санал болгодог байх зэрэг болно.

Чөлөөт бүсийг байгуулснаар экспортын үйлдвэрлэлийг урамшуулсны үндсэн дээр валютын эх үүсвэртэй болох, ажлын байр нэмэгдэх, үндэсний аж ахуйн өсөлтийг нэмэгдүүлэх, гааль, татвар, хөрөнгө оруулалтын тогтолцоо нь гадаад ба дотоодын хөрөнгө оруулагчдад хамгийн тааламжтай нөхцөлийг бий болгодог гэж үздэг байна.

Мөн тухайн бүсэд ажлын байр нэмэгдэж, амьжиргааны түвшин дээшлэх, гадаад шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх зэрэг эерэг үр дагаврууд илэрдэг бол Засгийн оролцоо шаарддагаас үүдэж улс төрийн нөлөө орох, төрийн бодлого тогтворгүйгээс үүдэж хөрөнгө оруулагч буурах, эхний жилүүдэд бизнесийн таатай орчин бүрдэж орлого орох нь тодорхойгүй байх зэрэг эрсдэлүүд тулгардаг.

Улс бүр өөрийн нөөц боломж, онцлог дээрээ тулгуурлан чөлөөт бүсийн төрлөө сонгодог бөгөөд чөлөөт бүсийг байгуулснаар нэн тэргүүнд тухайн бүсэд бизнес эрхлэгч ашигтай ажиллах, иргэд ажлын байртай болох нь чухал асуудал юм.

Ингэснээр улсын экспортын барааны нэр төрөл нэмэгдэх, үндэсний үйлдвэрлэгч хөгжих боломж бүрдэх юм.

Чөлөөт бүсийг байгуулахад төрөөс бизнесийг дэмжих зорилгоор нээлттэй, ил тод, шударга өрсөлдөөнд суурилсан байх, чөлөөт бүс байрлах бүс нутагт авто зам, төмөр зам,

нисэх онгоцны буудал зэрэг шаардлагатай дэд бүтэцтэй байх буюу эдгээр дэд бүтцийг хөгжүүлэх боломжтой байх, чөлөөт бүсэд ашиглах усны нөөц, эрчим хүчний хангамжтай байх, хот байгуулалтын норм, дүрэм, стандарт, орон зайн нөхцөлийг хангасан байх, чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгж, байгууллага итгэл үнэмшилтэй ажиллах таатай орчин, нөхцөл бий болгох, байгаль орчинд ээлтэй байх, бүс нутгийн тогтвортой хөгжил, орон нутгийн эдийн засгийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, мэргэжлийн ажилтныг бэлтгэх нарийвчилсан төлөвлөгөөтэй байх зарчим, нөхцөлийг баримтлахаар, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт "Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана" гэж[16] тусгасан нь бодлогыг тодорхой, заавал хэрэгжүүлэх ажил гэж үзэн үйл ажиллагааг эрчимжүүлэхээр төлөвлөсөн боловч одоогоор хуулийн зорилго болон засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна.

Засгийн газар 2020 он хүртэл үлдсэн хугацаандаа үйл ажиллагааг эхлүүлэх боломж байж болох боловч өнөөгийн улс төрийн байдал, засгийн газрын үйл ажиллагаа явуулах эрх зүйн чадамжийг харахад бодит ажил хэрэг болох магадлал тун бага байна.

Чөлөөт бүсийг байгуулахад их хэмжээний хөрөнгө оруулалт, тогтвортой хэрэгжих төрийн зөв бодлого, оролцоо маш чухал үүрэгтэй юм.

Эрх зүйн орчныг бүрдүүлэх нь хангалтгүй бөгөөд түүнийг хэрэгжүүлэх засгийн газрын үүргээ гүйцэтгэх байдлаас хамаарч хөгжлийн тулгуур болох бизнесийн оролцоог хангах явдал төрийн бодлогоос шалтгаалдаг. Тийм ч учраас тухайн чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгжүүдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон гаалийн хялбарчилсан горимыг санал болгодог.

Тухайлбал: Чөлөөт бүсийн тухай хуулийг 2015 онд шинэчлэн найруулахдаа эрх зүйн орчныг таатай болгох, зорилгоор зорчигчийн худалдан авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийхээр, хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргах бараанд тарифын бус хязгаарлалт тогтоохгүй байхаар, барааг хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийхээр, чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсэн бол ажлын байрын төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөхөөр, чөлөөт бүсэд ажиллаж байгаа хуулийн этгээд өөрийн ажилтныг чадваржуулах, мэргэшүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн тохиолдолд зардлыг тухайн жилийн татвар ногдох орлогоос хасаж тооцохоор зохицуулсан.

Мөн чөлөөт бүсэд татварын цөөнгүй хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлэхээр тусгасан нь ололтой боловч эрх зүйн зохицуулалтыг үр нөлөөг дүгнэхэд цаг хугацааны хувьд эрт байна.

Монгол Улс бизнесийн үйл ажиллагаа явуулахад бизнес эрхлэлтийн үзүүлэлт бүс нутгийн хэмжээнд нэлээд доогуур байр эзэлсэн нь улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хямрал, бизнесийн таатай орчин сайн бүрдэж чадаагүй, тодорхой хэмжээний

[16] Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2 дугаар бүлэг.

хүндрэл бэрхшээл байгааг илтгэж байгаа ба дэлхийн банкны хил дамнасан худалдааны үзүүлэлтээр 2017 онд 103 дугаар байрт жагссан.

Тус үзүүлэлт нь тухайн улсын гадаад худалдааны гол хилийн боомтууд дээр худалдааны үйл ажиллагаанд хир хүндрэл гардаг, мөн хилийн худалдааны орчин хир байгааг дүгнэхэд чиглэдэг. 2016 онд 74 дүгээр байрт орж байсан үзүүлэлт Монгол Улс бүс нутгийн хэмжээд хил дамнасан худалдааны үзүүлэлтээр дундаж үзүүлэлттэй байна.

Монгол Улсын хууль тогтоомж, хилийн хяналт болон авто зам, төмөр замын дэд бүтэц буюу тээвэр логистикийн бүтцийн хөгжил сул, гааль, мэргэжлийн хяналт, гадаад худалдааны бусад хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хүнд суртал голлох нөлөө үзүүлсэн гэж дүгнэсэн.

Тиймээс цаашид чөлөөт бүсийг хөгжүүлэхэд төрийн зүгээс дэд бүтцийг хөгжүүлэх болон байгууллагуудын үйл ажиллагааг хэрэглэгч төвтэй болгоход анхаарч ажиллах шаардлагатай байна. Чөлөөт бүсүүдийг байгуулснаас хойш улсын төсвөөс 35 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

Үүний 77 хувийг “Алтанбулаг” чөлөөт бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд зарцуулсан байна. “Алтанбулаг” чөлөөт бүсийг анх худалдааны чиглэлээр байгуулсан ба 2014 оны 06 дугаар сарын 22 нээгдэн үйл ажиллагааг нь эхлүүлэхэд чөлөөт бүсийн харуул, хамгаалалтын байгууламж, түр цахилгаан хангамж, бүсийн доторх цэвэр, бохир усны шугам хоолой, усан сан, цэвэр усны эх үүсвэрийн шугам хоолой, үерийн хамгаалалтын далан, шалган нэвтрүүлэх байр, гаалийн хяналтын талбай зэрэг нь ашиглалтад орсон.

Алтанбулаг чөлөөт бүсэд бүртгэлтэй нийт 105 аж ахуйн нэгжээс 97 аж ахуйн нэгж газар эзэмшүүлэх болон хөрөнгө оруулалтын гэрээг шинэчлэн байгуулж, хамтран ажиллах гэрээгээр 8 аж ахуйн нэгж бүртгэгдсэн. 2016 онд 16 аж ахуйн нэгжийн газрын төлбөр 24,6 сая төгрөгийг, 2018 оны 09 сарын байдлаар газрын төлбөрийн 25,6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн 14 бөгөөд тухайн бүсэд хэвийн үйл ажиллагаа эрхэлж буй 15 аж ахуй нэгж байна.

Энэ нь бизнес эрхлэх болон хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдсэн гэж хэлэхэд асуудалтайг илтгэж байгаа бөгөөд үйл ажиллагаа явуулах сонирхол аж ахуй нэгжүүдэд байгаа боловч ашиг орлого олох нөхцөл бүрдээгүйг улмаар ажлын байрыг нэмэгдүүлж, орон нутгийн хөгжилд томоохон ахиц дэвшил оруулахгүй байгаа нь эдийн засгийн үр өгөөжгүй байдлыг илтгэж байна.

Чөлөөт бүсийг байгуулагдах, үйл ажиллагаа эхлэхэд багагүй цаг хугацаа зарцуулж, эдийн засагт өөрийн үүргээ гүйцэтгэхэд дахиад хугацаа хэрэгтэй байгаагаас харахад эдийн засгийн үр ашиг хүртэх, байгуулсан зорилгоо биелүүлэх боломж ойрын хугацаанд бага байна гэж үзэж болохоор байна.

Энэ нь орон нутгийн хөгжил, төр хувийн хэвшлийн түншлэл болон зах зээлийн хүрээ гэсэн хүчин зүйлтэй салшгүй холбоотой юм.

Орон нутаг бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд тулгамдсан хамгийн түгээмэл бэрхшээл бол бүтээгдэхүүнийг худалдан авах, үйлчлүүлэх иргэд буюу зах зээл байхгүйтэй холбоотой.

Иймээс орон нутагт иргэдийг ажиллах, амьдрах боломжийг бүрдүүлэх, шаардлагатай дэд бүтцийг бий болгох, бүсийн нөөц боломжид нь тулгуурлан тодорхой чиглэлүүдээр хөгжүүлэх замаар нийслэлийн төвлөрлийг сааруулах шаардлагатай байгааг илтгэж байна.

Мөн чөлөөт бүс дэх хөрөнгө оруулалтыг шат дараалан шийдэх, нэг чөлөөт бүсийнхээ хөрөнгө оруулалтыг асуудлыг цогцоор нь төр, хувийн хэвшлийн оролцоотой шийдвэрлэх нь илүү оновчтой юм.

Хөрөнгө оруулалтын үр дүнд бүтээн байгуулалт, үйл ажиллагаа нь өргөжин тэлэх нь ойлгомжтой боловч зарцуулалтыг хянах, богино хугацаанд чөлөөт бүсийг байгуулж үйл ажиллагааг явуулах шаардлагатай байна.

Учир нь өнгөрсөн хугацаанд нэг засгийн газраас нөгөө засгийн газарт эрх мэдэл шилжих явцад зайлшгүй шаардлагатай бүтээн байгуулалтын ажил хоцорч байсныг анхаарах хэрэгтэй. Чөлөөт бүсийн хөгжилд хөрөнгө оруулагч чухал үүрэгтэй бөгөөд дэлхийн ихэнх улсууд чөлөөт бүсийг хувийн хэвшилтэй хамтран байгуулдаг нь сонирхолтой.

Хөрөнгө оруулагч нийтлэг хүчин зүйлээс гадна чөлөөт бүсэд хөрөнгө оруулалт хийхдээ улс төрийн болон эдийн засгийн тогтвортой байдал, хувийн өмчид хандах соёл, олон улсын гэрээнд хандах уламжлал зэргийг харгалзан шийдвэрээ гаргадаг байна.

Сүүлийн жилүүдэд улс төрийн болон эдийн засгийн тогтворгүй байдал хөрөнгө оруулагчдыг итгэлийг сулруулж хувийн өмчид халдах тохиолдол гарч байгаа нь чөлөөт бүсийг хөгжүүлэхэд саад болж буй нэгэн бэрхшээлтэй тал болж байх магадлалтай юм.

Чөлөөт бүс байгуулсан зорилго нь улсынхаа нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийн байгаль орчин, хүн ам, түүхий эдийн нөөц, газар зүйн байрлал, зам харилцааны боломжийг зохистой ашиглан, хөрөнгө оруулагчдыг татах, дэвшилтэд технологи оруулах замаар эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх боловч бодит байдал дээр аль чөлөөт бүсэд бүртгэлтэй нь олон, үйл ажиллагаа явуулж байгаа нь цөөхөн байгаа нь аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулах орчин бүрдээгүй, хөрөнгө оруулагч оруулсан хөрөнгөө эрсдэлгүй өсгөх боломж хязгаарлагдмал байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.

“Алтанбулаг” чөлөөт бүсийн захирагчийн албаны гаргасан ажлын тайланд эрх зүйн зохицуулалтын хувьд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон урамшууллыг тодорхой хэмжээнд шийдэж өгсөн боловч тухайн бүсийг дагасан хотжилт, бүтээн байгуулалт орхигдсоноос үр ашиггүй байх нөхцөл үүсэж байгааг харгалзан үзэх шаардлага байна гэжээ.

Мөн “Хүнсний тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Хүнсийг зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд, экспортолж, импортолно” гэсэн заалтыг Гаалийн байгууллага баримтлан ажилласнаар “Чөлөөт бүсийн тухай” хуулийн 16.1.4. дахь заалт буюу зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх” гэсэн заалттай зөрчилдөж байгаа тул цаашид дээрх заалт хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Монгол Улсын хөрш орнуудтай хийх эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжин тэлж хамтарсан томоохон төсөл, хөтөлбөрүүд батлагдсан боловч улс төрийн тогтворгүй байдал болон гадаад бодлогын залгамж чанаргүй байдал зэрэг хүчин зүйл нь цаг хугацаа алдах,

эдийн засгийн үр ашигт сөргөөр нөлөөлөх үр дагавартай тул улс төрийн тогтвортой байдал чөлөөт бүсийн хөгжилд ч чухал асуудал гэдгийг анхаарах шаардлагатай юм.

## НЭГДСЭН ДҮГНЭЛТ:

1.Хил орчмын нутаг дэвсгэрт болон эдийн засгийн чөлөөт бүсийн орчинд үйл ажиллагаа, үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгжүүд, зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн эрс нэмэгдэж, хоёр улсын иргэдийн хооронд үүсэх харилцаа нээлттэй болсноор улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан бараа бүтээгдэхүүн, зэвсэг, сум галт хэрэглэл, хар тамхи, мансууруулах төрлийн бодис, хүний наймаа зэрэг хууль бус үйл ажиллагаа эрчимжих хандлагатай байгаа тул эдгээр гэмт хэрэг, зөрчлийн асуудлыг шийдвэрлэхэд холбогдох хууль тогтоомж, гэрээ хэлэлцээрүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага бий болсон.

2.Монгол Улсын чөлөөт бүсийн тухай хууль 2015 онд батлагдаж, уг хуулийн шинэчилсэн найруулгын наймдугаар бүлгийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт ***“хилийн зурвас дахь чөлөөт бүсийн харуул, хамгаалалтын үүргийг хил хамгаалах байгууллага, бусад чөлөөт бүсийн харуул, хамгаалалтын үүргийг холбогдох байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр тус тус гүйцэтгэнэ”*** гэж заасны дагуу Замын-Үүд”-ийн чөлөөт бүсийн харуул, хамгаалалтыг Хилийн цэргийн 0108 дугаар ангийн шалган нэвтрүүлэх бэлтгэл заставын, “Алтанбулаг”-ийн чөлөөт бүсийн харуул, хамгаалалтыг Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн Бүргэдэй-Уулын хилийн заставын хүч хэрэгсээр тус тус зохион байгуулж байгаа бөгөөд дээрх хилийн салбаруудын алба хаагчид нь зөвхөн чөлөөт бүсийн хамгаалалтад үүрэг гүйцэтгэх биш анги, салбаруудын өдөр тутмын үйл ажиллагаанд болон хил хамгаалатад оролцож байна.

Энэ нь чөлөөт бүсийн харуул, хамгаалалтыг зохион байгуулахад хүч хэрэгсэл хүрэлцэхгүй болох гол шалтгаан болж байгаа бөгөөд нэгэнт Хил хамгаалах байгууллага чөлөөт бүсийн харуул, хамгаалалтыг хариуцах талаар хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд Чөлөөт бүсийн харуул, хамгаалалтыг хариуцсан тусгай үүрэг бүхий хилийн салбарыг бий болгож, тэнд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын албаны ачаалал, сонор сэрэмжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага бий болсон.

Чөлөөт бүсийн хашааг инженерийн байгууламжаар төхөөрөмжлөх (Мөр хянах зурвас, дохиолол хяналтын систем, гэрэлтүүлгийн хэрэгсэл, хяналтын камер, зам талбай), хянах манааны байрнуудыг засварлаж, албанд ашиглах, болзошгүй чиглэлүүдэд албаны нохой байрлуулах байнгын болон гүйдэг уяа хийх, чөлөөт бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг уналгын техник хэрэгслээр хангах зэрэг ажлуудыг цаг алдалгүй хийж гүйцэтгэх нь зүйтэй гэж үзсэн.

